




ГОВИЙН ОЮУ  
ХӨГЖЛИЙГ  
ДЭМЖИХ САН

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ  
ДЭМЖИХ САН”

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



2021



ГОВИЙН ОЮУ  
ХӨГЖЛИЙГ  
ДЭМЖИХ САН

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*



# АГУУЛГА

Удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ.....	2
“Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”, хөрөнгө оруулагч “Оюу толгой” компани .....	3-4
<b>Говийн Оюу хөгжлийг дэмжих сангийн засаглал .....</b>	<b>5-6</b>
Сангийн Удирдах зөвлөл .....	5
Харилцааны хороо.....	6
<b>Говийн Оюу хөгжлийг дэмжих санд хүлээн авах төсөл, хөтөлбөрийн саналын чиглэл .....</b>	<b>7-10</b>
Санхүүжилт олгох үндсэн чиглэл .....	7
Санхүүжилт олгох үйл явц .....	8-9
Сангийн санхүүжилтийн гүйцэтгэл .....	10
<b>Ирээдүй хойч үеийн төлөө сан .....</b>	<b>11-19</b>
“Говийн оюу-Бизнес боломж” бизнесийн бичил зээл.....	11-13
Ирээдүй хойч үеийнхэнд зориулсан хадгаламж.....	14
“Говийн Оюу-Оюутны тэтгэлэг” хөтөлбөр.....	15-19
<b>Хандив, тусламж .....</b>	<b>20-21</b>
<b>Батлагдсан төсөл хөтөлбөрийн хэрэгжилт .....</b>	<b>22-64</b>
Сангийн Удирдах зөвлөлөөс баталсан төсөл хөтөлбөрүүд.....	22-23
Сангийн 2021 онд Өмнөговь аймагт оруулсан хөрөнгө оруулалт .....	24-26
НҮБ-ийн тогтвортой хөгжлийн зорилтуудад ХДС-ийн оруулсан хувь нэмэр .....	27
Сангийн 2021 оны онцлох үйл явдал.....	28
Удирдах зөвлөлөөс Сангийн 2021 оны санхүүжилтийн эх үүсвэрийн хуваарилалт .....	29-33
Сангаас батлагдсан төсөл хөтөлбөрийн хэрэгжилт .....	34-64
2021 онд батлагдсан төсөл хөтөлбөрийн хэрэгжилт.....	34-47
Он дамжин хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд.....	48-64
<b>Квотын санхүүжилт, 2021 оны квотын санхүүжилтээр хэрэгжих төсөл хөтөлбөр.....</b>	<b>65-155</b>
Квотын санхүүжилт, зорилго .....	65-66
Ханбогд суманд хуваарилагдсан квотын санхүүжилт, батлагдсан төсөл, хөтөлбөр.....	67-85
Манлай суманд хуваарилагдсан квотын санхүүжилт, батлагдсан төсөл, хөтөлбөр .....	86-100
Баян-Овоо суманд хуваарилагдсан квотын санхүүжилт, батлагдсан төсөл, хөтөлбөр.....	101-106
Даланзадгад суманд хуваарилагдсан квотын санхүүжилт, батлагдсан төсөл, хөтөлбөр ...	107-120
Баяндалай суманд хуваарилагдсан квотын санхүүжилт, батлагдсан төсөл, хөтөлбөр .....	121-128
Мандал-Овоо суманд хуваарилагдсан квотын санхүүжилт, батлагдсан төсөл, хөтөлбөр ..	129-134
Сэврэй суманд хуваарилагдсан квотын санхүүжилт, батлагдсан төсөл, хөтөлбөр .....	135-139
Булган суманд хуваарилагдсан квотын санхүүжилт, батлагдсан төсөл, хөтөлбөр .....	140-145
Цогт-Овоо суманд хуваарилагдсан квотын санхүүжилт, батлагдсан төсөл, хөтөлбөр .....	146-153
Номгон суманд хуваарилагдсан квотын санхүүжилт, батлагдсан төсөл, хөтөлбөр.....	154-155
<b>Төсөл хөтөлбөрүүдээс үр шим хүртэгчдийн сэтгэгдэл .....</b>	<b>156</b>
<b>Сангийн ил тод байдал.....</b>	<b>157</b>
<b>Сангийн хяналт, шинжилгээ-үнэлгээ.....</b>	<b>158-165</b>
<b>Харилцагч байгууллагууд.....</b>	<b>166-169</b>
<b>Санхүүгийн тайлан .....</b>	<b>170-173</b>



## САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

*“Оюу толгой” компанийн Уурхайн үйл ажиллагаа эрхэлсэн захирал,  
“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн дарга*

**Эндрью Уилсон**

Та бүхэндээ “Оюу толгой” компанийн хөрөнгө оруулалттай “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн 2021 оны үйл ажиллагааны тайланг хүргэж байгаадаа баяртай байна.

“Оюу толгой” компани Өмнөговь аймаг, тус аймгийн Ханбогд сумтай байгуулсан “Хамтын ажиллагааны гэрээ”-ний дагуу 2015 оноос хойш жил бүр таван сая ам.долларын санхүүжилтийг “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-аар дамжуулан Өмнөговь аймгийн тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэн ажиллаж байна.

Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд бид 2021 оны байдлаар 82.3 тэрбум төгрөгөөр 304 төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлжээ. Үүнд зургаан цэцэрлэг, хоёр сургууль, гурван эмнэлэг, спорт заал, уурын зуух зэрэг нийгмийн дэд бүтцийн томоохон төслүүдээс гадна иргэдэд амьдралын чанарыг сайжруулахад чиглэсэн төрөл бүрийн сургалт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, байгаль орчныг хамгаалах, хөдөө аж ахуй, орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн хөтөлбөрүүдийг дэмжиж ажиллалаа.

Өнгөрсөн онд орон нутгийн иргэдийн санаачилгад тулгуурлан “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” Даланзадгад сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Цогт-Овоо сумын эрүүл мэндийн төвийн барилга, “Бэлчээр усжуулалтын хоёрдугаар аян”, гурван жил

дараалан хэрэгжиж буй “Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих хамтарсан хөтөлбөр”, Даланзадгад сумын 1200 хүүхдийн сургууль, Даланзадгад сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн төслүүдийг санхүүжүүлсэн билээ.

“Говийн Оюу” оюутны тэтгэлэг хөтөлбөрийг сүүлийн зургаан жилийн хугацаанд хэрэгжүүлэхдээ Өмнөговь аймагт нэн хэрэгцээтэй мэргэжлээр суралцаж буй 324 оюутанд 800 сая төгрөгийн сургалтын тэтгэлэг, “Говийн Оюу-Бизнес боломж” бичил зээлийн хөтөлбөрийн хүрээнд 51 бизнес эрхлэгчдэд 1.4 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож, Өмнөговьчуудын амьдралд иүүд үр өгөөжөө өгөх олон ажлыг хийж байгаадаа “Оюу толгой” компани болон “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн нэрийн өмнөөс туйлын баяртай байгаагаа дуулахаад таатай байна.

Өмнөговь аймгийн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажил, 2021 оны зун тохиолдсон гэнэтийн үер усны гамшигийн хохирлыг арилгах, цар тахлыг хохирол багатай даван туулах зэрэг нэн яаралтай ажлуудад “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” 866.5 сая гаруй төгрөгийн хандив, тусламжийг үзүүлээ. Өмнийн говиос дэлхийн хэмжээний бүтээн байгуулалтыг хамтран бүтээлцэж буй Өмнөговьчуудаа талархаж ажлын амжилт хүсье!



## ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН

2015 оны 04 сарын 22-ны өдөр Өмнөговь аймаг, тус аймгийн Ханбогд сум болон “Оюу толгой” компанийн хооронд байгуулсан Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийг хангах үүднээс “Оюу толгой” компани нь “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” Төрийн бус байгууллагыг 2015 оны 09 сарын 25-ны өдөр үүсгэн байгуулсан.

Уг гэрээний 8.3-т заасны дагуу “Оюу Толгой” компани нь жил бүр 5 сая ам.доллар түүнтэй тэнцэх төгрөгийн санхүүжилтийг “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-д олгодог. “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” нь Хамтын ажиллагааны гэрээ, түүний сэдэвчилсэн хавсралтаар зохицуулсны дагуу орон нутгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахад чиглэгдсэн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэн ажиллаж байна.

## “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

### АЛСЫН ХАРАА

Итгэлцэлд суурилсан  
сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид  
хамтдаа бүтээнэ

### ЭРХЭМ ЗОРИЛГО

Өмнөговьчуудын сайн  
сайхан амьдралыг  
дэмжсэн хамтын  
хөгжлийн санаачилгыг  
санхүүжүүлэгч сан байна

### ЭРХЭМЛЭХ ЗАРЧИМ

- Авилгаас ангид байх
- Хувийн ашиг сонирхлоос ангид байх
- Үндэслэл, тооцоо баримт нотолгоонд суурилсан шийдвэр гаргах
- Аливаа ялгаварлалгүйгээр нутгийн иргэдийн шударга оролцоог дэмжих, тэгш боломжоор хангах
- Бүх төслүүд Сангийн эрхэм зорилготой уялдсан байх
- Батлагдсан төслүүд тохиролцсон үр дүндээ хүрдэг байх





*Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ “ОЮУ ТОЛГОЙ” КОМПАНИЙН ТУХАЙ

“Оюу толгой” компани нь Монгол Улсын Засгийн газар буюу “Эрдэнэс Оюу Толгой” компани (34 хувь), Канад Улсын “Туркойз Хилл Ресурс” (66 хувь) компанийн хамтран эзэмшдэг Монголын компани юм. “Туркойз Хилл Ресурс” компани Торонто, Нью-Йоркийн хөрөнгийн бирж дээр хувьцаагаа гаргасан, Рио Тинто компанийн шууд бус эзэмшлийн компани юм.

Оюу толгой уурхай нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт Улаанбаатар хотоос 550 км зайд байрлах зэс, алтны уурхай юм.

Аюулгүй ажиллагааг эрхэмлэн зэс, алт бүхий ашигт малтмалыг олборлон баяжуулж, дэлхийн зах зээлд гарган нэмүү өртөг бий болгон, Монгол Улсын хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулж байна.

“Оюу толгой” компани нь 2015 оны 4 дүгээр сарын 22-нд Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль болон бусад хууль тогтоомж, тус компанийн хөрөнгө оруулагч Рио Тинто компанийн олон улсад мөрддөг стандарт журмын дагуу Хамтын ажиллагааны гэрээг Оюу толгойн уурхай үйл ажиллагаагаа явуулж байгаа Өмнөговь аймаг болон тус аймгийн Ханбогд сумтай байгуулсан юм. Энэ нь Өмнөговь аймаг төдийгүй Монгол улсын хэмжээнд уул уурхайн компани нутгийн захиргааны байгууллагатай иж бүрэн Хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж буй анхны жишээ болсон билээ.

### АЛСЫН ХАРАА

Эрдэс баялгаас эрдэм мэдлэг, ур чадвар, үнэт зүйлс бүтээлцэнэ



### ҮНЭТ ЗҮЙЛС

- Аюулгүй ажиллагаа
- Хамтын зүтгэл
- Хүндэтгэл
- Ёс зүй
- Төгөлдөршил



### ЭРХЭМЛЭХ ЗАРЧИМ

Аюулгүй ажиллагааг эрхэмлэж, дэлхийд өрсөлдөхүйц зэсийн үйлдвэрлэлийг цогцлоож, Монгол Улсын хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах





## САНГИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Сангийн Удирдах зөвлөл нь Говийн Оюу хөгжлийг дэмжих сангийн эрх барих дээд байгууллага юм. Удирдах зөвлөл 7 гишүүнээс бүрдэнэ. Өмнөговь аймаг болон Ханбогд сум хамтран орон нутгийн төлөөлөл 3 гишүүнийг нэр дэвшүүлж, “Оюу толгой” компаниас 4 гишүүнийг нэр дэвшүүлэн Удирдах зөвлөлийг бүрдүүлдэг.

Сангийн удирдлагыг сайжруулах болон Хамтын ажиллагааны гэрээнд нийцэж ажиллахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Сангийн Дүрмийн дагуу удирдах зөвлөлд зөвлөгөө өгөх, сангийн дүрмийн хэрэгжилтийг сахиулах, хөндлөнгийн хяналт тавих эрх бүхий хараат бус Итгэмжлэгдсэн зөвлөх сонгогдон ажиллаж байгаа.

Гүйцэтгэх захирлаар ахлуулсан 4 хүний бүрэлдэхүүнтэй ажлын алба өдөр тутмын үйл ажиллагааг эрхэлдэг.

### САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД-2021 ОН



Удирдах зөвлөлийн дарга/  
ОТ Уурхайн үйл ажиллагаа  
эрхэлсэн захирал

**Эндрью Уилсон**



Удирдах зөвлөлийн  
гишүүн / Өм.аймгийн  
ИТХ-ын дарга

**Б.Бадраа**



Удирдах зөвлөлийн  
гишүүн/ Өм.аймгийн  
Засаг дарга

**Р.Сэддорж**



Удирдах зөвлөлийн  
гишүүн / Өм.аймгийн  
ИТХ-ын төлөөлөгч

**Ж.Занабазар**



Удирдах зөвлөлийн  
гишүүн / ОТ Хууль,  
эрх зүйн асуудал  
хариуцсан захирал

**Д.Амарбаясгалан**



Удирдах зөвлөлийн  
гишүүн /ОТ  
Хангамжийн хэлтсийн  
Ерөнхий менежер

**Деррик Хансен**



Удирдах зөвлөлийн  
гишүүн /ОТ Орон  
нутгийн харилцааны  
Ерөнхий менежер

**Г.Сугар**

### ХАРИЛЦААНЫ ХОРОО

Сангийн Харилцааны хороо нь Хамтын ажиллагааны гэрээний дагуу байгуулагдсан Өмнөговь аймаг, “Оюу толгой” компани болон сангаас хамтран ажиллах Түншлэгч сумдын харилцаа хамтын ажиллагааг зохицуулах, дэмжлэг үзүүлэх, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих зорилготой бүтэц бүрэлдэхүүн юм. Харилцааны хороо 13 гишүүнээс бүрдэнэ.





*Итгэцлэг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

Өмнөговь аймаг болон Ханбогд сум хамтран нэр дэвшүүлж орон нутгийн 9 төлөөлөгчийг томилж ажиллуулдаг. “Оюу толгой” компанийн төлөөлөл 4 гишүүнийг “Оюу толгой” компаниас томилон ажиллаж байна.

Оюу толгой компанийн төлөөллийг Хангамж, хүний нөөц сургалт, байгаль орчин, орон нутгийн харилцаа гэсэн орон нутагтай илүү хамтран ажиллах шаардлагатай хэлтэс албадын төлөөлөл байдаг бол орон нутгийн зүгээс сумдын удирдлага, аймгийн салбар хариуцсан хэлтэс, агентлагийн удирдлага иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс бүрдэн ажиллаж байна.

## ХАРИЛЦААНЫ ХОРООНЫ ГИШҮҮД-2021 ОН

### ХАРИЛЦААНЫ ХОРООНЫ ДАРГА НАР



**Ч.Баяржаргал**

Өм. Аймгийн нийгэм эдийн засгийн асуудал хариуцсан Засаг даргын орлогч



**О.Цэрэннадмид**

“Оюу толгой” компанийн Орон нутгийн харилцааны менежер

### ХАРИЛЦААНЫ ХОРООНЫ ГИШҮҮД



**Ц.Амартөгс**

Өм.аймгийн Засаг даргын тамгын газрын дарга



**О.Эрдэнэ-Өрнөх**

Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга



**Ц.Бадамцэрэн**

Нийгмийн бодлогын хэлтсийн дарга



**О.Мандахбаяр**

Баян-Овоо сумын Засаг дарга



**П.Баасанцогт**

Манлай сумын Засаг дарга



**Х.Нэхийт**

Ханбогд сумын Засаг дарга



**В.Мөнхбат**

Өм.ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгч



**Б.Энхмөнх**

Даланзадгад сумын иргэний төлөөлөл



**Д.Амартүвшин**

“Оюу толгой” компанийн Хангамж, худалдан авалтын газрын менежер



**Н.Эрдэнэбаяр**

“Оюу толгой” компанийн байгаль орчны асуудал хариуцсан менежер



**М.Ариунтунгалаг**

“Оюу толгой” компанийн хүний нөөцийн ахлах мэргэжилтэн



## “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-Д ХҮЛЭЭН АВАХ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН САНАЛЫН ЧИГЛЭЛ, ШАЛГУУР, САНХҮҮЖИЛТ ОЛГОХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ХАРИЛЦААНЫ ХОРОО,  
ГОВИЙН ОЮУ ХДС, ТӨСӨЛ САНААЧЛАГЧ

ҮНДСЭН 7 СЭДЭВЧИЛСЭН ЧИГЛЭЛЭЭР ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР  
САНХҮҮЖҮҮЛЖ ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН  
ЗАСГИЙН ХӨГЖИЛД ХУВЬ НЭМЭР ОРУУЛНА.

АШГИЙН БУС НИЙГЭМД ЧИГЛЭСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН  
САНАЛ АВАХ ЧИГЛЭЛҮҮД

САНХҮҮЖИЛТИЙН ЧИГЛЭЛҮҮД

Усны менежмент

Байгаль орчны менежмент  
(нөхөн сэргээлт, био-тархалт,  
экологийн тэнцвэр)

Уламжлалт мал аж ахуй &  
Бэлчээрийн Менежмент

Үндэсний түүх, Соёл &  
Аялал жуулчлал

Нийгмийн суурь үйлчилгээ  
(эрүүл мэнд, боловсрол, ажил  
мэргэжил баримжаа олгох  
сургалт & ажил эрхлэлт)

Нийгмийн дэд бүтэц &  
Хөрөнгө оруулалтын төсөл

Орон нутгийн бизнес  
хөгжил & бараа үйлчилгээ  
худалдан авалт

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЖИЖИГ ДУНД БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ-  
БИЗНЕСИЙН БИЧИЛ-ЗЭЭЛ

ХААН БАНКААР ДАМЖУУЛАН БИЗНЕСИЙН  
ХӨНГӨЛӨЛТТЭЙ, БИЧИЛ ЗЭЭЛ ОЛГОЖ БАЙНА



## “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН САНХҮҮЖИЛТ ОЛГОХ ҮЙЛ ЯВЦ

### ХДС-ИЙН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ЧИГЛЭЛ, ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

#### НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ

##### Төслийн санал хүлээн авах

- Өмнөговь аймгийн үндсэн чиглэлтэй уялдсан байна

##### Нөхцөл байдлын шинжилгээ хийх

- Санал ХДС-ийн бичиг баримтуудад нийцсэн байна

##### Санхүүжилтийн шийдвэр гаргах

- Харилцааны хороо, Удирдах зөвлөлөөр батлуулна

##### Төслийн хэрэгжилт, хяналт, хаалт

- Төслийн хэрэгжилт, хяналт, төслийн хаалт, Захиалагч тогтвортой байдлыг хангана

#### ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

##### Төслийн санал хүлээн авах

- ХДС 3 жилийн үндсэн чиглэлээ боловсруулж батлуулна
- Жил бүр үндсэн чиглэл, аймгийн хөгжлийн бодлоготой уялдсан төслийн саналыг АЗДТГ-аас хүлээн авна

##### Санхүүжилтийн шийдвэр гаргах

- Харилцааны хороо, Удирдах зөвлөлөөр батлуулна

##### Төслийн хэрэгжилт, хяналт, хаалт

- Төслийн хэрэгжилт, хяналт, төслийн хаалт, Захиалагч тогтвортой байдлыг хангана

#### САНХҮҮЖИЛТИЙН КВОТ


- Өмнөговь аймгийн ЗДТГ-аас ХДС-д уул уурхайн үйл ажиллагаа явуулахгүй байгаа сумдын нэрсийг жил бүр ирүүлнэ
- Санхүүжилтийн квотоор хийсэн ажлыг жил бүр дүгнэнэ
- Түншлэгч болон уул уурхайгүй сумдын Засаг дарга нартай гэрээ байгуулна

##### Төслийн хэрэгжилт, хяналт, хаалт

- Төслийн хэрэгжилт, хяналт, төслийн хаалт, Захиалагч тогтвортой байдлыг хангана



## “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН ЗОРИЛТОТ ХАМРАХ НУТАГ ДЭВСГЭР



### Зорилтот газар

- |   |                     |   |
|---|---------------------|---|
| 1 | ОТ Түншлэгч сум-4   | Эхний ээлжид анхаарал хандуулах                                     |
| 2 | Уул уурхайгүй сум-7 | 2 дахь ээлжид анхаарал хандуулах                                    |
| 3 | Бусад сум-4         | Хамтарсан санхүүжилтээр болон бүх сумыг хамарсан төсөл санхүүжүүлэх |




Итгэцлэгд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

## САНХҮҮЖИЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛ- 2015-2021



“ОЮУТОЛГОЙ” ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ /2015-2021/  
**82.3 ТЭРБУМ ₮/32.97 САЯ \$**




Төсөл хөтөлбөрийн  
санхүүжилт




Ирээдүй хойч үеийн  
төлөө сан

- Хөнгөлөлттэй зээл
- Оюутны тэтгэлэг
- Ирээдүй хойч үед зориулсан хадгаламж



Хандив




Сангийн үйл  
ажиллагаа


## САНХҮҮЖИЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛ-2021 ОН



“ОЮУТОЛГОЙ” ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ /2021/  
**16.25 ТЭРБУМ ₮/5.7 САЯ \$**




Төсөл хөтөлбөрийн  
санхүүжилт




Ирээдүй хойч үеийн  
төлөө сан

- Хөнгөлөлттэй зээл
- Оюутны тэтгэлэг
- Ирээдүй хойч үед зориулсан хадгаламж



Хандив



Сангийн үйл  
ажиллагаа





## “ИРЭЭДҮЙ ХОЙЧ ҮЕИЙН ТӨЛӨӨ САН”

Говийн оюу хөгжлийг дэмжих сан нь Хамтын ажиллагааны гэрээний зорилгод хүрч ажиллахын тулд Санхүүжилтийн удирдамжид заасны дагуу жилийн нийт санхүүжилтийнхээ 6%-ийг Өмнөговийн ирээдүй хойч үеийнхэнд зориулан “Өмнөговийн ирээдүй хойч үеийн төлөө сан” нэрээр хуваарилдаг. Энэхүү хойч үедээ зориулсан санд хуваарилсан санхүүжилтийг “Говийн оюу-Бизнес боломж” бизнесийн бичил зээлийн хөтөлбөр, тусгай нөхцөлт Хадгаламж, “Говийн оюу-Оюутны тэтгэлэг” гэсэн үндсэн гурван хэлбэрээр хуваарилан зохих журмын дагуу зарцуулж байна.

## “ГОВИЙН ОЮУ-БИЗНЕС БОЛОМЖ” БИЗНЕСИЙН БИЧИЛ ЗЭЭЛ



ГОВИЙН ОЮУ  
ХӨГЖЛИЙГ  
ДЭМЖИХ САН



**ХААН БАНК**

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь 2016 оноос хойш “Говийн оюу – Бизнес боломж” нэртэй орон нутгийн жижиг дунд бизнесийг дэмжих санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд уг бизнесийн бичил зээлийг Хаан банкаар дамжуулан олгож байна. 2016-2021 онд Өмнөговь аймгийн 51 бизнес эрхлэгч иргэдэд 1.4 тэрбум төгрөгийн зээл олгосон.

### Зээл авсан бизнес эрхлэгчдийн харьяалал

Сум	Зээлийн тоо	Олгосон зээл /өссөн дүнгээр/
Даланзадгад	36	1,049,000,000
Ханбогд	10	177,000,000
Манлай	2	45,020,000
Мандал-Овоо	1	28,000,000
Булган	1	37,500,000
Ханхонгор	1	48,824,300
<b>Нийт</b>	<b>51</b>	<b>1,385,344,300</b>



ҮЙЛДВЭРЛЭЛ-29

769.5  
сая ₮



ҮЙЛЧИЛГЭЭ-16

470.8  
сая ₮






ХУДАЛДАА-6

145  
сая ₮




*Итгэцлэгд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## “ГОВИЙН ОЮУ-БИЗНЕС БОЛОМЖ” ХӨНГӨЛӨЛТТЭЙ БИЧИЛ ЗЭЭЛИЙН ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАН БИЗНЕСИЙН ЗЭЭЛ АВСАН БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ДУРДВАЛ:









## “ИРЭЭДҮЙ ХОЙЧ ҮЕИЙН ТӨЛӨӨ САН”-ИЙН ТУСГАЙ НӨХЦӨЛТ ХАДГАЛАМЖ

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь Өмнөговь аймгийн хүүхэд залуучуудад зориулан жил бүрийн нийт санхүүжилтийн 2%-ийг 10 жилийн хугацаатай хадгаламжид байршуулж байна. Уг хадгаламжийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр нээж одоогийн байдлаар 1.8 тэрбум төгрөг хуримтлуулаад байна.

## “ГОВИЙН ОЮУ- ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ” ХӨТӨЛБӨР


“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-аас Өмнөговь аймгийн ирээдүй хойч үеийн төлөө зориулан хэрэгжүүлдэг томоохон хөтөлбөрүүдийн нэг нь “Говийн оюу – Оюутны тэтгэлэг” хөтөлбөр юм. Уг хөтөлбөрийг 2021 онд 6 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна.

- Өмнөговь аймгийн ЗДТГ-аас Өмнөговь аймагт хэрэгцээтэй байгаа мэргэжлийн чиглэлийг санд ирүүлсний дагуу аймгийн ЗДТГ-ын боловсрол, хүний нөөцийн мэргэжилтнүүд, Ханбогд сумын төлөөлөл, “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн төлөөлөл болон хөтөлбөрийн удирдах байгууллагаар сонгогдсон “Говийн оюуны хөтөч” төрийн бус байгууллага, Өмнөговь аймагт боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн сонгон шалгаруулах хороо 2021-2022 оны хичээлийн жилд тэтгэлэгт хамрагдах оюутнуудыг сонгон шалгаруулсан.



- “Говийн оюу - Оюутны тэтгэлэг” хөтөлбөрийн хүрээнд 2021 онд магадлан итгэмжлэгдсэн дотоодын их, дээд сургуульд Өмнөговь аймагт дутагдалтай байгаа мэргэжлээр суралцаж байгаа 90 оюутанд тэтгэлэг олгосон.

Тэтгэлэг авсан оюутнуудыг сумдаар ангилсан байдал






“Говийн оюу - Оюутны тэтгэлэг” хөтөлбөрт 2016 онд 30, 2017 онд 57, 2018 онд 55, 2019 онд 45, 2020 онд 47, 2021 онд 90 оюутан тус тус хамруулсан бөгөөд 2016-2021 онд давхардсан тоогоор Өмнөговь аймгийн 324 оюутанд 800 сая төгрөгийн тэтгэлэг олгосон.


### “ГОВИЙН ОЮУ- ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ” ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДСАН ОЮУТНУУДЫН МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛ

#### 2016-2021 онд олгосон тэтгэлгийг мэргэжлээр ангилсан байдал, n=324



### 2020-2021 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД “ГОВИЙН ОЮУ-ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ” ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДСАН ТӨГССӨН ОЮУТНУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

#### Тэтгэлэгт хамрагдан төгссөн оюутнуудын мэдээлэл







Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

## “ГОВИЙН ОЮУ-ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ” ХӨТӨЛБӨРТ 2021 ОНД ХАМРАГДСАН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ОЮУТНУУД



**З.АРИУНЦЭЦЭГ**

АШУУИС-Их эмч



**А.НАНДИНЦЭЦЭГ**

ШУТИС-Нийгмийн  
ажилтан



**У.УЦЭДЭН-ИШ**

Эм зүйн ШУИС-  
Эмч-уламжлалт



**Х.НАМУУН**

ХҮИС-Сэтгэлзүйч



**Г.БЯЯРМАА**

ШУТИС-Барилгын  
инженер



**Д.МӨНГӨНСАР**

Мандах ИС-Мэдээллийн  
систем



**Г.ДАШЧИРЭВ**

МУБИС-Багш технологи



**Ё.ХОРОЛСҮРЭН**

ХААИС-Инженер-хүнсний  
технологич



**Г.НАНДИНБОЛОР**

АШУУИС-Эмч



**Б.МИНЖИНСОР**

ШУТИС-Нийгмийн  
ажилтан



**Э.СУГАРМАА**

ШУТИС-Барилгын  
инженер



**Ж.МӨНХСАЙХАН**

ШУТИС-Системийн  
аюулгүй байдал



**Б.ТАЙВАНЖАРГАЛ**

ХААИС-Малын эмч



**Б.НАРАНСОЛОНГО**

МУИС – Багш-Түүх  
нийгмийн ухаан



**О.УУЛСАНАА**

МУБИС-Нийгмийн  
ажилтан



**А.БЯМБАСҮРЭН**

АШУУИС-Эх баригч эмч



**О.ЭРДЭНЭЦЭЦЭГ**

МУИС-Программ хангамж



**М.МӨНХ-ЭРДЭНЭ**

МУИС-Түүхч



**Б.АЗЗАЯА**

МУБИС-Англи хэлний  
багш



**Р.МАРАЛМАА**

АШУУИС-Эм зүйч



“ГОВИЙН ОЮУ-ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ”  
ХӨТӨЛБӨРТ 2021 ОНД ХАМРАГДСАН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ОЮУТНУУД



**Б.АРИУНЖАРГАЛ**

МУБИС-Англи хэлний багш



**Т.МИШЭЭЛ**

АШУУИС-Эрүүл ахуйч



**А.БЯМБАБАЯР**

ШУТИС-Уул уурхайн ашиглалтын технологи



**Б.ЗОЛЗАЯА**

АШУУИС-Шүдний эмч



**Э.ГЭРЭЛМАА**

АШУУИС-Сувилагч



**Н.ДӨЛГӨӨН**

АШУУИС-Хүүхдийн эмч



**Э.ДАЛАЙЖАРГАЛ**

МУИС-Нийгмийн ухааны багш



**Х.УРАНЦЭЦЭГ**

Ач анагаах ухааны ИС-Шүдний эмч



**Т.ДОЛЖИДМАА**

АШУУИС-Шүдний эмч



**Б.ЗОЛЖАРГАЛ**

АШУУИС-Эмч-Уламжлалт



**С.МИЧИДМАА**

ХУИС-Аялал жуулчлалын менежмент



**Ш.ГАРТААМ**

АШУУИС-Хүний их эмч



**Б.МӨНХЗУЛ**

Их засаг ОУИС-Барилгын инженер



**Д.АНУЖИН**

ШУТИС-Үйлдвэрлэлийн автоматжуулалт



**А.НАНДИНЦЭЦЭГ**

МУБИС-Технологийн багш



**Т.БАТ-ЭНХ**

Этүгэн-Шүдний эмч



**С.АМИНЦЭЦЭГ**

ШУТИС-Цахилгааны инженер



**Х.ОЮУ-ЭРДЭНЭ**

Этүгэн-Хүний их эмч



**М.ОТГОНЦЭЦЭГ**

АШУУИС-Хүний их эмч



**Т.НАРАНГОО**

Үндэсний ТИС-Барилгын инженер





**Б.ОТГОНЦЭЦЭГ**

МУБИС-Бага ангийн багш



**Б.АНАРЧУЛУУН**

АШУУИС-Эм зүйч



**Б.ПҮРЭВЖАЛ**

Их засаг ОУИС-Хүний их эмч



**Ц.ХУЛАН**

СУИС-Жүжигчин



**И.САЙНЗАЯА**

МУИС-Англи хэлний багш



**Ч.ШҮРЭНЦЭЦЭГ**

Этүгэн-Их эмч



**А.ТЭГШЗАЯА**

ХААИС-Малын их эмч



**Б.РОЛЖИНСҮРЭН**

МУИС-Нийгмийн ухааны багш



**Э.ЦЭРЭНЖАВ**

ХААИС-Байгаль орчны хяналт үнэлгээ



**Б.ЭРСҮҮХ**

Оточ манрамба-Эмч-Уламжлалт



**Н.СҮНДИЙ**

ХААИС-Малын эмч



**Б.ТҮМЭНХҮСЛЭН**

СУИС-Жүжигчин



**Ц.АНАР**

Боловсрол эрх зүйн ДС-Жүжигчин-найруулагч



**Д.ЖИМСМАА**

Их засаг-Бага ангийн багш



**Ч.ДӨЛ-ЭРДЭНЭ**

Этүгэн-Их эмч



**Х.УЯНГА**

АШУУИС  
Дорноговь-Сувилахуй



**О.МАРАЛ-ЭРДЭНЭ**

ХҮИС-Сэтгэлзүйч




**Ц.БОЛОР-ОД**

ШУТИС-Архитехтур



**Б.ЛХАМЖАРГАЛ**

МУИС-Биологийн багш



**О.МАНДУХАЙ**

Этүгэн-Эм зүйч



**О.САРАНЦАЦРАЛТ**

МУБИС-Нийгмийн ажилтан



**Л.АЮУШ**

Шинэ анагаах ухааны ИС-Эм зүйч



**Р.БАЯРМАА**

МУИС-Археологи



**А.НОМИНТӨГӨЛДӨР**

АШУУИС-Хүний их эмч



**А.ОЮУНБОЛОР**

АШУУИС-Нийгмийн эрүүл мэнд судлаач



**Б. СУГИРМАА**

АШУУИС-Сувилахуй



**Д. САНСАРМАА**

СУИС-Бүжигчин



**А. ЦОГДЭЛГЭР**

ХААИС-Байгаль орчны  
нөхөн сэргээлт



**Б. НАСАНТОГТОХ**

ХААИС-Байгаль орчны  
нөхөн сэргээлт



**УХОНГОРЗУЛ**

Оточ манрамба-  
Эмч-уламжлалт



**Б. САРАНГУА**

ШУТИС-Мэдээллийн  
систем



**М. ТҮВШИНТӨГС**

МУИС-Цахилгааны  
инженер



**Г. БУЯНБУЛГАН**

Этүгэн-Шүдний эмч



**Б. НАСАНЦЭЦЭГ**

АШУУИС-Шүдний эмч



**Д. ТЭГШЖАРГАЛ**

МУБИС-СӨБ багш



**Н. МӨНХГЭРЭЛ**

Этүгэн-Эм зүйч



**Ц. НЯМДАРЬ**

МУИС-Нийгмийн  
ажилтан



**М. МЯГМАРСҮРЭН**

МУБИС-Математик  
багш



**Б. ЦЭЦЭГДЭЛГЭР**

Этүгэн-Шүдний эмч



**Б. ХУЛАН**

АШУУИС-Шүдний эмч



**Д. АЛТАНЖАРГАЛ**

Этүгэн-Шүдний эмч



**Б. ШИНЭЦЭЦЭГ**

АШУУИС-Шүдний эмч



**Н. ХОНГОРЗУЛ**

Этүгэн-Их эмч



**Б. НАНДИНБОЛОР**

АШУУИС-Сувилахуй



**М. ЭРДЭНЭЦЭЦЭГ**

МУБИС-Сэтгэлзүйч



**Э. БАТЧИМЭГ**

МУБИС-Англи хэлний  
багш



**И. ЛХАМ-ОСОРЖИН**

МУИС-Нийгмийн ажилтан



**Б. ЖАМЦ**

ШУТИС-Программ  
хангамж



**У. БАЯНМӨНХ**

МУБИС-Биеийн тамирын  
багш



**Х. УРАНЦЭЦЭГ**

Эм зүйн шинжлэх  
ухааны ИС-Эм зүйч



## ХАНДИВ ТУСЛАМЖ

“Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” нь Хандив тусламжийн журмын дагуу Өмнөговь аймаг, тус аймгийн сумдад шаардлагатай тулгамдсан асуудал, журамд заасан хандивын төрлийн дагуу 2016-2021 онд 2.1 тэрбум төгрөгийн Хандив тусламж олгосон байна.

### “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ААС 2021 ОНД ОЛГОСОН ХАНДИВ







## 2016-2021 ОНД ОЛГОСОН ХАНДИВ


### 2016-2021 онд олгосон/олгох хандив



Он	Тоо	Дүн
2016	5	33,000,000
2017	12	368,125,762
2018	20	175,412,560
2019	25	370,588,700
2020	11	322,595,920
2021	4	866,500,000
<b>Нийт</b>	<b>77</b>	<b>2,136,222,942</b>

## 2016-2021 ОНД ОЛГОСОН ХАНДИВ- 2.1 ТЭРБУМ ₮

### Олгосон хандив - ₮-өөр харуулав





Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ


## 2021 ОНД “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ААС

### САНХҮҮЖҮҮЛЭХЭЭР САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС БАТАЛСАН ТӨСЛҮҮД

“Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөл нь 2021 онд 7 томоохон төсөл, хөтөлбөр санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Мөн сангаас түншлэгч болон уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулахгүй байгаа сумд болох Ханбогд, Манлай, Баян-Овоо, Даланзадгад, Сэврэй, Баяндалай, Мандал-Овоо, Цогт-Овоо, Булган, Номгон, Хүрмэн сумдад олгосон санхүүжилтийн квотоор дээрх сумдад нийт 47 төсөл, хөтөлбөр хэрэгжээд байна.

2021 онд санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн хамтын ажиллагааны сэдэвчилсэн хавсралтаар ангилсан байдлыг харуулбал

2021 онд санхүүжүүлсэн төсөл хөтөлбөр-  
Сэдэвчилсэн хавсралт - (₮)






“Говийн Оюу хөгжлийн дэмжих сан”-гийн 2015-2021 онд санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийг Хамтын ажиллагааны гэрээний Сэдэвчилсэн хавсралтын дагуу ангилбал:

№	Сэдэвчилсэн Хавсралт	Төслийн тоо	Санхүүжилт (₮)	Санхүүжилт (\$)
1	Нийгмийн дэд бүтэц	53	52,001,068,647	21,105,850.67
2	Байгаль орчны менежмент	15	1,211,283,360	509,836.51
3	Нийгмийн суурь үйлчилгээ	157	11,937,384,585	4,700,751.58
4	Орон нутгийн бизнес хөгжил	16	2,579,814,655	1,020,188.79
5	Уламжлалт мал аж ахуй	17	1,972,601,439	816,518.69
6	Усны менежмент	16	1,640,672,270	639,328.57
7	Үндэсний түүх соёл	30	1,259,856,099	563,418.13

**“Говийн Оюу хөгжлийн дэмжих сан”-гийн 2015-2021 онд санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийг Хамтын ажиллагааны гэрээний Сэдэвчилсэн хавсралтын дагуу ангилбал:**








## “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМАГТ ОРУУЛСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ СУМДААР

Сумын нэр	Санхүүжилтийн хуваарилалт (₮)	Санхүүжилтийн хуваарилалт (\$)
Бүх сумдыг хамарсан	10,779,875,899	4,268,337.61
Өмнөговь аймгийн сумдыг хэсэгчлэн хамарсан	2,388,481,454	998,681.43
Даланзадгад сум	34,256,202,528	13,579,288
Ханбогд	13,058,005,651	5,662,203
Манлай	3,413,087,424	1,428,786
Баян-Овоо	2,646,457,497	1,138,066
Булган	336,659,600	127,597
Мандал-Овоо	1,463,792,039	588,419
Сэврэй	324,237,300	123,156
Цогт-Овоо	3,331,376,161	1,235,327
Номгон	231,165,300	90,000
Баяндалай	475,525,600	178,774
Хүрмэн	166,584,000	60,000






САНГИЙН САНХҮҮЖИЛТЭЭР ХЭРЭГЖСЭН  
ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ҮР ШИМ ХҮРТЭГЧ



Зорилтот үр шим хүртэгч



	Хүүхэд	Эмэгтэйчүүд	Залуучууд	Малчин	Ахмад настан	Эмзэг бүлгийн иргэд	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
■ 2021	11196	47522	40000	2829			
■ 2020	26230	21560	4786		1288	260	
■ 2019	32574	53475	959	10763	12074	90	4313
■ 2018	10592	13,181	1920	3040	77	90	1995
■ 2017	7504	173	11514	531	12375		300
■ 2016	6486	1000	18450	6971	38		
■ 2015	593						



Итгэцээд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

## “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН 2015-2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

**82.3 ТЭРБУМ ₮**  
**32.97 САЯ \$**

Харилцагч  
байгууллага

**+400**



Шинэ ажлын  
байр

**484**



25 төслийн  
хамтарсан  
санхүүжилт

**30 тэрбум ₮**



Үр шим  
хүртэгч

**+760,000**

Тэтгэлэгт  
оюутан

**324**



Бизнесийн  
хөнгөлөлттэй  
зээл

**51**



Санхүүжилтийн  
квот

**4.3 тэрбум ₮**



Хөрөнгө  
оруулалт

**82.3 тэрбум ₮**







## НҮБ-ЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДАД “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ААС ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР



**7.3 ТЭРБУМ ₮**  
**2.8 САЯ \$**

### ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ - ЗОРИЛТ 3

- Чадавхжуулах сургалт
- Тоног төхөөрөмж нийлүүлэх хөтөлбөр
- Иргэдэд мэдлэг, мэдээлэл өгөх сургалт



**2.5 ТЭРБУМ ₮**  
**1.1 САЯ \$**

### ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ - ЗОРИЛТ 4

- Сургууль цэцэрлэгийн тоног төхөөрөмж
- Сургалт, сургалтын хэрэглэгдэхүүн



**763 САЯ ₮**  
**287 МЯН. \$**

### БАТАЛГААТ УНДНЫ УС АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖААР ХАНГАХ - ЗОРИЛТ 6

- Гашуунсухайт боомтын ус цэвэршүүлэх байгууламж
- Сумдад худаг гаргах ажил



**4.6 ТЭРБУМ ₮**  
**1.9 САЯ \$**

### ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ - ЗОРИЛТ 8

- Бизнес хөгжлийг дэмжих төсөл
- Хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлт



**51.8 ТЭРБУМ ₮**  
**21 САЯ \$**

### ИННОВАЦИ БОЛОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ - ЗОРИЛТ 9

- Эмнэлэг, сургууль, цэцэрлэг, музей, спорт заалны барилга



**2.3 ТЭРБУМ ₮**  
**938.4 МЯН \$**

### ЭЭЛТЭЙ ХОТ, ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ - ЗОРИЛТ 11

- Сургалт, нөлөөллийн ажил
- Иргэдийн ая тухтай амьдрах орчинг сайжруулах тохижилт, үйлчилгээний ажил



**1.2 ТЭРБУМ ₮**  
**505 МЯН \$**

### УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН НӨЛӨӨГ БАГАСГАХ - ЗОРИЛТ 15

- Сумдад мод тарих
- Хог хаягдал менежмент



**34.2 САЯ ₮**  
**17 МЯН \$**

### ЭНХ ТАЙВАН, ШУДАРГА ЁСЫГ ЦОГЦЛООХ - ЗОРИЛТ 16

- Хүний наймааны хохирогч, шилжин суурьшигчдын эрхийг хамгаалах хөтөлбөр хэрэгжүүлсэн



**82.3 ТЭРБУМ ₮**  
**32.97 САЯ \$**

### ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ТҮНШЛЭЛИЙГ БИЙ БОЛГОХ - ЗОРИЛТ 17

- 82.3 тэрбум ₮ буюу 32.97 сая \$-ийн хөрөнгө оруулалт хийж 400 гаруй түнштэй болсон

# САНГИЙН 2021 ОНЫ

# ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ



Харилцааны хорооны хурал

2021.04.01

## Санхүүжилтийн квотоор 48 хөтөлбөр хэрэгжсэн

2021.04-12 сар- Санхүүжилтийн квотын гэрээ байгуулсан сумдад тогтвортой хөгжлийн хөтөлбөрүүд хэрэгжсэн



2020 оны санхүү, үйл ажиллагаанд хөндлөнгийн Аудит хийлгэв.

2021.08

## Олон улсын байгууллагуудтай хамтарсан хөтөлбөр

• Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих хамтарсан хөтөлбөр-2018-2021 онд хэрэгжиж давхардсан тоогоор 85,0 мянган хүнд үр өгөөжөө өглөө



## ХДС-ийн 2020 оны тайланг хэвлүүлж олон нийтэд танилцуулав

2021.02 сард 2000 хувь хэвлүүлж олон нийтэд түгээв



## Зорилтот сумдын санхүүжилтийн квот

2021.04 сар- Ханбогд, Баян-Овоо, Манлай, Даланзадгад, Сэврэй, Баяндалай, Номгон, Булган, Цогт-Овоо, Мандал-Овоо, Хүрмэн сумдын засаг дарга нартай санхүүжилтийн квотын гэрээ байгуулав

## Удирдах зөвлөлийн хурал

2021.04.16



## Мал угаалга, хашаа хорооны ариутгал, халдваргүйжүүлэлт-2019-2021

- 2019 он- "Говийн Оюу ХДС" санхүүжүүлсэн
- 2020 он- Өмнөговь. АЗДТГ санхүүжүүлсэн
- 2021 он- Өм. Малчид санхүүжүүлсэн

## Говийн Оюу-Оюутны тэтгэлэг

- 2021 онд 90 оюутан тэтгэлэгт хамрагдаж өссөн дүнгээр нийт 324 оюутанд тэтгэлэг олгосон





## УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС САНГИЙН 2021 ОНЫ САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ХУВААРИЛСАН ХУВААРИЛАЛТ

	2021 онд ОТ ХХК-аас хүлээн авсан санхүүжилт	16,251,900,621.00	5,703,382.00
	2020 оны санхүүжилтийн үлдэгдэл	1,669,001,252.18	585,669.20
	2021 онд хуваарилах боломжтой санхүүжилт	17,920,901,873.18	6,289,051.20
№	ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН НЭР	САНХҮҮЖИЛТ (₮)	САНХҮҮЖИЛТ (\$)
<b>Нийгмийн дэд бүтэц</b>			
1	Цогт-Овоо сумын 15 ортой эрүүл мэндийн төвийн барилга	3,014,716,561.00	1,057,973.47
2	Даланзадгад сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажилд	250,000,000.00	87,734.07
3	Дата төв байгуулах техник, эдийн засгийн үндэслэл, зураг, зах зээлийн судалгаа боловсруулах ажил	118,769,670	41,680.59
4	Нутгийн үйлдвэрлэгч	1,000,000,000	350,936.30
5	Эко жорлон	599,994,300	210,559.78
6	Даланзадгад сумын 1200 хүүхдийн сургуулийн барилга	5,585,219,758	1,960,056.35
7	Даланзадгад сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга	1,765,485,316	619,572.88
	<b>Дэд дүн (А)</b>	<b>12,334,185,605.00</b>	<b>4,328,513.43</b>

<b>Тогтвортой хөгжлийн хөтөлбөр</b>			
1	Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих хамтарсан хөтөлбөр	1,434,833,573	503,535.18
2	Хүүхдийн зуслангийн зоогийн газрын тоног төхөөрөмж	158,866,000.00	55,751.85
3	Бэлчээр усжуулалтын 2-р аян	516,133,596.00	181,130.01
	<b>Дэд дүн (Б)</b>	<b>2,109,833,169.00</b>	<b>740,417.04</b>





*Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

<b>Санхүүжилтийн квотоор хэрэгжсэн төслүүд</b>			
<b>ХАНБОГД СУМ</b>			
	<b>2021 онд хуваарилсан санхүүжилтийн квот (В)</b>	<b>199,486,700</b>	<b>70,000</b>
	2020 оноос шилжиж орж ирсэн квотын санхүүжилтийн үлдэгдэл	925,371.00	342.35.00
1	Цэмцгэр Ханбогд	70,000,000.00	24,565.54
2	Гадна тохижилт	21,025,580.00	7,378.64
3	Сагсан бөмбөг	7,080,000.00	2,484.63
4	Эрдмийн оргил	15,380,000.00	5,397.40
5	Ханбогд брэнд багц	10,000,000.00	3,509.36
6	Нэг цэг	7,500,000.00	2,632.02
7	Малын им тамга	25,800,000.00	9,054.16
8	Гар аргаар худаг гаргах	10,000,000.00	3,509.36
9	Багт мод тарих	9,750,000.00	3,421.63
10	Баян дэлгэрэх	11,000,000.00	3,860.30
	Эрсдэлийн сангийн зарцуулалт	0	0
<b>БАЯН-ОВОО СУМ</b>			
	<b>2021 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Г)</b>	<b>142,490,500.00</b>	<b>50,000.00</b>
	2020 оноос шилжиж орж ирсэн квотын санхүүжилтийн үлдэгдэл	16,765,225.00	6,202.47
1	Баян-Овоо Говийн төгөл	20,000,000.00	7,018.73
2	Баян-Овоо Цэвэр сум	55,000,000.00	19,301.50
3	Цэвэр агаар-Эрүүл мэнд	40,000,000.00	14,037.45
4	Эмнэлгийн түргэн тусламж	20,000,000.00	7,018.73
	Эрсдэлийн сангийн зарцуулалт	7,000,000.00	2,456.55
<b>МАНЛАЙ СУМ</b>			
	<b>2021 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Д)</b>	<b>142,490,500.00</b>	<b>50,000.00</b>
	2020 оноос шилжиж орж ирсэн квотын санхүүжилтийн үлдэгдэл	182,565.00	67.54
1	Цэвэр Манлай	40,674,000.00	14,273.98



2	Эмнэлгийн хог хаягдлын менежмент	13,000,000.00	4,562.17
3	Үдийн цайны гал тогооны тоног төхөөрөмж	25,000,000.00	8,773.41
4	Малын им, тамга	3,000,000.00	1,052.81
5	Хөгжмийн боловсрол хүүхдийн ирээдүй	8,500,000.00	2,982.96
6	Эрүүл эх хүүхэд-Эрүүл манлай	7,000,000.00	2,456.55
7	Түүх, өв соёл	13,000,000.00	4,562.17
8	Ахмадын өргөөний гадна тохижилт	25,000,000.00	8,773.41
	Эрсдэлийн сангийн зарцуулалт	7,124,525.00	2,500.25
<b>ДАЛАНЗАДГАД СУМ</b>			
	<b>2021 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Е)</b>	<b>142,490,500.00</b>	<b>50,000.00</b>
	2020 оноос шилжиж орж ирсэн квотын санхүүжилтийн үлдэгдэл	23,729,400.00	8,778.94
1	Дотуур байр бидний гэр	14,500,000.00	5,088.58
2	Сургалтын таатай орчин	15,000,000.00	5,264.04
3	Номадик говь	19,500,000.00	6,843.26
4	Жишиг мал эмнэлгийн үйлчилгээ	14,500,000.00	5,088.58
5	Дэвшилтэт Даланзадгад	38,000,000.00	13,335.58
6	Даланзадгадад үйлдвэрлэв	22,500,000.00	7,896.07
7	Хүмүүний хэрэглээ хүчилтөрөгч	15,900,000.00	5,579.89
	Эрсдэлийн сангийн зарцуулалт	18,995,970.00	7266.06
<b>БАЯНДАЛАЙ СУМ</b>			
	<b>2021 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Ё)</b>	<b>85,494,300.00</b>	<b>30,000.00</b>
	2020 оноос шилжиж орж ирсэн квотын санхүүжилтийн үлдэгдэл	644,481.00	238.43
1	Далай булаг	10,000,000.00	3,509.01
2	Журмын хашаа	10,000,000.00	3,509.01
3	Хот айл	15,000,000.00	5,263.51
4	Явуулын үйлчилгээ	16,000,000.00	5,614.41
5	Усны машин	30,000,000.00	10,527.02
	Эрсдэлийн сангийн зарцуулалт	0	0



*Итгэцлэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

СЭВРЭЙ СУМ			
	<b>2021 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Ж)</b>	<b>85,494,300.00</b>	<b>30,000.00</b>
	2020 оноос шилжиж орж ирсэн квотын санхүүжилтийн үлдэгдэл	2,019,200.00	747.02
1	Ахмадын сургаал алт	7,490,000.00	2,628.51
2	Эмийн сан	15,600,000.00	5,474.61
3	Түргэн тусламж - 2	63,000,000.00	22,108.99
	Эрсдэлийн сангийн зарцуулалт	0	0
МАНДАЛ-ОВОО СУМ			
	<b>2021 онд хуваарилсан санхүүжилтийн квот (З)</b>	<b>85,494,300.00</b>	<b>30,000.00</b>
	2020 оноос шилжиж орж ирсэн квотын санхүүжилтийн үлдэгдэл	1,863,120.00	689.28
1	Эмнэлгийн эрсдэлгүй орчин	19,900,000.00	6,983.63
2	Стандартад нийцсэн соёлтой үйлчилгээ	5,000,000.00	1,754.68
3	Иргэдийн оролцоо нутгийн хөгжил	48,790,000.00	17,122.18
	Эрсдэлийн сангийн зарцуулалт	4,230,000.00	1,484.46
ЦОГТ-ОВОО СУМ			
	<b>2021 онд хуваарилсан санхүүжилтийн квот (И)</b>	<b>85,494,300.00</b>	<b>30,000.00</b>
	2020 оноос шилжиж орж ирсэн квотын санхүүжилтийн үлдэгдэл	7,115.00	2.63
1	Бид өнөөдрийн уншигч-Маргаашийн манлайлагчид	9,864,000.00	3,461.64
2	Зөөврийн хяналтын сууц	19,500,000.00	6,843.26
3	Эмнэлгийн тоног төхөөрөмж, зөөлөн эдлэл	6,849,400.00	2,403.70
4	Мал угаалгын дүк автомашин нийлүүлэх	44,500,000.00	15,616.67
	Эрсдэлийн сангийн зарцуулалт	4,274,715.00	1,500.15
НОМГОН СУМ			
	<b>2021 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Й)</b>	<b>85,494,300.00</b>	<b>30,000.00</b>
	2020 оноос шилжиж орж ирсэн квотын санхүүжилтийн үлдэгдэл	614,800.00	227,45.00
1	Баянбулаг тоног төхөөрөмж	83,000,000.00	29,127.71
	Эрсдэлийн сангийн зарцуулалт	0	0





БУЛГАН СУМ			
	2021 онд хуваарилсан санхүүжилтийн квот (К)	85,494,300.00	30,000.00
	2020 оноос шилжиж орж ирсэн квотын санхүүжилтийн үлдэгдэл	688,145.00	254.59
1	Ус түгээх байранд цахим төхөөрөмж суурилуулах	18,285,000.00	6,416.87
2	Музейн тохижилт	19,571,500.00	6,868.35
3	Иргэнд хүртээмжтэй төрийн үйлчилгээ, тохижилт	35,000,000.00	12,282.77
	Эрсдэлийн сангийн зарцуулалт	1,600,000.00	561.50
ХҮРМЭН СУМ			
	2021 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Л)	85,494,300.00	30,000.00
	2020 оноос шилжиж орж ирсэн квотын санхүүжилтийн үлдэгдэл	4,149,701.00	1,535.23
	Эрсдэлийн сангийн зарцуулалт	0	0
	Санхүүжилтийн квотын дүн (М)	1,225,418,300.00	430,000.00
БУСАД			
1	Ирээдүй хойч үеийн төлөө сан	975,213,248.73	342,237.73
2	Хандив тусламж	862,535,541.45	302,695.03
3	ХДС-ийн үйл ажиллагаа	413,716,009.00	145,187.96
	Дэд дүн (Н)	2,251,464,799.18	790,120.72
	Нийт дүн(А+Б+М+Н)	17,920,901,873.18	6,289,051.20



*Итгэцлэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС 2021 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХЭЭР БАТАЛСАН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД:

### 1. “ЦОГТ-ОВОО СУМЫН 15 ОРТОЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН БАРИЛГА” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ**

БАРИЛГЫН ГҮЙЦЭТГЭГЧ:

**“ЭВТ ЦАХИРАЛ” ХХК**

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

**3,014,716,561 төгрөг**



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- 2020 оны жилийн эцсийн байдлаар Цогт-Овоо сум нь албан ёсны бүртгэлтэй 1896 хүн амтай, засаг захиргааны анхан шатны нэгж болсон 4 багтай сум юм. Тус сумын эрүүл мэндийн төвийн барилга нь 2007 онд ашиглалтад орсон 9 орны хүчин чадалтай. Улаанбаатараас Өмнөговь аймгийн төв Даланзадгад хоорондын улсын чанартай авто зам тус сумын төвөөр дайран гардаг тул орон нутгийн иргэд, уул уурхайн ажилчид, гадаад дотоодын аялагч гэх мэт зорчин өнгөрөх иргэдийн тоо харьцангуй ихтэй байдаг тул ердийн сумын эмнэлгээс илүү ачаалалтай ажиллагсаас гадна гэнэтийн осол аваарын үед үзүүлэх анхан шатны яаралтай тусламж үйлчилгээний хүртээмж маш муу байдаг. Дээрх нөхцөл байдлаас шалтгаалан өрөө тасалгаа, орны тоо хүрэлцдэггүй, эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээний стандарт хангагдаагүй, эмнэлгийн дотоод халдвар дамжих эрсдэл өндөр, яаралтай тусламж үйлчилгээний үед хүлээлт, дараалал ихтэй зэрэг олон хүндрэлтэй асуудал тулгардаг байна.



### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Стандартын шаардлага хангасан эмнэлгийн барилга барьж иргэдэд чанар, хүртээмжтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх болон эмч, эмнэлгийн ажилтнуудын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах.

### ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 05 дугаар тогтоолоор “Цогт-Овоо сумын 15 ортой эрүүл мэндийн төвийн барилга” төслийг 3,106,754,176 төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Эвт цахирал” ХХК, санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар барилга угсралтын ажлыг эхлүүлэв.
- 2021 онд “Эвт цахирал” ХХК нь орон нутгийн зах зээлээс 218 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүн худалдан авч, 56 түр ажлын байр бий болгосон.
- Барилга угсралтын ажил 2021 оны жилийн эцсийн байдлаар 30 хувьд хүрэв.

### ҮР ДҮН:

- Цогт-Овоо сум стандартын шаардлага хангасан эмнэлгийн барилгатай болно.
- Эрүүл мэндийн үйлчилгээний төрөл, чанар, хүртээмж дээшилнэ.
- Эрүүл мэндийн үйлчилгээний орчин нөхцөл сайжирна.
- Эмч, эмнэлгийн ажилтнууд ая тухтай орчинд ажиллана.
- Эмч, ажилчдын ажлын бүтээмжид эерэг нөлөө үзүүлнэ.

## 2021 ОНД БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ 30 %-Д ХҮРЭВ







*Итгэцлэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## 2. “ДАЛАНЗАДГАД СУМЫН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГОХДС-С ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ

“ММ АРХИТЕКТУР” ХХК

250,000,000 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 2015 онд батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөө нь 2030 он хүртэл баримтлахаар боловсруулагдсан боловч тус ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн шатанд сумын хөгжлийн чиг хандлага, хурдцаас шалтгаалан барилга байгууламжийн төлөвлөлт инженерийн шугам сүлжээний төлөвлөлт хийх, бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэхэд жил ирэх тутам хүндрэл учирч байна.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Даланзадгад сумын төвийн 4700 га талбайд хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Монгол улсын нийгэм эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, бүс нутаг, хот байгуулалтын болон хөрш зэргэлдээ орших аймаг, сумын хөгжлийн бодлоготой уялдуулан хөгжүүлэх стратеги, төлөвлөлт бүхий хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл боловсруулахад оршино.

### ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 05 дугаар тогтоолоор “Даланзадгад сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах” төслийг 250,000,000 төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “ММ Архитектур” ХХК, санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар төслийг эхлүүлэв.







Итгэцээд сууринсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

### 3. “ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ДАТА ТӨВ БАЙГУУЛАХ ТЭЗҮ, ЗУРАГ ТӨСӨЛ, ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА БОЛОВСРУУЛАХ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

БАТЛАГДСАН ТӨСӨВ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН АЖИЛ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ

152,000,000 ТӨГРӨГ

1. Барилгын зураг төсөл боловсруулах ажил-  
“ХЯЗГААРГҮЙ ШУЛУУН” ХХК, 39,900,000 төгрөг



#### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Өмнөговь аймгийн Даланзадгад сум нь 2020 оны жилийн эцсээр 8,608 өрхийн 27,525 хүн амтай. Засаг захиргааны хувьд үндсэн 8 багт хуваагддаг. Өмнөговь аймаг нь уул уурхайн салбарыг түшиглэн хөгжиж буй аймаг тул цаашид орон нутгийн бизнес эрхлэгчдэд уул уурхайтай холбоотой болон холбоогүйгээр үүсэх боломж, эрсдэлийг тооцоолон орон нутгийн эдийн засаг, бизнесийн хөгжлийн шинэ түвшинд хүргэн хөгжүүлэх цогц бодлогын баримт бичиг боловсруулах, үе шаттай хэрэгжүүлэх бодит шаардлага тулгарч байна.



### **ТӨСЛИЙН ЗОРИЛГО:**

- Өмнөговь аймагт уул уурхайн бус бизнесийг хөгжүүлэх бодлогын хүрээнд Дата төв байгуулах техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, зах зээлийн судалгаа, бизнес орчны шинжилгээ, бизнес модель боловсруулах бөгөөд дараах ажлууд хийгдэнэ.

Үүнд:

- Дата төвийн барилгын зураг төсөв боловсруулна /15\*18 м2 харьцаатай 3 давхар барилга/
- Дата төвийн техник эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/ боловсруулна
- Дата төвийн зах зээлийн судалгаа, бизнес модель, эрх зүйн орчны судалгаа хийнэ.

### **ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:**

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 05 дугаар тогтоолоор “Өмнөговь аймгийн дата төв байгуулах техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, зах зээлийн судалгаа боловсруулах” төслийг 152,000,000 төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, барилгын зураг төсвийн зохиогч “Хязгааргүй шулуун” ХХК, санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар төслийг эхлүүлэв.
- 2021 оны жилийн эцэст “Өмнөговь аймгийн дата төв байгуулах ТЭЗҮ, зураг төсөл, зах зээлийн судалгаа боловсруулах” төслийн дараах ажлууд тендерийн шатанд байна.
  - Дата төвийн техник эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/ боловсруулна
  - Дата төвийн зах зээлийн судалгаа, бизнес модель, эрх зүйн орчны судалгаа хийнэ.

### **ҮР ДҮН:**

- Дата төвийн техникийн шийдэл, ажлын даалгавар, зураг төсөл бүхий баримт бичигтэй болно
- Өмнөговь аймагт шинээр хөгжих боломжтой гарааны бизнес, мэдээллийн технологийн чиглэлийн компани, төслийг хэрхэн дэмжих стратеги тодорхой болно
- Орон нутгийн эдийн засаг, бизнесийн хөгжилд баримтлах технологид суурилсан, зардал хэмнэсэн, хүртээмжийг ихэсгэх, бүтээмж өсгөхүйц арга техник зэрэг цогц бодлогыг мэргэжлийн түвшинд хөгжүүлэхэд дэмжлэг болох бодлогын баримт бичигтэй болно.





*Итгэцлэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

#### 4. “БУЯНТ ХОТХОН ХҮҮХДИЙН ЗУСЛАНГИЙН ЦАЙНЫ ГАЗРЫГ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖӨӨР ХАНГАН ОРЧИН НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ

“ИХЭР САЙХАН УУЛ” ХХК

158,866,000 төгрөг



#### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Өмнөговь аймгийн Буянт хотхон хүүхдийн зуслан 1957 онд байгуулагдаж эдүгээ хүртэлх хугацаанд говь нутгийн ирээдүй хойч үе болсон хүүхэд багачууд амрах, чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэх, байгаль орчноо хайрлан хамгаалах, бие даан сурч хөгжих, багаар ажиллаж, хөгжиж төлөвших үйлсэд хүндтэй үүрэг хүлээн ирсэн. Өмнөговь аймгийн ЗДТГ-с “Буянт хотхон” хүүхдийн зусланг олон улсын хүүхдийн зуслан болгохоор зорин 250 хүүхдийн багтаамжтай зоогийн газар, оффисын өрөө, эмнэлгийн өрөө тасалгаа бүхий цогцолборыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр барьж байгаа. Иймд уг барилгын хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, эмнэлгийн тусламж үйлчилгээний тоног төхөөрөмж, хэрэгсэл нийлүүлэх хэрэгцээ шаардлага үүссэн.





### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Зусланд амарч буй хүүхэд, амрагчдад эрүүл ахуйн стандартад нийцсэн орчинд амт чанар, шим тэжээл сайтай хоолоор үйлчлэх мөн байгууллагын ажилтнуудад тав тухтай ажиллах орчин нөхцөл бүрдүүлэх

### ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 05 дугаар тогтоолоор “Буянт хотхон хүүхдийн зуслангийн цайны газрыг тоног төхөөрөмжөөр ханган орчин нөхцөлийг сайжруулах” төслийг 177,985,000 төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Ихэр сайхан уул” ХХК, санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар төслийн ажлыг эхлүүлэв.

### ҮР ДҮН:

- “Буянт хотхон” хүүхдийн зуслан нь 250 хүнд зэрэг үйлчлэх шаардлага хангасан гал тогооны тоног төхөөрөмжтэй болсон.
- Улмаар зуслангийн гал тогооны эрүүл ахуй сайжирч, зусланд амарч ажиллаж байгаа хүмүүсийг тав тухтай орчин байрлуулах боломж бүрдэнэ.

### БУЯНТ ХОТХОН ХҮҮХДИЙН ЗУСЛАНД 48 НЭР ТӨРЛИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ТАВИЛГА ХЭРЭГСЭЛ НИЙЛҮҮЛСЭН.





Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

## 5. “ЭКО ЖОРЛОН” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ

БАТЛАГДСАН ТӨСӨВ:

599,994,300 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Даланзадгад сумын төвийн газар өмчлөл, эзэмшилд байгаа нийт газар нутгаас гэр бүлийн хэрэгцээний өмчлөлд 15,841 айл өрхийн 1,237.5 га, иргэн аж ахуй нэгж байгууллагын эзэмшилд 2,459.1 га газар тус тус байна. Энэ нь сумын газар ашиглалтын ихэнх хувийг гэр бүлийн хэрэгцээний газар эзэлж байгаа нь гэр хорооллын нүхэн жорлонгоос үүдэлтэй хөрс агаарын бохирдол маш их байгааг харуулж байна. Мөн сүүлийн жилүүдэд орсон их хэмжээний борооны улмаас Гурвансайхан уулнаас буух үерээр далангийн даац хэтрэн эвдрэх, засмал зам даван халих зэргээр гэр хорооллын олон айл өрхийг усанд автуулж байгаа нь тэдний одоогийн ашиглаж буй доторлогоогүй нүхэн жорлонгоос үүдэлтэй элдэв халдварт өвчин хөрс, усаар дамжин үер, усны дараа дэгдэх өндөр эрсдэлтэй байдаг. Мөн хөдөөгийн зарим сумдын сургууль, тэдгээрийн дотуур байр, аялал жуулчлалын гол түшиц газруудад эрүүл ахуйн стандартын шаардлагад нийцээгүй нүхэн жорлонгийн тоог үе шаттайгаар бууруулах, сайжруулах арга хэмжээг авах зайлшгүй нөхцөл, шаардлага тулгарч байна.



### **ТӨСЛИЙН ЗОРИЛГО:**

- Энэ ажлын хүрээнд цэвэр, бохир усны төвлөрсөн шугам сүлжээнд ойрын хугацаанд холбогдох боломжгүй гэр хорооллын айл өрх болон аялал жуулчлалын бүсэд говийн нөхцөлд тохирсон хямд өртөг бүхий эко жорлонгийн шийдлийг гаргаж, инновац дэмжих арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр хог хаягдлаас үүсэх хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад эерэг нөлөө үзүүлж, хөрс, усны бохирдол, хог хаягдлыг бууруулж эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

### **ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:**

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 05 дугаар тогтоолоор “Эко жорлон” төслийг 599,994,300 төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарласан.

### **ҮР ДҮН:**

- Даланзадгад сумын 250 айл өрх, Өмнөговь аймгийн сумдын ЕБС-ийн дотуур байр эко жорлонтой болно.
- Даланзадгад сумын үдэлт угталтын хаалганы хуучин нийтийн бие засах газар, Ёлын ам, Хавцгайт, Мухар шивэртийн хуучин жорлонг шинэчилж хуурай технологийн жорлон болгож өөрчилж Өмнөговь аймгийн хамгаалалтын захиргаа, Орон нутгийн иргэд, нөхөрлөлийн хамтын ажиллагааны хүрээнд байнгын хариуцагч эзэнтэй болно.
- Иргэдийн эрүүл ахуй, байгаль орчинд эерэг нөлөө авчирна.
- Хот, суурин газрын агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлэхэд дэмжлэг болно.






*Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## 6. “БЭЛЧЭЭР УСЖУУЛАЛТЫН ХОЁРДУГААР АЯН” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:  
ГҮЙЦЭТГЭГЧ:  
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ  
“ГРАНД ХОЛДИНГ” ХХК  
516,133,596 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Өмнөговь аймгийн Хөдөө аж ахуйн газраас аймгийн хэмжээнд нийт 6,537 малчин өрхийн 2,8 сая гаруй толгой мал 5,000 орчим бэлчээрийн худгаас ундалж байгаа нь нийт малын тоог хонин сүргийн тоо толгойд шилжүүлснээр нэг худгаас 800-3,700 толгой мал ундалж, нэг худгаас ус уух малын тоо стандартаас 2-3 дахин хэтэрсэн тухай тооцоо, судалгаа гаргасан. 2019 онд Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн санхүүжилтээр “Чандмань эрдэнэ” төсөл /784,8 сая ₮/-ийн хүрээнд Ханбогд, Манлай, Баян-Овоо, Цогт-Овоо сумдын 15 багийн газар нутагт 37 худаг шинээр гаргаж, 40 худаг сэргээн засварласан. Мөн аймаг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар худаг ус гаргах, сэргээн засварлах ажлууд хийгдсээр байгаа ч одоогийн байдлаар аймгийн хэмжээний нийт бэлчээрийн зориулалттай газрын 54,7 % нь л усжуулагдсан байна. Иймд цаашид усны дутагдалтай газар нутгуудад бэлчээр усжуулах, уст цэгийн тоог нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага байсаар байна.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Өмнөговь аймгийн 9 сумын усжуулагдаагүй, усан хангамж дутагдалтай, алслагдсан бэлчээрт газрын доорх усны геофизикийн хайгуул хийж инженерийн хийцтэй 18 худаг шинээр гаргах.





### ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 05 дугаар тогтоолоор “Бэлчээр усжуулалтын хоёрдугаар аян” төслийг 567,000,000 төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Гранд холдинг” ХХК, санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар төслийг эхлүүлэв.

### ҮР ДҮН:

- Бэлчээрийн нөөц сайтай газруудад газрын доорх усны шинэ нөөц олж тогтооно.
- Газрын доорх усны хайгуулаар уст цэгийн зөвлөмж өгсөн цэгийн мэдээллийг тэмдэгжүүлэх, мэдээллийн санд хадгалах, усжуулагдаагүй бэлчээрт инженерийн хийцтэй худаг шинээр гаргаж сум орон нутаг, тухайн бүсийн малчдад хүлээлгэн өгнө.
- Баяндалай, Ханхонгор, Мандал-Овоо, Хүрмэн, Ноён, Цогт-Овоо, Манлай, Баян-Овоо, Номгон сумдын усан хангамж дутагдалтай 18 газарт инженерийн хийцтэй худаг шинээр гаргаж 27,0 мянган га бэлчээрийг усжуулж, 50-80 малчин өрхийн 30.0-40.0 мянган толгой малыг найдвартай усны эх үүсвэртэй болгоно.

### 2021 ОНД ТӨСЛИЙН АЖИЛ 80 %-Д ХҮРЭВ



Баяндалай сумын Төхөм баг.  
Тавхан



Ханхонгор сум. Жавхлантаг баг.  
Хөх цав



Хүрмэн сум. Жанжин баг.  
Хөх ус



Хүрмэн. Жанжин.  
Түймэрт



Мандал-Овоо. Өтгөн баг.  
Шугам



Баяндалай. Баян баг.  
Таван толгой



*Итгэцлэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## 7. “НУТГИЙН ҮЙЛДВЭРЛЭГЧ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

БАТЛАГДСАН ТӨСӨВ:

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТ**

**1,000,000,000 ТӨГРӨГ**

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН АЖИЛ:

**Барилгын зураг төсөл боловсруулах ажил-  
“ГРАНД ЛАЙН ПРОЖЕКТ” ХХК,  
128,079,000 төгрөг**



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Даланзадгад сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд үйлдвэржилтийн бүсийг тогтоож түүнд үйл ажиллагаа явуулах үйлдвэрийн төлөвлөлтийг гаргасан байдаг. Тус бүсэд барилгын чиглэлийн 7, хөнгөн үйлдвэрийн 8, хүнсний үйлдвэрийн 9, малын гаралтай түүхий эд боловсруулах болон бусад чиглэлийн 30 гаруй үйлдвэр үйл ажиллагаа явуулах боломжтойгоор төлөвлөсөн байна. Уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд аймгийн хэмжээний үйлдвэрийн нөөц, кластер, бодлогын судалгаа хийх тухайн бүсийн дэд бүтцийн шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар шийдвэрлэх, хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа.





### **ТӨСЛИЙН ЗОРИЛГО:**

- Өмнөговь аймгийн Даланзадгад сумын үйлдвэрийн бүсийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, тус бүсийг эрчим хүчний найдвартай эх үүсвэрт холбох, хангах, аймгийн хэмжээний үйлдвэрийн нөөц, төвлөрөн байрлах боломж, бодлогын судалгаа хийх бөгөөд төслийн хүрээнд дараах ажлууд хийгдэнэ. Үүнд:
  - 35 кВ-ын ЦДАШ шинээр татах-(1км)
  - Дэд станц шинээр байгуулах
  - 10кВ-ын хаалттай хуваарилах байгууламж барих, Даланзадгад сумын станцад 1 гаргалгаа гаргах
  - Үйлдвэрлэлийн бүсийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах
  - Аймгийн хэмжээний үйлдвэрийн нөөц, кластер, бодлогын судалгаа

### **ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:**

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 05 дугаар тогтоолоор “Нутгийн үйлдвэрлэгч” төслийг 1,000,000,000 төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ “Үйлдвэрлэлийн бүсийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах” ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Гранд лайн прожект” ХХК, санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар зураг төсөв боловсруулах ажлыг эхлүүлэв.
- 2021 оны жилийн эцэст “Нутгийн үйлдвэрлэгч” төслийн дараах ажлууд тендерийн шатанд байна.
  - 35 кВ-ын ЦДАШ шинээр татах-(1км),
  - Дэд станц шинээр байгуулах, 10кВ-ын хаалттай хуваарилах байгууламж барих,
  - Даланзадгад сумын цахилгаан станцад 1 гаргалгаа шинээр гаргах
  - Аймгийн хэмжээний үйлдвэрийн нөөц, кластер, бодлогын судалгаа

### **ҮР ДҮН:**

- Өмнөговь аймгийн үйлдвэрлэлийн салбар цогц байдлаар хөгжих боломжтой бичиг баримттай болно.
- Үйлдвэрлэлийн бүс найдвартай эрчим хүчний эх үүсвэрээр хангагдана.
- Орон нутгийн иргэдэд тогтвортой, байнгын ажлын байр бий болох суурь тавигдана.



*Итгэцээг суурьлсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## ОН ДАМЖИН ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД:

### 1. “ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МУЗЕЙН БАРИЛГА БАРИХ” ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ: **ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ**  
БАТЛАГДСАН ТӨСӨВ: **9,773,713,692 төгрөг**  
ГҮЙЦЭТГЭГЧ, ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

1. Барилга угсралтын ажил: **“Аглут” ХХК, 5,795,000,000 төгрөг**
2. Гадна шугам сүлжээний ажил: **“Дүжий хайрхан” ХХК, 215,344,809 төгрөг**
3. “Музейн барилгын дотор засал (интерьер), лифт, үүдний гонх барих” төсөл:  
**“Аглут” ХХК, 2,089,053,404 төгрөг**
4. “Өмнөговь аймгийн музейн барилга барих төсөл”-ийн нэмэлт ажил:  
**“Аглут” ХХК, 471,702,337 төгрөг**
5. “Музейн сан хөмрөгийн өрөөний тоног төхөөрөмж нийлүүлэх”:  
**“Тангад-араа” ХХК, 137,454,000 төгрөг**
6. “Өмнөговь аймагт шинээр баригдаж буй музейд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах”: **“Эрдэнийн гүн говь” ХХК, 493,990,000 төгрөг**
7. “Өмнөговь аймагт шинээр баригдаж буй музейн гадна тохижилт”:  
**“Андгай” ХХК, 148,935,447 төгрөг**
8. “Өмнөговь аймагт шинээр баригдаж буй музейн барилгын үзмэрийн баяжилт-1”: **Археологийн хүрээлэн, 149,000,000 төгрөг**
9. “Өмнөговь аймагт шинээр баригдаж буй музейн барилгын үзмэрийн баяжилт-2”: **Палеонтологийн хүрээлэн, 200,000,000 төгрөг**





## **ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:**

- Өмнөговь аймаг нь Монгол улсын өмнөд хэсэгт байрлах үзэсгэлэнт байгальтай, говь нутгийн байгаль цаг агаарт зохицсон уламжлалт нүүдлийн соёл иргэншил, түүх соёлын арвин уламжлалтай нутаг юм. Байгалийн өвөрмөц тогтоц нь, үзэсгэлэнт газрыг түшиглэсэн аялал жуулчлал нь аймгийн эдийн засгийн тулгуур салбарын нэг юм. Монгол улсад ирж буй жуулчдын 80 гаруй хувь нь говь нутгийг үзэж сонирхохоор ирдэг. Эдгээр жуулчдад нутаг орны соёлын өв, говь нутгийн нэрийн хуудас болсон үлэг гүрвэлийн олдвор зэрэг палеонтологийн ховор нандин үзмэрүүдийг үзүүлэхэд аймгийн музейн одоогийн барилгын хүчин чадал хаана нь ч хүрдэггүй. Учир нь музейн барилга нь 1954 онд чулуугаар барьсан аймгийн анхны зочид буудал, 1969 онд аж ахуйн аргаар хоёр давхар болгосон барилга юм. Барилгад суулт өгч, хана цуурсан зэрэг эвдрэл гэмтэл нь музейн үйл ажиллагаанд тавигдах MNS 5634:2006 стандартын шаардлага хангахгүй, үзмэрүүдийн хадгалалт хамгаалалтад сөргөөр нөлөөлж байна.
- Энэ нөхцөл байдлын улмаас барилгын болон галын улсын байцаагчийн дөрвөн удаагийн дүгнэлтээр үйл ажиллагааг зогсоох шаардлага тавигдаад байгаа. Иймд уг барилгыг музейн зориулалтаар цаашид ашиглах боломжгүй болсон.

## **ТӨСЛИЙН ЗОРИЛГО:**

- Энэхүү төслийн гол зорилго нь стандартын шаардлага хангасан, барилга архитектурын өвөрмөц шийдэл бүхий музейн барилгыг барьж бүрэн тохижуулан ашиглалтад оруулах юм. Ингэснээр Монголын говь нутгийн соёлын өвийг хадгалж хамгаалах, хойч үедээ өвлүүлэн уламжлуулах, оюуны хөрөнгө оруулалт, танин мэдэхүйн боловсрол олгох, гадаад дотоодын аялагч жуулчдад Монголын говь нутгийг сурталчлан таниулах баян үзмэртэй жишиг музей болж улмаар аймгийн эдийн засагт хувь нэмэр оруулах ач холбогдолтой.

## **ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:**

- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 06 дугаар тогтоолоор “Өмнөговь аймгийн Музейн барилга” төслийг 5,8 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр дэмжиж санхүүжилтийг батлав.
- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор “Өмнөговь аймагт шинээр баригдаж буй музейн барилга байгууламжийн нэмэлт ажил” төслийг 3.6 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр дэмжиж санхүүжилтийг батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч аймгийн ЗДТГ, төслийн гүйцэтгэгч байгууллагууд тус бүртэй санхүүжилтийн гуравласан гэрээ байгуулав.
- 2021 оны 11 дүгээр сарын 22-нд барилгын ажлыг дуусган ашиглалтад шилжүүлэв.

## **ҮР ДҮН:**

- Монголын говь нутгийн соёлын өвийг хадгалж хамгаалах, хойч үедээ өвлүүлэн уламжлуулах, оюуны хөрөнгө оруулалт, танин мэдэхүйн боловсрол олгоход музей чухал үүрэг гүйцэтгэнэ
- Гадаад дотоодын аялагч жуулчдад Монголын говь нутгийг сурталчлан таниулах баян үзмэртэй жишиг музей болж улмаар аймгийн эдийн засагт хувь нэмэр оруулна.
- Жилдээ 50,000 түүнээс дээш үзэгчдэд соёлын үйлчилгээ явуулах зорилготой бөгөөд, угсаатан зүй-түүхийн болон тэмээний музей, байгалийн музей гэсэн салбаруудтай ажиллана.



*Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

**2021 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 22-НД УЛСЫН КОМИСС АЖИЛЛАН БАРИЛГА  
АШИГЛАЛТАД ШИЛЖҮҮЛЭВ.**







## 2. “ДАЛАНЗАДГАД СУМЫН 1200 ХҮҮХДИЙН СУРГУУЛИЙН БАРИЛГА” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:  
БАРИЛГЫН ГҮЙЦЭТГЭГЧ:  
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ  
“ХҮННҮГИЙН ГОВЬ” ХХК  
10,211,387,025 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Даланзадгад сумын 6 сургуулийн 5 нь 2 ээлжээр хичээллэдэг, шинэ төлөвлөлтийн бүс дэх гэр хорооллуудад оршин сууж байгаа 3,193 өрхийн хүүхдүүд сургууль цэцэрлэгтээ 4-6 км холоос явдаг. Энэ нь нийтийн тээвэр хөгжөөгүй тус суманд хүүхдүүд их холоос сургууль, цэцэрлэгтээ явахад бэрхшээлтэй байдаг. Даланзадгад суманд 2,591 сурагчийн суудал дутагдаж байгаа зэрэг нөхцөл байдалд үндэслэн төслийг санаачилсан.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Даланзадгад сумын сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлж 1 ээлжээр хичээллэдэг сургуулийн тоог нэмэгдүүлэх, жил бүр хүрээгээ тэлж буй төвөөс алслагдсан гэр хорооллын хүүхдүүдийн сурах нөхцөлийг сайжруулах, сургууль цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх.

### ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Даланзадгад сумын 1200 хүүхдийн сургуулийн барилга барих” төслийг Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор 4,626,167,267 төгрөг, 2021 оны 05 дугаар тогтоолоор 5,585,219,758 төгрөгөөр санхүүжүүлэхээр тус тус батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Хүннүгийн говь” ХХК, санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар барилга угсралтын ажлыг эхлүүлэв.



*Итгэцээгд суурьилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

#### **ҮР ДҮН:**

- Даланзадгад сумын сургуулийн хүртээмж нэмэгдэнэ.
- 1 ээлжээр хичээллэдэг сургуулийн тоог нэмэгдүүлнэ.
- Анги дүүргэлтийг багасгана.
- Алслагдсан гэр хорооллын сурагчид гэртээ ойрхон сургуульд явах нөхцөл бүрдэнэ.
- 100 орчим шинэ ажлын байр бий болно

#### **2021 ОНД БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ 45%-Д ХҮРЭВ**







### 3. “ДАЛАНЗАДГАД СУМЫН 200 ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:  
ГҮЙЦЭТГЭГЧ:  
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ  
“ХАНБОГД АРВИЖИХ” ХХК  
2,197,902,731 төгрөг



#### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Даланзадгад сумын шинэ суурьшлын бүсийн хамран сургах тойргийн сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг цэцэрлэгт бүрэн хамруулж чадахгүй байгаа, зарим хүүхдүүдийн хамрагдаж буй цэцэрлэг гэрээс нь 4-6 км хол байрлалтай байдаг нь хүүхэд, гэр бүлд бэрхшээлтэй байдаг. Даланзадгад сумын Гурван сайхан, Нисэх, Баруун сайхан хорооллын хойд тал, Төгөл зэрэг алслагдсан гэр хороололд цэцэрлэгийн насны 300 хүүхэд бүртгэлтэй. Улсын стандартаар цэцэрлэгийн нэг ангид 25 хүүхэд хамрагдах ёстой байтал Даланзадгад сумын бүх цэцэрлэгийн дундаж анги дүүргэлт 40 хүүхэдтэй мөн 2020 оны байдлаар дээрх хорооллуудын 136 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа зэрэг нь сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг хүүхэд бүрд тэгш, хүртээмжтэй явуулах нөхцөл тааруу байгааг өөрчилж хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулах боломжоор хангах шаардлагатай байсан.

#### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Даланзадгад сумын сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг хүүхэд бүрд тэгш, хүртээмжтэй явуулахад дэмжлэг болох.
- Даланзадгад сумын Гурван сайхан хороололд 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга барина.

#### ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Даланзадгад сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга барих” төслийг Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2020 оны 03 дугаар тогтоолоор 450,000,000 төгрөг, 2021 оны 05 дугаар тогтоолоор 1,765,485,316 төгрөгөөр санхүүжүүлэхээр тус тус батлав.



## *Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

- Захиалагч аймгийн ЗДТГ “Даланзадгад сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга барих” ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Ханбогд арвижих” ХХК, санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар барилга угсралтын ажлыг эхлүүлэв.

### **ҮР ДҮН:**

- Даланзадгад сумын цэцэрлэгийн хүртээмж нэмэгдэнэ.
- Анги дүүргэлтийг багасгана.
- Хүүхдүүд гэртээ ойрхон цэцэрлэгт хамрагдана.
- Сургуулийн өмнөх боловсролын хоцрогдол багасна.
- 35 ажлын байр шинээр бий болно.
- Цэцэрлэгт хамрагдсан хүүхэд бүрийн тоогоор эцэг эхчүүд, асран хамгаалагч нар ажил эрхлэх боломжтой болж өрхийн орлогоо нэмэгдүүлнэ.

**2021 ОНД БАРИЛГЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ 80%-Д ХҮРЭВ.**







#### 4. “ГАСУУН СУХАЙТ БООМТЫН ХЯНАЛТЫН КАМЕРААР ТОНОГЛОГДСОН ЦАМХАГТ ХАРУУЛЫН БАЙР БАРИХ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:  
БАРИЛГЫН ГҮЙЦЭТГЭГЧ:  
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ  
ХИЛИЙН 0131 ДҮГЭЭР ЦЭРГИЙН АНГИ  
188,880,300 төгрөг



#### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Гашуун сухайт боомт нь Монгол улсын зэс, нүүрсний экспортыг гадаадын зах зээлд нэвтрүүлж буй гол боомт тул зорчих хөдөлгөөн, ачаа тээврийн ачаалал маш их байдаг. Гэтэл өнөөг хүртэл боомтын орчинд камерын хяналтын системийг шийдвэрлээгүйгээс зам тээврийн болон бусад зөрчил илрүүлэх боломж муу, хяналт шалгалтын үр дүн, иргэдийн эрүүл мэнд, эд хөрөнгөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөл боломж муутай байдаг.

#### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Гашуун сухайт боомт орчмыг камержуулж Цагаан хад сууринаас хилийн боомт хоорондын зорчигч, суудлын болон ачаа тээврийн хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулах

#### ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2020 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 03 дугаар тогтоолоор “Гашуун сухайт боомтын хяналтын камераар тоноглогдсон цамхагт харуулын байр барих” төслийг санхүүжүүлэхээр дэмжиж санхүүжилтийг батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ барилгын ажлын гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч Хилийн 0131-р цэргийн анги, санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар барилга угсралтын ажлыг 2021 онд эхлүүлэв.



*Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

#### ҮР ДҮН:

- Цагаан хад сууринаас хилийн боомт хооронд зорчиж яваа иргэд, суудлын болон ачаа тээврийн хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулна.
- Хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход дэмжлэг болно
- Хил хамгаалах үйл ажиллагаанд дорвитой дэмжлэг болно.

### 2021 ОНД БАРИЛГА АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ 100 ХУВЬД ХҮРЧ КАМЕРЖУУЛАЛТЫН АЖИЛ ХИЙГДЭЖ БАЙНА.







## 5. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЭМЭГТЭЙЧҮҮД ЗАЛУУЧУУДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ХАМТАРСАН ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ: **ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ**

ХАМТРАН САНХҮҮЖҮҮЛЭГЧ: **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, АВСТРАЛИЙН ЗАСГИЙН ГАЗАР, ДЭЛХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА, НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮҮХДИЙН САН, НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮН АМЫН САН**

НИЙТ ТӨСӨВ:	<b>12,605,198,320 ₮</b>
ГОВИЙН ОЮУ ХДС-ИЙН САНХҮҮЖИЛТ:	<b>4,686,036,140 ₮</b>
НУБ-ЫН ХҮН АМЫН САНГИЙН САНХҮҮЖИЛТ:	<b>2,993,414,100 ₮</b>
НУБ-ЫН ХҮҮХДИЙН САНГИЙН САНХҮҮЖИЛТ:	<b>778,774,400 ₮</b>
ДЭЛХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮЖИЛТ:	<b>496,468,680 ₮</b>
АВСТРАЛИЙН ЗАСГИЙН ГАЗРЫН САНХҮҮЖИЛТ:	<b>1,216,835,000 ₮</b>
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН САНХҮҮЖИЛТ:	<b>2,433,670,000 ₮</b>

### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Өмнөговь аймагт нийт 60,675 байнгын оршин суугч хүн амын гуравны нэг нь 15 хүртэлх насны иргэд, гуравны хоёр нь 15-60 насны иргэд байна. 15-34 насны залуучууд нийт хүн амын 35%-ийг, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд мөн хүн амын гуравны нэгийг эзэлдэг. Хөдөлгөөнт хүн амын тоо их, оршин суугчидтайгаа бараг тэнцүү буюу ойролцоогоор 60,000 байгаа нь хүн амын тоон хурдацтай өсөлтөд нөлөөлж байна.

Өмнөговь аймагт эхийн эндэгдэл 100,000 амьд төрөлтөд 212.9, үр хөндөлт 1,000 амьд төрөлтөд 301 байгаа нь улсын дунджаас өндөр үзүүлэлт юм.



Өсвөр насны охидын төрөлт 2016 онд 1,000 амьд төрөлт тутамд 24 байсан. Тус аймагт халдварт болон халдварт бус өвчлөл аль аль нь өндөр байгаа юм. БНХАУ-ын хилийн боомт руу өдөр бүр нүүрс тээвэрлэх 6,500 хүртэлх тооны ачааны машин зорчдог холын тээврийн зам дээрх осол гэмтлийн улмаас зам тээврийн осол гэмтэл, нас баралт өндөр байна. Умайн хүзүүний хорт хавдар нь эмэгтэйчүүдийн дунд түгээмэл тохиолддог хоёр дахь хавдар юм. Умайн хүзүүний хорт хавдрын үзлэг, оношилгоо Өмнөговь аймагт доогуур үзүүлэлттэй буюу оршин суугчдын ойролцоогоор 30 хувийг хамарч байна. Жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ), гэр бүлийн хүчирхийлэл (ГБХ) зэрэг нь улсын хэмжээнд түгээмэл, өргөн тархсан бөгөөд уул уурхайн үйл ажиллагааны оргил үед хамгийн өндөр байдаг. Нийгэм, эдийн засгийн үйлчилгээний төвлөрлийг сааруулах бодлогын хэрэгжилт эхний үе шатандаа явж байгаа бөгөөд орон нутгийн чадавхыг хөгжүүлэх, орон нутгийн түвшин дэх хөрөнгө нөөцийн дутагдалтай байдлыг шийдвэрлэх хэрэгцээ шаардлага их байна.

Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудыг дэмжих НҮБ-ын байгууллагуудын нэгдсэн хөтөлбөр нь Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Зорилт 2030, Өмнөговь аймгийн хөгжлийн стратеги, түүнчлэн НҮБ-ын хөгжлийн тусламжийн хүрээ (НҮБХТХ)-ний Үр дүн 2 (нийгмийн хамгааллыг сайжруулах, чанартай, тэгш хамруулсан нийгмийн үйлчилгээг хүргэх) болон Үр дүн 3-ыг (иргэдийн дуу хоолойг дэмжих, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх) хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулж буй хөтөлбөр юм.

Улсын хэмжээнд эхийн эндэгдэл (MMR) 2016 онд 100,000 амьд төрөлтөнд 48 байна. Гэсэн хэдий ч жирэмслэхээс хамгаалах арга хэрэгслийн хэрэглээний хувь гэр бүлтэй эмэгтэйчүүдийн дунд 2003 онд 69% байсан бол 2013 онд 54.6% болж буурсан. Үүнтэй адилаар, гэр бүл төлөвлөлтийн хангагдаагүй хэрэгцээ 2003 онд 4.6% байснаа 2013 онд 16% болж нэмэгдсэн ба 15-19 насны эмэгтэйчүүдийн дунд хамгийн өндөр (36.4%) байна. Ялангуяа үр хөндөлтийн түвшин 2008 онд 1,000 амьд төрөлтөд 169 байснаа эрс өсч 2013 онд 1,000 амьд төрөлтөд 205 ногдож байгаа нь санаа зовоож байгаа юм. Мөн өөр нэг санаа зовоож буй асуудал бол тэмбүү өвчний тохиолдол 15-24 насныхны дунд 10,000 залуу хүн амд 60.4, 25-49 насныхны дунд 10,000 хүн амд 32 байгаа явдал юм.

Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, өсвөр насныхан, залуучуудын эрүүл мэндийн асуудал маш их анхаарал татаж байна. 2016 онд эхийн эндэгдэл 100,000 амьд төрөлтөнд 212.9, ба үр хөндөлт 1,000 амьд төрөлтөнд 301 байгаа нь улсын дунджаас хамаагүй өндөр байгаа юм. Өсвөр насны охидын төрөлт 1,000 амьд төрөлтөд 24 байна.

## **ТӨСЛИЙН ЗОРИЛГО/ҮР ДҮН:**

Нэгдсэн хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд дараах үр дүнгүүд гарсан байна. Үүнд:

1. Эмэгтэйчүүд, залуучууд, өсвөр насныханд чиглэсэн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанар сайжирсан байна.
2. Бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ), умайн хүзүүний хорт хавдрын гаралт буурсан байна.
3. Умайн хүзүүний хорт хавдар зэрэг халдварт бус өвчнүүдийн илрүүлэг, эмчилгээ, зам тээврийн осол гэмтлийн үеийн эмчилгээ сайжирна.
4. Орон нутгийн түвшний засаглал бэхжиж, эрүүл мэндийн үйлчилгээний эрэлт бий болгох, хүрч үйлчлэх ажил хийгдсэн байна.
5. Залуучууд, өсвөр насныхан эрх мэдэлтэй болж залуучуудын асуудлаарх бодлого, шийдвэр гаргах үйл явцад оролцдог болсон байна.



6. Жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах ажлыг чангатгасан байна.

## ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

### Үр дүн 1: Эмэгтэйчүүд, залуучууд, өсвөр насныханд чиглэсэн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанар сайжирсан байна.

- Эх барихын тусламж үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэж, 2018-2020 онуудад Өмнөговь аймгийн хэмжээнд эхийн эндэгдэл, эхийн ноцтой хүндрэл буурсан.
  - Сүүлийн 10-аад жилийн турш эх баригч нар жирэмслэлтээс сэргийлэх суулгац суулгах ажилбар хийх боломжгүй зөвхөн их эмч хийхээр байсныг НҮБХАС бодлогын түвшний олон удаагийн уулзалт, нөлөөллийн ажлын үр дүнд эх баригчдын ажлын байрны тодорхойлолтод нэмж оруулснаар эх баригч нар тус ажилбарыг хийх боломж бүрдсэн. Бүх сумын эх баригч нар, жирэмсний хяналтад оролцож байгаа эмч, нөхөн үржихүйн асуудал хариуцсан эмч нарыг үе шаттайгаар сургасны үр дүнд анхан шатны эмнэлэгт ажиллаж байгаа 14 сумын эх баригч, эмч нар орчин үеийн ЖСУХ болох норплант, спираль тавих, эхоны баримжаа олгох сургалтад сууж анхан шатны мэдлэгийг бүрэн эзэмшсэн.
- Өмнөговь аймгийн хэмжээнд жирэмслэлтээс хамгаалах арга хэрэгслийн (ЖСАХ) хүртээмж нэмэгдэж, ЖСАХ суулгац суулгах ажилбарын тоо нэмэгдсэн.
  - БОЭТ-д Гэр бүл төлөвлөлт, зөвлөх үйлчилгээ үзүүлэх НҮЭМ-ийн цогц үйлчилгээний нэгж байгуулж эмэгтэйчүүдэд нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээ үзүүлж, эмчилгээг хүртээмжтэйгээр ая тухтай орчин нөхцөлд үзүүлэх боломж бүрдсэн. Тус төв нь нийт 160 эмэгтэйд нөхөн үрчин эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж, үр хөндөлтийн өмнөх болон дараах зөвлөгөө, гэр бүл төлөвлөлтийн арга, жирэмслэлээс сэргийлэх аргын талаарх зөвлөгөөг өгсөн.
  - Өмнөговь аймгийн БОЭТ «Нярай судлалын тасаг»-ийг анх удаад нээж ажиллуулж, дутуу нярайн уушги дэмжих "сурфактант эмчилгээ"-ний эм, бэлдмэл авахад шаардлагатай төсвийг шийдвэрлэж, нярайн эмч, сувилагч нарын мэдлэг, ур чадварыг тасралтгүй нэмэгдүүлж ажилласны үр дүнд 2017 онд 1,000 амьд төрөлтөд нялхсын эндэгдлийн түвшнийг 16.1 промил байсныг 2020 онд 11.9 болгон бууруулж, ахиц гаргахад хувь нэмэр оруулсан
  - БОЭТ болон холбогдох сумдын эрүүл мэндийн төвүүдийн чадавхыг сайжруулах зорилгоор нийт 1.3 тэрбум төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийг нийлүүлснээр аймгийн хэмжээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай хүргэх боломжийг бүрдүүлсэн.
  - Эхийн эрүүл мэнд түүн дотроо эх барихын яаралтай тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор Өмнөговь аймагт загварчилсан сургалтын өрөө, телемедицины шууд дамжуулалтын нэгжийг тус тус байгуулснаар эрүүл мэндийн байгууллагууд тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг сайжруулж, сургалтыг өөрсдийн танхимаар дамжуулан гүйцэтгэж, зайн оношилгоо, зөвлөгөөг өвчтөний орны дэргэдээс авах боломжтой болсон.





## Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

- Өмнөговь аймгийн Даланзадгад, Ханбогд, Цогтцэций, Гурвантэс өсвөр үеийн кабинетууд 12,900 өсвөр үе, залуучуудад үйлчилгээ үзүүлсэн бөгөөд үйлчлүүлэгчдийн 70 хувь нь 15-19 насныхан байсан бөгөөд 4100 залуучуудад хүрч үйлчлэх үйлчилгээ үзүүлсэн.
- Өсвөр үеийнхнийг гэр бүл төлөвлөлт болон лавлах үйлчилгээний шинэ тутмын мэдээллээр хангах оюун ухаанд суурилсан өсвөр үеийн цахим зөвлөх Мандухай чатботыг Өмнөговь аймагт ажиллуулж эхэлсэн. Үүний үр дүнд нүүдэлчин өсвөр үеийнхэн аль ч өдрийн аль ч цагт гэр бүл төлөвлөлтийн талаар үнэн зөв мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргах, жирэмслэлтээс хамгаалах хэрэгслийг үнэгүй авах, хүсээгүй жирэмслэлт, эрсдэлтэй үр хөндөлт болон БЗХӨ-өөс сэргийлэхэд цахим зөвлөхийн дэмжлэгийг авах болсон.
- Хүүхэд, залуучуудад сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төв, сэтгэл зүйч ажиллуулж эхэлсэн нь тусламж, зөвлөгөө авах хүүхдийн тоо нэмэгдэхэд нөлөөлсөн. Өмнөговь аймагт хийсэн судалгааны үр дүнд үндэслэн БОЭТ болон ХБХГХГ-ийн ажилтнууд болон нийгмийн ажилтнууд, ЕБС-ийн сэтгэцийн эрүүл мэнд, зөвлөгөө өгөх ур чадварын талаар давтан сургалтуудад хамрагдсанаар тэдний зөвлөгөө өгөх ур чадварыг бэхжүүлсэн. Аймгийн хэмжээнд нийт 145 эмч, нийгмийн ажилтан болон холбогдох бусад мэргэжилтнүүдийг өсвөр үеийн сэтгэцийн эрүүл мэнд ба мансууруулах бодис хэрэглэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтад хамруулсан.
- Сумдад бэлтгэгдсэн 152 үе тэнгийн сургагч багш нараар дамжуулан өсвөр үе, залуучуудад нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээлэл зөвлөгөө өгөх, мэдээлэл түгээсэн. Сургуульд суурилсан сургалт, бүлгийн зөвлөгөө, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээгээр дамжуулан нийт 626 залуучуудад хүрсэн байна.
- Y-Peer сүлжээний салбар клубуудыг сумдад байгуулсан нь залуусыг өсвөр үе, залуучуудад ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулахад холбон зуучлах механизмыг бүрдүүлсэн.
- БОЭТ-ийн сүлжээгээр дамжуулан сумдаас нийт 37 тохиолдолд нарийн мэргэжлийн зөвлөгөө авсан байна. Нийт 15 сумдын эрүүл мэндийн нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний талаарх шаардлагатай зөвлөгөө, мэдээллийг цахимаар, утсаар тогтмол өгч, төрөх эмэгтэйчүүдийн тасагт хянагдаж буй эмэгтэйчүүдийг аймгийн төв, хөдөө орон нутгаар ялган тусламж үйлчилгээг хүргэж эхэлсэн.
- Алслагдсан нутгийн малчдад эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх болон жирэмсэн эхчүүдийг хянахад дэмжлэг үзүүлэх зорилгоор хөтөлбөрөөс 58 багийн эмч нарын хүрч очих үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор дэмжлэг үзүүлж ажилласан.
- НҮБХАС-ийн системтэй, өргөн хүрээтэй нөлөөллийн ажлын үр дүнд Монгол улсын төрөөс жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийн хангамжид зарцуулах санхүүжилтийг ихэсгэж, 2019 оноос эхлэн улсын төсөвт санхүүжилтийг хуваарилж эхэлсэн нь тусламж үйлчилгээ сайжрахад түлхэц болсон. Энэхүү санхүүжилтийн үр дүнд эмзэг бүлгийн нийт 3,752 эмэгтэйчүүд Өмнөговь аймгийн эрүүл мэндийн 17 төвөөр нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээнд үнэ төлбөргүй хамрагдсан. Мөн өсвөр үеийн кабинетууд болон сумын бүх эмнэлгүүд жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн таван төрлийн арга хэрэгслээр (бэлгэвч, уух эм, ерөндөг, тариа, суулгац) үйлчилгээ үзүүлэх боломжтой болсон.



- Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийн чадавх бэхжүүлэх цуврал сургалтуудаар дамжуулан орон нутгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчдийн жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслээр хангах, гэр бүл төлөвлөлтийн зөвлөгөө өгөх чадавх нэмэгдсэн.
- Эрүүл мэндийн салбарын засаглал, удирдлага зохион байгуулалт, санхүүгийн хариуцлага болон яаралтай түргэн тусламж, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний талаарх сайн туршлагыг Өмнөговь аймгийн удирдлагууд Австрали улсаас суралцсан.

### **Үр дүн 2: Бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ), умайн хүзүүний хорт хавдрын гаралт буурсан байна.**

- БОЭТ-ийн Бэлгийн замын кабинетыг бүрэн ашиглалтад оруулж, ХӨСҮТ-тэй хамтран сумын эрүүл мэндийн төвүүдийн БЗДХ-аас урьдчилан сэргийлэх чадавхыг нэмэгдүүлсэн. Цогтцэций, Ханбогд, Цогт-Овоо сумдын БЗДХ-ын тусламж үйлчилгээний менежмент ийн бүртгэл, тайлангийн аргачлалд үсрэнгүй ахиц гарсныг ЭМЯ онцолсон. БЗДХ-ын тандалт судалгаа, оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн нийт 150 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг шаталсан сургалтуудаар дамжуулан чадавхжуулсан.
- Үр дүнд БЗДХ-ын оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх чиглэлээр сүүлийн үеийн оношилгооны арга зүй, эрт илрүүлэг, оношилгооны чадвар нэмэгдсэн бөгөөд илрүүлэг хөтөлбөр хэрэгжилтийн өмнөх үеэс гурав дахин нэмэгдэж, хавьтал судлал хоёр дахин нэмэгдэж, ELIZA аппарат ашиглах, оношлох чадвар зуун хувь нэмэгдсэн байна. Жирэмсний хяналтад орсон эмэгтэйчүүдийг зуун хувь тэмбүү илрүүлэх шинжилгээнд хамруулж, илэрсэн тохиолдол бүрийг хавьтлыг хавьтлын хамт зуун хувь эмчлэн эрүүлжүүлсэн.
- Аймгийн хэмжээнд анх удаа урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж, нөхөн үржихүйн насны бүх эмэгтэйчүүдийг БЗДХ-ын шинжилгээ болон эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд үзлэгт бүрэн хамруулж, үзлэгээр илэрсэн өвчлөлийг бүрэн эмчилгээнд хамруулан, хавьтал илрүүлэх, эмчлэх ажлыг зохион байгуулсан нь ЭМЯ-ны Тэмбүү өвчний эсрэг санаачилгыг дорвитой хэрэгжүүлэн бусад аймагт үлгэр жишээ болохуйц туршлагыг хуримтлуулсан, бусад сумдад өөрийн хүчээр ХӨСҮТ-ийн аргачлалаар илрүүлэг шинжилгээ хийх чадавх бүрдсэн.
- БОЭТ-ийн болон сумын ЭМТ-үүдийн нийт 22 эмч, эх баригч нарт тэмбүү, ХДХВ, гепатитын халдвараас урьдчилан сэргийлэх тухай ажлын байран дахь системчилсэн сургалтуудад хамрагдсан.
- ХӨСҮТ-ээс тогтмол хяналт тавьж, дэмжиж ажилласны үр дүнд 14 сум, дөрвөн өрхийн эрүүл мэндийн төвийн мэдээллийг аймгийн Эрүүл мэндийн газар БЗДХ/ХДХВ, БЗДХ -ын тандалтын мэдээллийн тайланг тогтмол өгч хэвшсэн.

### **Үр дүн 3: Умайн хүзүүний хорт хавдар зэрэг халдварт бус өвчнүүдийн илрүүлэг, эмчилгээ, зам тээврийн осол гэмтлийн үеийн эмчилгээ сайжирна.**

- 2018 онд батлагдсан умайн хүзүүний хорт хавдрын өвчлөл, нас баралтыг бууруулах үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу аймгийн



түвшинд дэд төлөвлөгөө гаргаж, умайн хүзүүний хорт хавдрын эсрэг үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлсэн. Улмаар 14 сумын халдварт болон халдварт бус өвчнийг илрүүлэх цогц үзлэгийн хүрээнд 30 ба түүнээс дээш насны зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн 57.3 хувь нь умайн хүзүүний хорт хавдрын шинжилгээнд хамрагдсан.

- Аймгийн 15 сум явуулын, хөдөлгөөнт эрүүл мэндийн технологийг ашигладаг болсны үр дүнд анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид чухал нөлөө үзүүлэх боломж бүрдсэн байна. Улмаар явуулын эрүүл мэндийн тусламж технологийг эрүүл мэндийн анхан шатанд бүх сумдад нэвтрүүлсэн аймаг болсон.
- ДЭМБ-ын удирдлага дор БОЭТ болон Ханбогд, Цогтцэций, Номгон сумдын СДЭ-ийн анхан шатны болон мэс заслын тусламж үзүүлэх багийнхны чадавх сайжирсан.

#### **Үр дүн 4: Орон нутгийн эрүүл мэндийн салбарын засаглал, чадавх бэхэжсэн байна.**

- БОЭТ-ийн эмнэлгийн захиргаа, удирдлагад үйлчлүүлэгчийн бүртгэл, үйлчилгээг сайжруулахад туслалцаа үзүүлж, эмнэлгээр үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг сайжруулахад чиглэсэн санаачилгыг нэвтрүүлсэн бөгөөд энэхүү үйл ажиллагаа нь иргэд, олон нийтийн оролцоотойгоор орон нутгийн засаглал, хариуцлагыг бэхжүүлж, эрүүл мэндийн зохистой үйлчилгээг хүргэхэд эмнэлгүүдийн чадавхыг бэхжүүлсэн.
- Орон нутгийн засаглал, манлайллыг дэмжих зорилгоор аймгийн түвшинд хүүхдэд ээлтэй орон нутаг сургалтыг аймгийн холбогдох удирдлага, мэргэжилтнүүд, төрийн албан хаагчид, бүх сумдын удирдлагууд, боловсрол, эрүүл мэнд, хүүхэд, гэр бүл, залуучуудын газар хэлтсийн дарга нар, сургуулийн захирлууд, нийгмийн ажилтнуудад шаталсан сургалтад хамруулсан нь хүүхдийн эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний бодлого хэрэгжүүлэгч байгууллагууд хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах гол түлхэц болсон.
- Засгийн газрын 163 тоот тогтоолын дагуу Осол, гэмтлээс сэргийлэх Аймгийн зөвлөлийг анх удаа байгуулж анхны хуралдаанаар аймгийн хэмжээнд зам тээврийн осол гэмтлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан.
- Төлөвлөгөөний дагуу зам тээврийн ослыг бууруулах, замын аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр сумын засаг даргаар ахлуулсан салбар дундын ажлын хэсэг орон нутагт тогтвортой ажиллаж эхэлсэн. Боловсролын байгууллагуудын ойролцоох замын аюулгүй байдлыг нэмэгдүүлэхээр эцэг эх, багш нартай хамтран Сургуулийн цагдаа хөтөлбөрийг сумын сургууль, цэцэрлэгүүдэд амжилттай хэрэгжүүлсэн.

#### **Үр дүн 5: Залуучууд, өсвөр насныхан эрх мэдэлтэй болж, залуучуудын асуудлаар бодлого, шийдвэр гаргах үйл явцад оролцдог болсон байна.**

- Багш нарын заах аргазүйг шинэчлэх, шаталсан сургалтуудад хамруулах замаар эрүүл мэндийн хичээлээр дамжуулан бэлгийн цогц боловсрол (БЦБ) олгох сургалтын хөтөлбөрийг боловсруулах мөн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажилласан ба Өмнөговь аймагт эрүүл мэндийн жишиг кабинетыг байгуулсан. Сургалтын интерактив орчныг бүрдүүлснээр хичээлийг улам сонирхолтой болгож багш, сурагч хооронд идэвхтэй харилцаа өрнөн сурагчдын оролцоо сайжирсан. НХ-ийн хүрээнд өсвөр үеийнхэнд БЦБ олгохоос гадна мэргэжил сонгоход нь дэмжлэг үзүүлэхэд багш





нарыг бэлтгэн сургасан хүчин чармайлтын үр дүн салбар дундын хамтын ажиллагаа сайжирсан. Аймгийн багш, арга зүйч нарт эрүүл мэндийн хичээл заах талаар аргачлал эзэмшүүлэх сургалт зохион байгуулж, орон нутгийн түвшинд эрүүл мэндийн сургагч багшийг бэлдсэн

- НХ-ийн залуучуудын оролцооны механизмыг бүх түвшинд дэмжих зорилгоор Өмнөговь аймагт шинээр 3 ЗХТ-ийг Гурвантэс, Булган, Номгон сумдад байгуулсан. Тийнхүү Өмнөговь аймаг нь сумын түвшинд 6 ЗХТ-тэй анхны аймаг боллоо. ЗХТ-үүдээр дамжуулан шат шатны Засаг даргын дэргэдэх Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлүүд байгуулагдан үйл ажиллагаа нь тогтмолжиж тухайн сум, орон нутгийн хүүхэд, залууст чиглэсэн бодлого, шийдвэр гаргах үйл явцад оролцох оролцоо нь улам нэмэгдэж байна
- ЗХТ-үүдээр дамжуулан орон нутгийн 15-34 насны нийт 28,240 залуучууд, үүн дотроо ажилгүй, сургууль завсардсан, хөгжлийн бэрхшээлтэй залуус болон гэрт суугаа залуу ээж нарт зориулан амьдрах ухааны сургалтууд зохион байгуулж, зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд илгээх хуудсаар өсвөр үеийн кабинет зэрэг бусад нийгмийн үйлчилгээний газруудад илгээх, дэмжих бүлгийн болон сонирхлын клубуудын үйл ажиллагаанд хамруулсан.
- Говийн бүсэд, ялангуяа сумын малчдад шинээр бизнес эрхлэх боломж, нөхцөлийг бүрдүүлсэн нь хөтөлбөрийн бас нэг онцлог юм. НХ нь Өмнөговь аймаг дахь залуучуудын гарааны бизнес эрхлэлтийн эко системийг сайжруулахад хувь нэмрээ оруулах тухайлбал төрийн бодлого, хууль эрхзүйн орчныг оновчтой болгох, бизнес эрхлэгчдийг дэмжигч байгууллагууд, санхүүгийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, нийгмийн бизнес эрхлэлтийн тухай ойлголт болон чиг хандлагыг тодорхойлох, байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зэргээр таатай орчин-эко системийг бий болгох, залуучуудын бизнес эрхлэгч сэтгэлгээ, урам зоригийг өдөөх, тухайн талбар дахь ололт, чиг хандлагыг гаргаж ирэх, бие даан бизнес эрхлэх сэтгэлгээг төлөвшүүлэхэд чиглэсэн олон үйл ажиллагаануудыг шат дараатайгаар зохион байгуулж олон залуучууд өөрсдийн бизнесийн санааг өргөжүүлсэн бөгөөд тухайлбал тэмээний ноосон хөнжил, тэмээний органик сүүний тос/шар тосны бүтээгдэхүүн, дээд зэргийн нэхий бүтээгдэхүүн, тэмээний сүүн чихэр, тэжээлийн тариалалт, тэмээний сүүний зайрмаг зэрэг бүтээгдэхүүнүүдээ худалдаалж байна.
- Өмнөговь аймгийн бүх сургуульд байгуулагдсан Хүүхэд хөгжлийн төвийн “Миний гэр бүл”, “Миний ертөнц” хөтөлбөрөөр дамжуулан хүүхдүүдийг амьдрах ухааны сургалтад хамруулж, өсвөр насныхныг хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар дамжуулан чадавхжуулж байна. Аймгийн бүх сургуулийн нийгмийн ажилтнууд амьдрах ухааны сургалтуудыг заах чадавхыг бэхжүүлсэн.

**Үр дүн 6: Жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ), гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах ажлыг чангатгасан байна.**

- “Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд тусламж үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээний төв” (НЦҮТ) үзүүлэх хууль эрхзүйн орчныг бүрдүүлсэн. Ийнхүү Өмнөговьд НЦҮТ байгуулсан нь хуулийн хэрэгжилтийг хангах, бусад аймаг, дүүрэгт туршлага болохуйцаар хэрэгжсэн. Гэр бүлийн, бэлгийн хүчирхийлэлд өртсөн насанд хүрэгч болон хүүхдийг хэвийн байдалдаа эргэн ороход дэмжин туслахад нийгмийн, халамжийн, эрүүл мэндийн,



## *Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

сэтгэл зүйн, хууль эрх зүйн салбар дундын оролцоог зангидсан зохион байгуулалт бүхий НЦҮТ тогтмол үйл ажиллагаатай болсон.

- ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх механизмыг боловсролын орчинд бүрдүүлэх зорилго бүхий “Аюулгүй сургууль” аргачлалыг Өмнөговь аймгийн Даланзадгад сумын ерөнхий боловсролын 1, 3, 4, 5, 7-р сургууль, Ханбогд сумын 2-р сургууль, Цогтцэций сумын 1-р сургууль, Гурвантэс сумын сургуулиудад тус тус хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийн үр дүнд хүчирхийллээс ангид боловсролын орчныг бий болгож, сургуулийн ажилтан, эцэг эх, сурагчдыг сургах замаар нийгэм дэх хүчирхийллийг бууруулахад хувь нэмэр оруулсан.

### **COVID-19 бэлэн байдал**

“Ковид-19” халдварт өвчний эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдал хангах, хүн амыг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор орон нутагт сургагч багш бэлтгэсэн. 82 сая төгрөгийн өртөг бүхий эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж, ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис Өмнөговь аймагт хүлээлгэн өгсөн.



## САНХҮҮЖИЛТИЙН КВОТ

### САНХҮҮЖИЛТИЙН КВОТ, ЗОРИЛГО

Тогтвортой хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдэд олгох жилийн нийт санхүүжилтийн тодорхой хэсгийг Түншлэгч болон уул уурхайгүй сумдад (хамтад нь “Зорилтот сумд” гэх) квот тогтоон хуваарилах замаар сумдын удирдлага, иргэдийн оролцоонд тулгуурлан тэдгээр сумдын болон Өмнөговь аймгийн нийт иргэд, онцгойлон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настнууд, тусгай дэмжлэг шаардлагатай хүмүүсийн амьдрал ахуй, биеийн эрүүл мэнд болон эдийн засгийн сайн сайхан байдлыг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдэд зарцуулах, хуваарилахыг эрмэлзэнэ.

Тухайн жилд Түншлэгч болон уул уурхайгүй сумдад дээрх зорилгоор хуваарилах санхүүгийн дэмжлэгийн хэмжээг дараах байдлаар тогтооно:

- Ханбогд сум 70,000 ам.доллартой тэнцэх төгрөгийн санхүүжилтийн квот
- Манлай, Баян-Овоо, Даланзадгад сумд 50,000 ам.доллартой тэнцэх төгрөгийн санхүүжилтийн квот
- Уул уурхайгүй сумд тус бүр 30,000 ам.доллартой тэнцэх төгрөгийн санхүүжилтийн квот


№	Зорилтот сумын нэр	2021 онд ХДС-аас хуваарилсан санхүүжилт	2020 оноос шилжиж орж ирсэн үлдэгдэл санхүүжилт	2021 онд нийт хуваарилах боломжтой санхүүжилт	2021 онд хуваарилж зарцуулсан санхүүжилт	Үлдэгдэл санхүүжилт
1	Ханбогд сум	199,486,700	10,385,836	209,872,536	187,535,580	12,876,491
2	Манлай	142,490,500	182,565	142,673,065	142,298,525	374,540
3	Баян-Овоо	142,490,500	16,765,225	159,255,725	142,000,000	17,255,725
4	Даланзадгад	142,490,500	23,729,400	166,219,900	63,500,000	83,723,930
5	Баяндалай	85,494,300	644,481	86,138,781	51,000,000	35,138,781
6	Сэврэй	85,494,300	2,019,200	87,513,500	86,090,000	1,423,500
7	Булган	85,494,300	688,145	86,182,445	39,456,500	46,725,945
8	Номгон	85,494,300	614,800	86,109,100	83,000,000	3,109,100
9	Цогт-Овоо	85,494,300	7,115	85,501,415	84,988,115	513,300
10	Мандал-Овоо	85,494,300	1,863,120	87,357,420	77,920,000	9,437,420
11	Хүрмэн	85,494,300	4,149,701	89,644,001	0	89,644,001





## Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

- Өмнөговь аймгийн уул уурхайн үйл ажиллагаа явагддаггүй сумд 2018-2021 онуудад тус бүр нийт 316.6 сая ₮ буюу 120 мянган Ам.долларын санхүүжилтийн квот хүлээн авч төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн
- Түншлэгч Даланзадгад, Манлай, Баян-Овоо сумд тус бүр 2018-2021 онуудад тус бүр нийт 527.8 сая ₮ буюу 200 мянган Ам.долларын санхүүжилтийн квот хүлээн авч төсөл хөтөлбөр санхүүжүүлсэн
- Түншлэгч Ханбогд сум 2018-2021 онуудад нийт 738.9 сая ₮ буюу 280 мянган Ам.долларын санхүүжилтийн квот хүлээн авч төсөл хөтөлбөр санхүүжүүлсэн



- Санхүүжилтийн квот хүлээн авсан Түншлэгч сумд
- Санхүүжилтийн квот хүлээн авсан уул уурхайн үйл ажиллагаа явагддаггүй сумд
- Санхүүжилтийн квот хүлээн авдаггүй/хамтарсан санхүүжилт болон Өмнөговь аймгийн сумдыг нийтэд нь хамарсан төслийн санхүүжилт хүлээн авдаг уул уурхайн үйл ажиллагаа явагддаг сумд



## 2021 ОНД ХАНБОГД СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТЭСЭЛ:

### 1. “ЦЭМЦГЭР ХАНБОГД” ТЭСЭЛ

ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЗДТГ

“ХАНБОГД ХОТ ТОХИЖИЛТ” ОНӨААТҮГ

70,000,000 төгрөг



#### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- 2020 онд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр Ханбогд суманд “Хог хаягдлын ландфиллын байгууламж барих төсөл”-ийг 591,4 сая төгрөгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлсэн. Гэвч тус сумын одоогийн хог хаягдлыг булшлаагүй удсанаас их хэмжээгээр хуримтлагдсан, сумын ойр орчимд ил задгай хог хаягдал ихтэй болсон, ангилан ялгалт хийгддэггүйгээс тэсэрч дэлбэрэх, хорт бодисын аюултай хог хаягдал хөрс, агаар орчныг бохирдуулсаар байгаа. Тиймээс сумын одоогийн хог хаягдлыг ангилан ялгах, булшлах зайлшгүй шаардлагатай байсан.

#### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Ханбогд сумын хог хаягдлын цэг болон сумын ойр орчмоор ил задгай хаягдсан хог хаягдлыг ангилан ялгаж булшлах

#### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- 80м\*80\*4м котлован бүхийн хогийн цэг шинээр байгуулсан. Хуучин хогийг булшилсан.



### ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчин нөхцөл сайжирна.
- Суурин амьдралын сайн жишиг бий болж иргэд амьдрах орчноо сайжруулахад илүү хамтран оролцдог болно.
- Ил задгай хог хаягдал буурч агаар, орчны бохирдол буурахад дэмжлэг болно.

### СЭТГЭГДЭЛ “Ханбогд хот тохижилт” ОНӨААТҮГ-ын захирал Д.Эрхэмбаатар:



*“Цэмцэгэр Ханбогд” төслийг санхүүжүүлэн сумын төвийн ил задгай хог хаягдалтай байсан хогийн цэгийг буушилж, шинэ хогийн цэгийг байгуулахад мөн хогийн цэг хариуцсан ажилтны ажлын байрыг бий болгоход хүндтэй хувь нэмэр оруулсан “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн хамт олондоо талархал илэрхийлье. Энэхүү төслийн үр дүнд сумын төвийн хог хаягдлын үйлчилгээ цогцоор шийдэгдсэн бөгөөд цаашид иргэд, аж ахуй нэгжүүд хог хаягдлаа ангилан ялгаж хэвишхээс гадна ахуйн хог хаягдлыг*

*шинэ хогийн цэг дээр хаях, идэвхгүй хог хаягдлыг ахуйн хогтой холихгүй зориулалтын цэгт хаядаг болох зэргээр хүн амын төвлөрөл суурьшил ихтэй манай суманд хог хаягдлын менежментийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал дэмжлэг болох юм.*





## 2. “ГАДНА ТОХИЖИЛТ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЗДТГ

ИРГЭН Н.ӨЛЗИЙБАЯР

21,025,580 төгрөг



### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- 2018 онд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр “Ханбогд сумын 640 хүүхдийн сургууль, 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга”-ыг барьж ашиглалтад шилжүүлсэн. Тус сургуулийн гадна талбайд сурагчид хичээлийн завсарлагаагаараа агаарт гарах, амрах, тоглох талбай орчин бүрдээгүй байсан тул сургуулийн захиргаанаас төслийг санаачилсан. Хүүхдүүд долоо хоногийн 5 өдөр ихэнх цагаа сургууль дээрээ өнгөрүүлдэг тул тэдэнд сурч боловсроход ая тухтай орчин нөхцөл бүрдүүлэх шаардлагатай юм.

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Сургуулийн гадаад орчныг өнгө үзэмжтэй орчин үеийн хэв маягт нийцүүлэн засан тохижуулах, сурагчдад ая тухтай орчинд сурч боловсрох орчин бүрдүүлэх

### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

- Ханбогд сумын 2-р сургуулийн гадна 448 м<sup>2</sup> бетон талбай, 2 ширхэг сүүдрэвч, 252 м урт, 60см өндөртэй төмөр хашлага хийж байна.

### ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Ханбогд сумын 2-р сургуулийн багш, сурагчид, ажилчдын сурах, ажиллах таатай орчин бүрдүүлэх, сурагчдын тоглож амрах талбайг нэмэгдүүлнэ.



*Итгэцээд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## **СЭТГЭГДЭЛ** Ханбогд сумын 2-р сургуулийн цахилгаанчин Н.Өлзийбаяр:



*“Товийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр сургуулийнхаа гадна хүүхэд амрах саравч хаашаа, бетон талбай зэрэг тохижилтын ажлууд хийж байна. Уг төслийг хэрэгжүүлснээр сургуулийн гадна өнгө үзэмж сайжирч сурагчдад хичээлийн завсарлагаагаараа тоглож наадах, алжаал тайлах нөхцөл боломж сайжрах юм. Санаачилсан төсөл маань дэмжигдэн амжилттай хэрэгжиж байгаад хувиасаа талархалтай байгаа.*



### 3. “САГСАН БӨМБӨГ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЗДТГ

“ХАНБОГД ХОТ ТОХИЖИЛТ” ОНӨААТҮГ

7,080,000 төгрөг



#### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Ханбогд сумын нийтийн эзэмшлийн сагсан бөмбөгийн талбайн шийд нь эвдэрсэн. Иймд тус талбайг шинэчлэн засварлаж сумын хүүхэд залуучуудын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, бие бялдар, эрүүл мэндэд нь анхаарахад дэмжлэг үзүүлэх зорилгоор төслийг санаачилсан.

#### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Сумын хөгжилд дэмжлэг болох, иргэд чөлөөт цагаа боловсон өнгөрүүлэх, зөв дадал хэвшлээр эрүүл мэнддээ анхаарах, хүүхэд, залуус спортод дурлах, хичээллэх зэрэг эерэг нөхцөлүүдийг бүрдүүлэх

#### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

- Ханбогд сумын нийтийн эзэмшлийн талбайн эвдэрсэн сагсан бөмбөгийн талбайг сэргээн тохижуулна.

#### ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Сумын хүүхэд, залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, хүүхэд залуучууд спортод дурлах, хичээллэх, иргэдэд хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, иргэд зөв дадал хэвшилтэй болох, сумын хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр оруулах зэрэг эерэг үзүүлэлтүүдийг бий болгоно.





*Итгэцлэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## 4. “ЭРДМИЙН ОРГИЛ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЗДТГ**

**ИРГЭН М.МАЖИГСҮРЭН**

**15,380,000 төгрөг**



### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- 2018 онд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр Ханбогд суманд “640 хүүхдийн сургууль, 200 хүүхдийн цэцэрлэгийг цогцолбор барилга ашиглалтад орж Ханбогд сумын 2-р сургууль, 29-р цэцэрлэгүүд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. 2021 оны байдлаар 2-р сургууль нь 794 хүүхэдтэй, 56 багш ажилчидтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Тус сургууль нь байгуулагдаад удаагүй тул номын сан нь номын төрөл, тоо цөөхөнтэй, дотор тохижилтоо хийж амжаагүй байсан.

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Сургуулийн номын санг багш, эцэг эх, хүүхэд багачуудын хүсэл сонирхол, шаардлагад нийцсэн ном товхимол, гарын авлага материалаар баяжуулж, хүүхэд хөгжих таатай орчин бүрдүүлэн, хүүхдийн ном унших сонирхлыг төрүүлэх булан байгуулах
- Номын сангийн уншлагын танхимын хэсгийн орчин бүрдүүлэн тохижуулах
- Шаардлагатай техник хэрэгслийг авч хүүхдүүд ашиглахад тохиромжтойгоор байрлуулах
- Бага дунд ахлах ангийн заавал унших ном, уран зохиол, танин мэдэхүй, хувь хүний хөгжлийн чиглэлийн гэх мэт ном товхимол, гарын авлагууд худалдан авч сургуулийн номын сангийн нөөцийг сайжруулах



### **ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:**

- Ханбогд сумын Ерөнхий боловсролын 2-р сургуулийн номын санд 240 ширхэг ном, гарын авлага, 13 ширхэг техник хэрэгсэл, тавилга нийлүүлсэн.

### **ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:**

- Ханбогд сумын 2-р сургуулийн номын санг багш, эцэг эх, хүүхэд багачуудын хүсэл сонирхол, шаардлагад нийцсэн ном товхимол, гарын авлага материалаар баяжуулж, хүүхэд хөгжих таатай орчин бүрдүүлж хүүхдийн ном унших сонирхлыг төрүүлэх булантай болсон.

### **СЭТГЭГДЭЛ** Ханбогд сумын 2-р сургуулийн номын санч М.Мажигсүрэн:



*Манай сургууль байгуулагдаад удаагүй болохоор ном товхимол, гарын авлагын дутагдалтай байсан. “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтийн квотоор “Эрдмийн оргил төсөл”-ийн хүрээнд номын сангаа шаардлагатай ном товхимол, гарын авлага зөврийн компьютер, принтер тоног төхөөрөмжөөр хангагдсанд талархаж байна.*



*Итгэлийг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## 5. “ХАНБОГД БРЭНД БАГЦ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЗДТГ**

**ИРГЭН М.НОРОВСҮРЭН**

**10,000,000 төгрөг**



### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Ханбогд сумын онцлогтой үндэсний гар урлал, ингэний цагаан идээ гээд өвөрмөц бүтээл, бүтээгдэхүүн олон байдаг тул Ханбогдын брэндийн багцыг бий болгох нь олон эерэг нөлөөтэй юм. Сумын эрүүл хүнс үйлдвэрлэгч иргэдийн өрхийн үйлдвэрлэлийг дэмжин, тэдний тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг өгөх, өрхийн орлогыг нь нэмэгдүүлэхийн тулд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд стандартад нийцсэн дизайн, хийц савлагаатай “ХАНБОГД-БРЭНД БАГЦ”-ыг зах зээлд гаргах боломжуудыг судалж, нутгийн “Брэнд”-ийг тодорхойлон танилцуулж баталгаажуулах цаашид зах зээлд гаргах боломжийг нээх юм.

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Ханбогд сумын эко бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, өрхийн үйлдвэрлэгч, иргэн хувь хүмүүс олон байдаг ч тэдэнд бүтээгдэхүүнээ борлуулах, зах зээлд нэвтрэх боломж нь бага байдаг тул тэднийг нэгтгэн, тулгамдсан асуудлыг шийдэлд хүргэж, өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн загвар дизайн, хийц савлагаатай “ХАНБОГД-БРЭНД БАГЦ”-ыг бий болгон зах зээлд гаргах замаар ЖДҮ, өрхийн үйлдвэрлэгчид, иргэн хувь хүмүүс, малчдын өрхийн орлогыг нэмэгдүүлэх

### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

- Ханбогд сумын өрхийн үйлдвэрлэгч, малчин, хөгжлийн бэрхшээлтэй 21 иргэнийг чадваржуулах сургалтад хамруулж тэдний өөрийн гараар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг брэнд багцын баглаа, боодол, шошготой болгоно.

### ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Иргэд сургалтад хамрагдаж зах зээлд борлуулж өрхийн орлогоо нэмэгдүүлэх талаар мэдлэг, мэдээлэлтэй болох ба тэд өөрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан сав, баглаа, боодол, тодорхой гарал үүслийн шошготой болгоно.





## 6. “НЭГ ЦЭГ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:  
ГҮЙЦЭТГЭГЧ:  
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЗДТГ  
ИРГЭН Д.НАРАНСҮРЭН  
7,500,000 төгрөг



### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Сүүлийн жилүүдэд дэлхий нийтэд төдийгүй манай оронд захиргааны шинэтгэлийн хүрээнд олон чухал өөрчлөлтийг хийсний нэг нь төрийн үйлчилгээнд цахим үйлчилгээг нэвтрүүлж байна. Эдүгээ төрийн үйлчилгээг аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны гэсэн түвшнүүдэд хэрэгжүүлдэг бөгөөд төрийн үйлчилгээний дийлэнх хэсэг нь орон нутгийн Засаг даргын Тамгын газраар дамжин хэрэгжиж байна. Ханбогд сумын хувьд уул уурхай дагасан хүн амын төвлөрөл ихтэйгээс албан ёсны бүртгэлтэй 8,000 гаруй хүн ам, хөдөлгөөнт 20,000 гаруй хүн амтай томоохон сум юм. Энэ нь иргэд, аж ахуйн нэгж байгууллагад хаягийн тодорхойлолт, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн лавлагаа, жолооны үнэмлэхийн лавлагаа, цагдаагийн газрын лавлагаа, татварын лавлагаа гэх мэтээс эхлэн төрийн 65 нэр төрлийн үйлчилгээ үзүүлэхэд дараалал, хүлээлт маш их гардаг.



### **ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:**

- Төрийн үйлчилгээг цахим болгож харилцан ялгаатай чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын зардал, чирэгдлийг бууруулах, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хэрэглэгчдэд хүргэж буй үйлчилгээг ил тод, түргэн шуурхай, хунд сурталгүй болгож төрийн үйлчилгээг хөгжүүлэхэд чухал дэмжлэг болох

### **ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:**

- Ханбогд сумын Засаг даргын тамгын газарт нэг цэгийн цахим үйлчилгээ явуулахад шаардлагатай 8 ширхэг техник хэрэгсэл нийлүүлсэн.

### **ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:**

- Ханбогд сумын иргэд, бизнес эрхлэгчдийн авдаг төрийн үйлчилгээг хүртээмжтэй, түргэн шуурхай, чирэгдэлгүй, хунд сурталгүй, ил тод авахад бодитой дэмжлэг болсон.
- Харилцан ялгаатай чиг үүрэг бүхий олон төрлийн төрийн байгууллагуудын зохион байгуулалтыг сайжруулах, үйл ажиллагааны зардлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэхэд дэмжлэг болсон.

## **СЭТГЭГДЭЛ Ханбогд сумын ЗДТГ-ын архив бичиг хэргийн ажилтан Х.Түмэндэмбэрэл:**



*“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн квотын санхүүжилтээр “Нэг цэг” төслийг хэрэгжүүлж төслийн хүрээнд шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авснаар төрийн үйлчилгээний нэгдсэн ПОРТАЛ системийн 65 төрлийн үйлчилгээг цахимаар иргэд, аж ахуй нэгжид чирэгдэлгүй, хунд сурталгүй, түргэн шуурхай, ил тод байдлаар үйлчлэх боломжтой болсон. Мөн цаашид төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн ПЛАТФОРМ үйлчилгээг хэрэгжүүлснээр төрийн албаны хууль тогтоомжид нийцсэн өгөгдөл мэдээлэл солилцох боломж бий болгон, төрийн байгууллагуудын уялдаа холбоо мэдээллийн урсгалыг сайжруулах, хариуцлага, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох улмаар төрийн үйлчилгээг иргэн, аж ахуй нэгжид ил тод хүргэх боломж сайжирна.*





## 7. “МАЛЫН ИМ ТАМГА” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЗДТГ

ИРГЭН М.СҮГЛЭГМАА

25,800,000 төгрөг



### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Говь нутгийн малчдын эртнээс нааш уламжилж ирсэн мал аж ахуй эрхлэхтэй холбогдсон арвин баялаг утга, агуулгатай эд зүйлийн нэгэн хэрэглэл бол малын тамга, малын им дүрс юм. Малын им тамга нь нэгэн төрлийн бүртгэлийн тэмдэг болдогос гадна бэлгэдэл, шүтлэг бишрэлийн илрэл болсоор ирсэн. Орчин үеийн нийгмийн хөгжил, өөрчлөлтийг дагаж нүүдлийн мал аж ахуй эрхлэлттэй холбогдсон уламжлалт мэдлэг ухаанд их бага хэмжээгээр өөрчлөлт орж, тэр хэмжээгээр уламжлалт нүүдлийн мал аж ахуй, түүнтэй хамааралтай эд зүйлсийг хэрэглэх нь багасаж байгаагийн илрэл нь малын им, тамга юм. Сүүлийн жилүүдэд малчид өөрсдийн тэмээ, адууг тамгалах гэхээсээ илүүтэй тухайн малын зүснээс ялгарч харагдахуйц өөр өнгийн тосон будгаар биед нь тэмдэг тавих нь нэмэгдэж байна. Энэ нь залуу малчдын мал маллагаатай холбоотой үндэсний уламжлалт соёл, мэдлэг ухаан, арга барил улам хомсдож байгааг харуулж байгаа бөгөөд хойшид малчдад малын им, тамганы хэрэглээг нэмэгдүүлэх, түгээн таниулахаар төслийг санаачилсан.





### **ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:**

- Ханбогд сумын малчдын малын им тамганы бүртгэлийг хээрийн судалгааны үр дүнд мэдээллийн санг бий болгож нэгдсэн зурагт жагсаалтыг гаргах, нутгийн малын им тамга, түүний уламжлал, холбогдох ёс горим, бэлгэдэл зан үйлийн шинж чанар, онцлог шинжийг тодруулах, бүх малчин өрх, сумын Цагдаагийн хэлтэс, ЗДТГ болон бусад шаардлагатай талуудад үнэ төлбөргүй тараах.

### **ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:**

- Ханбогд сумын бүх малчин өрх буюу 5 багийн 671 малчин өрхүүдээр явж малын им тамганы бүртгэл, судалгаа хийх, мэдээллийн сан бий болгон ном бичиж 900 ширхэг хэвлүүлэн бүх малчин өрх, сумын Цагдаагийн хэлтэс, ЗДТГ болон бусад шаардлагатай талуудад үнэ төлбөргүй тараана.
- Одоогийн байдлаар Ханбогд сумын хэмжээнд нийт 238 малын тамга бүрдүүлээд байна. Уриалга гаргаж сумын төв дээр мал бүхий иргэдийн малын тамга бүрдүүлэх ажлыг хийж эхэлсэн. Жилийн эцсийн малын тооллоготой давхцуулан хөдөөгүүр явж малчин айлуудын тамгыг бүрдүүлээд байна.

### **ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:**

- Иргэд, малчдын уламжлалт соёлын өв, түүнтэй холбоотой ёс горим, зан үйл, дэг ёсыг сэргээн ирээдүй хойч үедээ уламжлан таниулах
- Малын им, тамганы хэрэглээг нэмэгдүүлэх, нутгийн малчид бусад айлынхаа малыг им тамгаар нь таньж эрэл суралд нь туслах
- Малчид малынхаа им, тамгыг давхцуулахгүй ашиглаж өөрийн мал гэдгийг баталгаажуулахад дэмжлэг болно.
- Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэхэд дэмжлэг болсон.
- Ханбогд сумын Засаг Даргын тамгын газар болон бусад шаардлагатай талууд бүртгэгдсэн тамганы мэдээллээр хангагдана.

## **Сэтгэгдэл:**

**Ханбогд сумын ЗДТГ-ын Хүнс жижиг дунд хоршоо хариуцсан мэргэжилтэн М.Сүглэгмаа:**



*Ханбогд сумын малын тамганы нэгдсэн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх төсөл хэрэгжиж эхэлсэн цагаас хойш тус сумын малчид, өндөр настан, ЗДТГазрын мэргэжилтнүүд энэхүү төслийн ач холбогдол үнэ цэнийг маш сайн ойлгож дэмжиж хамтран ажиллаж байна. Одоогоор бид Ханбогд сумын хэмжээнд нийт 238 малын тамганы бүртгэлийг хийгээд байгаа бөгөөд төслийн нийт ажил харахан дуусаагүй байна. Энэхүү ажлыг дэмжиж хамтран ажиллаж буй ЗДТГ болон Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн хамт олонд баярлаж талархаж байгаа илэрхийлж байна. Бид малын тамганы нэгдсэн санг бий болгосноор энэ бүс нутгийн нэг төрлийн уламжлалт соёлын өвийн баримтыг бий болгоод зогсохгүй, малчдын өдөр тутмын амьдрал дахь им тамганы хэрэглээг нэмэгдүүлэх, түүний бүртгэлийг үнэн зөв тодруулах юм.*



**Ханбогд сумын Гавилууд багийн малчин С.Өлзийсүрэн:**

Миний хувьд хүүхэд наснаасаа өнөөг хүртэл мал маллаж байна. Энэ жил “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Малын им тамга” төслийн хүрээнд бүх малчдын малын тамганы хэвийг авч ном болгон бичих гэж байгаад малчид бид баяртай байна. Ингэж тамганы хэвийг авч малчдын нэртэй нь жагсаалт мэдээлэл болгож байгаа нь цаашид малын хулгайн гэмт хэргээс сэргийлэх, бидний ирээдүй болсон хүүхэд залуучуудад үндэсний өв соёлоо таниулах, түгээн дэлгэрүүлэх, бэлгэ тэмдгийг нь ойлгуулах гэх мэт олон эерэг ач холбогдолтой ажил болж байна.





*Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## 8. “ГАР АРГААР ХУДАГ ГАРГАХ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЗДТГ

ИРГЭН Т.БАЗАРСАД

10,000,000 төгрөг



### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Ханбогд сумын Гавилууд багийн иргэн Т.Базарсад нь 2008 оноос эхлэн модны цех ажиллуулан гэрийн модон эдлэл хийж сумын иргэддээ, Оюу толгойн уурхайд модон гадас хийж нийлүүлж ирсэн гарын ур дүй, туршлагатай хүн юм. Мөн тэр гар аргаар гүний худаг ухдаг тоног төхөөрөмж зохион бүтээж өөрийн эзэмшлийн газартаа болон хавь ойрын айлууддаа гүний худаг гаргаж өгсөн туршлагатай нэгэн бөгөөд цаашид өөрийн зохиосон бүтээсэн тоног төхөөрөмжийнхөө хүчин чадлыг сайжруулахаар төслийг санаачилсан.

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Ханбогд сумын иргэн Т.Базарсад нь өөрийн зохион бүтээсэн гар аргаар худаг гаргах төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах, цаашид орон нутгийнхаа айл өрх, малчдад зах зээлийн ханшаас хямд зардлаар гүний худаг гаргаж үйлчлэх.





### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Ханбогд сумын иргэн Т.Базарсад гар аргаар худаг гаргах төхөөрөмжөө шинэчлэн сайжруулсан.

### ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Ханбогд сумын иргэн Т.Базарсад өөрийн зохион бүтээсэн гар аргаар худаг гаргах төхөөрөмжөө шинэчлэн сайжруулсан.
- Иргэд, айл өрхөд хямд зардлаар 80м хүртэл гүнтэй худаг өрөмдөж гаргаж өгөх боломжтой болсон.

### СЭТГЭГДЭЛ **Ханбогд сумын иргэн Т.Базарсад:**

Миний бие гэр бүлээрээ Өмнөговь аймгийн Ханбогд суманд ажиллаж амьдардаг. 2013 оноос “Оюу толгой” ХХК-ийн дээжийн модон гадас нийлүүлж өөрсдийн өрхийн орлогыг нэмэгдүүлсээр ирлээ. 2021 онд өөрийн турилага, арга ухаанаар гүний усыг механик аргаар гаргаж авах боломжтой тоног төхөөрөмжийг зохион бүтээх санаа анх гаргасан. Миний энэ санал санаачилгыг өндрөөр үнэлж “Говийн Оюу” сангаас бодит ажил болгоход санхүүгийн дэмжлэг үзүүлсэн нь цаашидаа сум орон нутгийнхаа айл өрхүүдэд тухайн тоног төхөөрөмжийг хийж өгөх боломж бүрдэж байна. Мөн гэр бүлийн өрхийн орлогоо нэмэгдүүлэх, сум орон нутгийн айл өрхүүдэд хямд зардлаар гүний худаг гаргаж өгөх зэрэг боломж бүрдэж байгаа нь бидэнд маш том дэмжлэг боллоо.

Та бүхний маань ажил үйлс амжилт бүтээлээр дүүрэн байж, цаг ямагт дэлгэрэн хөгжихийн ерөөл дэвшүүлье.





*Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## 9. “БАГТ МОД ТАРИХ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЗДТГ**

**ИРГЭН Б.ШИНЭБАЯР**

**9,750,000 төгрөг**



### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Ханбогд сумын Жавхлант багийн төв нь Цагаан хад боомтын нүүрс тээврийн зам дагуу байрладаг тул тус багийн газар нутаг бүхэлдээ маш их талхлагдаж, эвдэрч, доройтож байна. Иймд цаашид газрын доройтол, агаарын тоосжилтыг бууруулахад дэмжлэг болгох зорилгоор мод сөөг тарьж ногоон зурвас байгуулах ажлыг эхлүүлэх шаардлагатай байна.

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Ханбогд сумын Жавхлант багийн төвд мод тарих бөгөөд энэ үйл ажиллагаа нь цөлжилтийг бууруулах, экологийн тэнцвэрт байдлыг хадгалахад дэмжлэг болох замаар байгаль орчноо хамгаалах

### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Жавхлант багийн төвд 1 га газрыг хашаажуулан 200 ш /улиас, жигд, хайлаас, сухай/ мод, бут сөөг тариалах, усалгааны систем, нөөцийн сав байршуулсан.

### ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Ханбогд сумын Жавхлант багийн төвд мод тарих бөгөөд энэ үйл ажиллагаа нь цөлжилтийг бууруулах, экологийн тэнцвэрт байдлыг хадгалахад дэмжлэг болох замаар байгаль орчноо хамгаалах ач холбогдолтой юм.



## Сэтгэгдэл Ханбогд сумын Жавхлант Багийн засаг дарга Э.Жамбалсанж:

Манай багийн иргэн Б.Шинэбаяр нь багийн төвд ногоон байгууламж байгуулах төсөл санаачилж түүнийг нь Говийн оюу хөгжлийг дэмжих сангаас дэмжиж уг төсөл амжилттай хэрэгжиж байгаад талархалтай байна. Цаашид улам өргөжин үргэлжлүүлж багийн төв маань ойн төгөлтэй болно гэдэгт итгэлтэй байна.







*Итгэцээд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## 10. “БАЯН ДЭЛГЭРЭХ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЗДТГ**

**ИРГЭН Д.ХИШИГБАТ**

**11,000,000 төгрөг**



### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Ханбогд сумын газар нутагт төрөл бүрийн бутлаг, модлог ургамлын зангилаа, үндэс, иш зэрэг байгалийн өвөрмөц тогтоц элбэг тааралддаг. Тус сумын иргэн Д.Хишигбат дээрх байгалийн бүтээлүүд болон ан амьтны эвэр ашиглан янз бүрийн хэлбэр дүрс бүхий бэлэг, дурсгалын бүтээл урлах сонирхолтой нэгэн бөгөөд 2021 онд сумын төвдөө жижиг байшин барьж өөрийн хийсэн бүтээлээр байгалийн музей гаргаж сумынхаа хүүхэд залуучууд, иргэд цаашлаад гадаад дотоодын аялагчдад орон нутгаа сурталчлах зорилгоор төслийг санаачилсан.

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Ханбогд сумын иргэн Д.Хишигбат нь орон нутгийн иргэд, гадаад, дотоодын аялагчдад өөрийн урласан бүтээлээ таниулах, иргэд, хүүхэд залуучуудад байгаль орчноо танин мэдэх, хайрлан хамгаалахад эерэг нөлөө бий болгох ач холбогдолтой юм



### **ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:**

- Ханбогд сумын төв дээр иргэн Д.Хишигбат өөрийн барьсан 49м<sup>2</sup> талбай бүхий орон нутгийн байгалийн үзмэр байгуулах барилгадаа үзмэр байршуулах шилэн хорго хийж байршуулна.

### **ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:**

- Д.Хишигбат нь орон нутгийн иргэд, гадаад, дотоодын аялагчдад өөрийн урласан бүтээлээ таниулж сайн үлгэр дуурайл үзүүлнэ.
- Иргэд, хүүхэд залуучуудад байгаль орчноо танин мэдэх, хайрлан хамгаалахад эергээр нөлөөлнө.

### **Сэтгэгдэл** Ханбогд сумын Баян багийн иргэн Д.Хишигбат:



*Миний бие өөрийн сонирхлын дагуу үндэсний онцлогтой өөрийн хийсэн гар урлалын бүтээлүүд, цуглуулсан орон нутгийн байгалийн сонин тогтоцтой бодит үзмэр болон ан амьтан ургамлын гэрэл зургаар музей гаргаж хүүхэд залуучууд, хойч үедээ танилруулахаар бэлтгэж байна. Санаачилсан төслийн саналыг маань сумын ЗДТГ-аас дэмжиж “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-аас санхүүжүүлж байгаад баярлалаа.*



*Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*



## 2021 ОНД МАНЛАЙ СУМД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ

### 1. “ЦЭВЭР МАНЛАЙ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

**МАНЛАЙ СУМЫН ЗДТГ**

**МАНЛАЙ СУМЫН ИРГЭН А.ГАНТӨМӨР**

**40,674,000 төгрөг**



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт эрчимтэй явагдаж байгаагаас үүдэн дэлхийн агаарын дундаж температур өнгөрсөн 140 жилийн хугацаанд 1.0 градус орчим дулаарчээ гэж дүгнэдэг. Монгол улсын хувьд дэлхийн бөмбөрцгийн хойд хагасын дундад өргөргийн туйл руу ойрхон бүсэд хамаардаг бөгөөд энэ бүсэд дэлхийн дулаарал хамгийн эрчимтэй явагдаж байгаа. Монгол улсад хийж буй ажиглалт хэмжилтээр сүүлийн 80 жилийн хугацаанд агаарын температур 2.3 орчим градусаар дулаарчээ. Өмнөговь аймгийн суурь судалгаагаар Манлай суманд унаж буй хур тунадасны хэмжээ багассан, аймгийн хэмжээнд хуурайшилтын зэргээр бага чийгтэй бүсэд хамаарч байна.
- Манлай сумын хэмжээнд унах хур тунадасны хэмжээ багассанаар төвийн хэмжээнд тоосжилт нэмэгдэх, зам талбай хэт халах зэргээр иргэдийн амьдрах орчин бохирдож эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсэж байгаа тул зам талбайг усалж чийгшүүлэх, тоосжилтыг бууруулах, нийтийн эзэмшлийн талбай дахь ногоон байгууламжийн услах давтамжийг нэмэгдүүлэхэд ашиглах техник хэрэгслээр хангах хэрэгцээ шаардлага тулгарч байна.





### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- “Цэвэр Манлай” хөтөлбөр хэрэгжсэнээр Манлай сумын төвийн өнгө үзэмжийг сайжруулах, иргэдийн эрүүл мэндийг тоосжилтоос хамгаалж цэвэр орчинг бий болгох, иргэдийн амьдрах орчны эрүүл мэндэд үзүүлэх эерэг нөлөөг сайжруулах, сумын 121.9 га нийтийн эзэмшлийн гудамж талбайг чийгшүүлэх, мод услах, арчлах, шаардлагатай тохиолдолд ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг хийхэд шаардагдах усалгааны автомашин, багаж хэрэгсэл нийлүүлнэ.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Манлай сумын Засаг даргын тамгын газарт замын тоос сорох төхөөрөмж суурилуулсан зам усалгааны автомашин, мод услах мотор, насос, зам цэвэрлэгээний багаж хэрэгслийг нийлүүлсэн.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Зам талбайг тогтмол усалж, зам дээр тогтсон шороог тогтмол цэвэрлэсэнээр сумын төвийн тоосжилт багассан
- Сумын төвийн нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг усалж тордож байна.
- Шинээр зам цэвэрлэх, мод услах хоёр ажлын байр бий болсон.

### СЭТГЭГДЭЛ **Манлай сумын иргэн А.Гантөмөр:**

*Миний хувьд 2021 онд “Цэвэр Манлай” нэртэй төслөөрөө сумынхаа хүүхэд залуучуудын чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлдэг талбай болон нийт гудамж талбай, зам ариутгах, услах, тоосжилтоос хамгаалах усалгааны машин, тоног төхөөрөмжийг авч амжилттай, үр дүнтэй ажлыг хийж гүйцэтгэж байна.*

*Та бүхэндээ цаашидын ажил, амьдралд нь хамгийн сайн сайхныг хүсье.*



*Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## 2. “ЭМНЭЛГИЙН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ САЙЖРУУЛАХ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

**МАНЛАЙ СУМЫН ЗДТГ**

**МАНЛАЙ СУМЫН ИРГЭН Д.УЛАМБАЯР**

**13,000,000 төгрөг**



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Манлай сумын эрүүл мэндийн төв нь 1938 онд байгуулагдсан бөгөөд одоогоор 21 ажилтантайгаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээг Манлай сумын болон явуулын иргэдэд үзүүлж байна. Эрүүл мэндийн үйлчилгээг ард иргэдэд үзүүлэхэд эмнэлгийн үйл ажиллагаатай холбоотой тариур, зүү, лабораторийн халдвартай хог хаягдал, цус цусан бүтээгдэхүүн гэх мэт халдвартай хог хаягдал ихээр үүсдэг. Ковид-19 цар тахалтай холбоотойгоор 2021 оны 4 сард гэхэд 146.8кг эмнэлгийн хог хаягдал гарсан байна. Эрүүл мэндийн сайдын 2017.12.12-ны А/505 тоот тушаалын дагуу хог хаягдлыг цуглуулж түр хадгалах цэгт хадгалах, түр хадгалах цэгт хог хаягдлын ариутгалын автоклаваар ариутгаж, эмнэлгийн хог хаягдлыг устгах цэгт ландфиллын аргаар булшилж устгах заавар журамтай боловч одоогийн байдлаар хог хаягдлыг түр хадгалах байр нь шаардлага хангахгүй, ариутгалын автоклав байрлуулах боломжгүй зэргээс шалтгаалан эмнэлгийн хог хаягдлыг шатааж устгаж байна. Мөн ландфиллын аргаар устгах хогийн нүх байгаа боловч газрын эвдрэл нуралтаас шалтгаалан аюултай хог хаягдлын стандартыг хангахгүй болж нохой, хүн чөлөөтэй нэвтэрч халдвар тараах эрсдэл үүсээд байна.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Эрүүл мэндийн төвөөс үүсдэг эмнэлгийн халдвартай хог хаягдлыг заавар стандартын дагуу цуглуулж, хадгалж, ариутгаж устгаж хэвших бөгөөд энэ нь халдвартай хог хаягдлыг зааврын дагуу бус устгаснаас болж эрүүл мэндийн ажилтныг халдварт өртөх эрсдэлийг бууруулах, байгаль орчин болон сумын иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг арилгах зорилготой. Зориулалтын байртай болж халдвартай хог хаягдлуудыг бүрэн халдваргүйжүүлсний дараа хогийн цэгт тээвэрлэж устгах тул ЭМТ-ийн ажилтнууд халдвартай хог хаягдалтай харьцах үед халдвар авах эрсдэлийг бууруулна.



### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Манлай сумын Эрүүл мэндийн төвд эмнэлгийн халдвартай, аюултай хог хаягдал ариутгах 5.3\*2.4м хэмжээ бүхий зөөврийн байрыг нийлүүлсэн. Улмаар хог хаягдлыг ариутгах автоклав төхөөрөмжийг байрлуулсан.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Эмнэлгийн халдвартай хог хаягдлыг цуглуулж хадгалах зориулалтын байртай болсон.
- Халдвартай хог хаягдлыг ариутгаж хэвшсэн
- Эмнэлгийн ажилтнууд халдвартай хог хаягдалтай харьцах үед халдвар авах эрсдэл буурсан.
- Хог хаягдлыг зориулалтын дагуу устгаж хэвшсэн.



Хог хаягдал хадгалах байрны өмнөх



Хог хаягдал хадгалах байрны дараах зураг

### СЭТГЭГДЭЛ **Манлай сумын Эрүүл мэндийн төвийн ариутгагч Д.Оюунчулуу:**



Манлай сумын ЭМТ нь 2021 онд “Говийн Оюу” ХДСангийн хөрөнгөөр хог хаягдлыг түр хадгалах ариутгах байртай болсон. Өмнө нь зориулалтын өрөө тасалгаагүй, хог хаягдал түр хадгалах байр маань зориулалтын бус байсан. Эмнэлгийн хаягдлыг ариутгах автоклавтай боловч өрөө хүрэлцдэггүйн улмаас хог хаягдлаа ариутгаж устгаж чадахгүй байсан. Одоо ариутгалын автоклаваа байрлуулж хогоо ариутгаад дараа нь түр хадгалах хэсэгтээ хадгалж байгаад хог хаягдал устгах цэгт аваачиж устгадаг болсон. Ингэснээр халдварын эрсдэлгүй болж ажиллах нөхцөл сайжирсан. Оюу толгой, Говийн Оюу ХДСангийн хамт олон болон сумын удирдлагууддаа баярлаж талархсанаа илэрхийлье.





*Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

### 3. “ҮДИЙН ЦАЙНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:  
ГҮЙЦЭТГЭГЧ:

МАНЛАЙ СУМЫН ЗДТГ  
“МАНЛАЙ СУМЫН ЕБС-ИЙН  
ТОГООЧ Б.ЛХАМСҮРЭН  
25,000,000 төгрөг

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:



#### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- “Тэтгэмж, мөнгөн тусламжийн хэмжээг тогтоох тухай” Улсын их хурлын 2006 оны 47 дугаар тогтоол, “Хөтөлбөр хэрэгжүүлэх тухай” Засгийн газрын 2006 оны 194 дүгээр тогтоолын дагуу ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” хөтөлбөр 2006 оноос хэрэгжиж эхэлсэн. 2019 онд УИХ-аас “Үдийн цай” хөтөлбөрийг албан ёсоор “Үдийн хоол” болгож 1-5 дугаар ангийн нэг хүүхдэд ноогдох зардал 900 төгрөг байсныг 1500 болгон нэмсэн. Мөн 6-9 дүгээр ангийн үдийн хоолны зардлыг 2022 оны 9 сарын 1-ээс, 10-12 дугаар ангийн хүүхдийн хоолны зардлыг 2023 оноос нэмэхээр болсон. “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай” хуулийн 2 дугаар зүйлд “Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний стандартын шаардлага хангасан зориулалтын байр, гал тогоо, тоног төхөөрөмж, мэргэжлийн хүний нөөцтэйгээр явуулна” гэж заасан.



- “Үдийн цай” хөтөлбөр хэрэгжилтийн үед гэрээт байгууллагын нийлүүлсэн бэлэн бүтээгдэхүүнийг сурагчдад олгодог байсан бол “Үдийн хоол” хөтөлбөрийн хүрээнд сурагчдын үдийн хоолыг сургуулийн гал тогоонд бэлтгэсэн шинэхэн хоолоор сурагчдад үйлчлэх юм. Манлай сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд сурагчдын хоол бэлтгэлийн гал тогоо байгаа боловч хуулийн дагуу сургууль өөрийн байрандаа стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэх тоног төхөөрөмж, хэрэгсэл байхгүй учраас үдийн хоол хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад бэрхшээл тулгарч байгаа юм. Тиймээс сургуулийн гал тогооны өрөөнд зориулалтын тоног төхөөрөмж нийлүүлэх шаардлагатай байна. Манлай сумын ЕБС-д 6-12 насны 234 хүүхэд суралцдаг.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Сургуулийн гал тогоонд шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлэн, стандартын шаардлага хангасан илчлэг, шим тэжээл бүхий шинэхэн хоол үйлдвэрлэн сурагчдыг хангах.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Манлай сумын цэцэрлэгт ерөнхий боловсролын сургуулийн гал тогооны өрөөнд хоол үйлдвэрлэлийн зориулалт бүхий 16 нэр төрлийн 122 ширхэг тоног төхөөрөмж, гал тогооны хэрэгслийг нийлүүлэн суурилуулсан.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Сургуулийн сурагчид үдийн хоол хөтөлбөрт хамрагдах боломжтой болсон
- Сурагчид эрүүл, аюулгүй, тэжээллэг хоол хүнсээр тэгш, хүртээмжтэй хангагдаж байна.
- Орон нутгийн бизнес эрхлэгчдийн хүнсний түүхий эдийн ханган нийлүүлэлт нэмэгдэнэ.
- Ахлах тогооч, бэлтгэгч гэсэн 2 ажлын байр шинээр бий болсон.

## Сэтгэгдэл:

### Манлай сумын ЕБС-ийн эцэг эхийн төлөөлөл Б.Даваацэрэн:

Үдийн хоол хөтөлбөртэй танилцахад 5-н цулын шөл, 3-н будааны холимог, алим, чацаргана амт чанар сайн байлаа. Гал тогоонд өгөгдөх хоолны минуттай танилцахад бүтэн сараар нь гаргаад ккал, илчлэгийг нь бүгдийг нь тооцоолон гаргасан байсан нь таалагдлаа.

### Манлай сумын ЕБС-ийн эцэг эхийн төлөөлөл Г.Оюун-Ундрах:

Үдийн хоол хөтөлбөртэй танилцахад хоолны амт чанар сайн, цагаан идээ түлхүү хэрэглэсэн нь авууштай санагдлаа. Үдийн хоолыг гал тогоондоо гурван ээлжээр хооллож, ээлж хоорондын зай нь цагийн хугацаатай, нэг ээлжинд 90 хүүхдийн дүүргэлттэй хооллож байна.



*Итгэцлэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*


#### 4. “МАЛЫН ИМ ТАМГА” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:  
ГҮЙЦЭТГЭГЧ:

**МАНЛАЙ СУМЫН ЗДТГ  
МАНЛАЙ СУМЫН ИРГЭН  
Б.ПЭРЭНЛЭЙМАА**

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

**3,000,000 төгрөг**



**ГОВИЙН ОЮУ  
ХӨГЖЛИЙГ  
ДЭМЖИХ САН**

#### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Өмнөговь аймгийн Манлай сум нь Өехий, Өгөөмөр, Жаргалант, Далай гэсэн дөрвөн багтай, тус багийн нутаг дэвсгэрт ажиллаж амьдарч буй 469 малчин өрхтэй, 2020 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр нийт 220,619 мал тоолуулж, малын тоо толгой тогтмол өссөөр байна. Сүүлийн жилүүдэд хур бороо багасаж, ган зудын давтамж ойр ойрхон тохиож байгаа нь малчдын хувьд малын хариулга маллагааг тогтмол байлгаж чадахгүйд хүргэх, малын үхэл хорогдлоос гадна салхи, шуурганд уруудуулж алдах, отор нүүдэл ихээр дамжин өнгөрөх, ирэх, явах зэргээс хамаарч малын хулгай тогтмол гарсаар байна. Иймээс мэдээлэл харилцаа хөгжсөн энэ үед малчид хоорондоо тогтмол харилцаа холбоотой байж, нэгнийхээ алдагдсан, сурагласан, олсон малын мэдээллийг цаг алдалгүй солилцож, эд малаараа хохирох болон малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлж, хоорондоо хамтран ажиллах нь чухал болоод байна.





### **ТӨСЛИЙН ЗОРИЛГО:**

- Манлай сумын 469 малчин өрхийн малын им тамга, чихлээс, тамга, утасны дугаар бүхий мэдээлэл, малын хулгайн хэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, эрхзүйн мэдээлэл, Манлай сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн мэдээлэл зэрэг малчдад хэрэгтэй тулгуур мэдээллүүдийг агуулсан гарын авлага бэлтгэн тараах.

### **ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:**

- Манлай сумын малчдын малын им тамга, бусад мэдээлэл бүхий 26 хуудас бүхий гарын авлагыг 600 хувь хэвлэн малчин өрх, мал бүхий өрх болон төрийн байгууллагад тараана.

### **ТӨСЛИЙН ҮР ДҮН:**

- Малчдын малын мэдээлэл солилцох уялдаа холбоог сайжруулна.
- Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлнэ.





Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

## 5. “ХӨГЖМИЙН БОЛОВСРОЛ ХҮҮХДИЙН ИРЭЭДҮЙ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:  
ГҮЙЦЭТГЭГЧ:

МАНЛАЙ СУМЫН ЗДТГ  
15-Р ЦЭЦЭРЛЭГИЙН БАГШ  
Д.БҮРЭНЖАРГАЛ  
8,500,000 төгрөг

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Хүүхдийн хөгжлийн 3-5 нас бол хүний амьдралын хамгийн чухал нас гэж үздэг. Бага наснаасаа дуу хөгжимд дуртай, хөгжмийн боловсрол эзэмшсэн, хөгжмийн мэдрэмж сайтай хүүхдийн сэтгэн бодох чадвар илүү хөгждөг байна. Манлай сумын 15-р цэцэрлэгийн барилгад 2019 онд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн санхүүжилтээр 100 хүүхдийн хүчин чадалтай өргөтгөлийн барилга баригдаж 200 хүүхдийг хамран сургах боломжтой болсон. Цэцэрлэгийн өргөтгөлийн барилгад шинэ урлагийн танхимтай болж, тоног төхөөрөмжтэй боловч цуурай ихтэй учир хүүхэд хөгжүүлэх, сурч боловсроход хүндрэлтэй байдаг. Урлагийн танхимаа тохижуулснаар хөгжмийн хичээлээ танхимдаа орох, хүүхдийг багаас нь урлагт дуртай болгох, орчноо мэдэрч сурах зэрэг ач холбогдолтой.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Сургуулийн өмнөх боловсрол, цэцэрлэгийн хүүхдүүдийн сурч боловсрох, хөгжих, багшийн ажиллах эрүүл тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Дуу намсгагч эсгий хавтанг урлагийн танхимд тохиромжтой хэлбэр, загвар гарган хийлгэж, урлагийн танхимын дотор хананд дуу чимээ, цуурай намсгасан.



### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Цэцэрлэгийн бага бүлгийн 40, дунд бүлгийн 50, ахлах бүлгийн 50, бэлтгэл бүлгийн 60 хүүхэд тухтай орчинд дуу хөгжмийн боловсрол эзэмших боломжтой болсон.

### СЭТГЭГДЭЛ 15-р цэцэрлэгийн багш Э.Мөнхсоёл:

2021 онд “Говийн оюу хөгжил”-ийг дэмжих сангийн санхүүжилтээр манай цэцэрлэгт урлаг заал тохижуулах төсөл хөтөлбөр хэрэгжсэн. Төсөл хөтөлбөр хэрэгжсэнээр урлаг заал өнгө үзэмжтэй болж хүүхэд сурч хөгжих сургалтын орчин сайжирч сургалт явуулахад сайнаар нөлөөлж байна.







*Итгэцээг суурьтсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## 6. “ЭРҮҮЛ ЭХ ХҮҮХЭД-ЭРҮҮЛ МАНЛАЙ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:  
ГҮЙЦЭТГЭГЧ:

**МАНЛАЙ СУМЫН ЗДТГ  
МАНЛАЙ СУМЫН ЭМТ-ИЙН  
ИХ ЭМЧ Э.БАЛЖИРМАА  
7,000,000 төгрөг**

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Манлай сумын нийт төрөлт 2018 онд 46, 2019 онд 60, 2020 онд 52 байгаа нь Өмнөговь аймгийн хүн амын тоо ойролцоо сумдын дунджаас өндөр байна. Нийт төрөлтөөс охидын төрөлт 2018 онд 1 буюу нийт төрөлтөд охидын эзлэх хувь 2.2%, 2019 онд 5 буюу 5.3%, 2020 онд 9 буюу 19.3% байгаа нь Манлай суманд охидын төрөлт ихсэх хандлагатайг харуулж байна. Нийт үр хөндөлт 2018 онд 28, 2019 онд 15, 2020 онд 6 байгаа нь хүн амын тоо ойролцоо сумдын дунджаас бага байна. Мөн 0-1 насны хүүхдийн эндэгдэл 2018 онд 2, үүнээс дутуу төрөлтөөс шалтгаалсан эрт нярайн эндэгдэл 2, 2019 онд 1, үүнээс дутуу төрөлтөөс шалтгаалсан эрт нярайн эндэгдэл 1, 2020 онд 1, үүнээс дутуу төрөлтөөс шалтгаалсан эрт нярайн эндэгдэл 1 байгаа нь дутуу төрөлт буурахгүй байгаагаас нярайн эндэгдэл буурахгүй тогтвортой байгаа сул тал ажиглагдаж байна. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанаржуулах, жирэмсний хяналтыг сайжруулах, жирэмсний эрт хяналтыг нэмэгдүүлэх, дутуу төрөлт, нярайн эндэгдлийн түвшин бууруулах зорилтын хүрээнд энэ төрлийн сургалт, мэдээлэл, сурталчилгааг эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна.



### **ТӨСЛИЙН ЗОРИЛГО:**

- Эх, хүүхэд, эмэгтэйчүүдэд зориулагдсан кабинетыг шинээр бий болгон тохижуулснаар 1 удаад 7-10 хүнийг сургалтад хамруулах ба 1 долоо хоногт 3 удаагийн сургалтаар 21-30 хүнийг сургалтад хамруулснаар эрүүл мэндийн боловсролыг олгож, жирэмсний болон төрөлтийн хүндрэл, эх хүүхдийн эндэгдэл, дутуу төрөлт, охидын жирэмслэлт, үр хөндөлтийг тодорхой түвшинд бууруулах зорилготой.

### **ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:**

- Манлай сумын эрүүл мэндийн төвд эх хүүхдийн сургалтын кабинетыг байгуулж сургалтын үйл ажиллагаанд ашиглах зурагт, иогийн гудас, дасгалын бөмбөг, муляж, эмэгтэй нөхөн үржихүйн эрхтний бүтцийг харуулсан үзүүлэн, нярайн муляж, хүчилтөрөгчийн коктейлэр нийлүүлсэн.

### **ТӨСЛИЙН ҮР ДҮН:**

- Эх, хүүхэд, эмэгтэйчүүдийн суралцах, мэдлэг, хандлага, ур чадвараа дээшлүүлэх материаллаг баазтай болсон
- Жирэмсэн эхчүүдийг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, ураг хэт томрох, төрөхийн хүндрэл зэргээс сэргийлж жирэмсний эхний, дунд, сүүлийн саруудад тохирох иогийн дасгалыг заах боломжтой болсон.
- Хүчилтөрөгчийн дутагдлаас үүсэх эмгэгүүд, эхийн уушгины цэвэрлэгээ болохоос гадна ургийн архаг бүтэлт, ургийн төрөх үеийн бүтэлт, нярайн тархины эмгэгшил зэрэг эмгэг байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хүчилтөрөгчийн коктейлээр үйлчилж байна.



Итгэцээд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

## 7. “ТҮҮХ, ӨВ СОЁЛ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

МАНЛАЙ СУМЫН ЗДТГ

МАНЛАЙ СУМЫН ИРГЭН Д.ОТГОНБАТ

13,000,000 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Сум орон нутагт уул уурхай, бүтээн байгуулалт эрчимтэй хийгдэж байгаа энэ үед эдийн засаг, нийгмийн өөрчлөлт соёлын биет болон бие бус өв, түүх уламжлалд нөлөөллөө үзүүлж байна. Орон нутгийн онцлог шинжийг агуулсан эдийн болон оюуны соёлын хэлбэрүүд бүдгэрэн гээгдэж, тэр дундаа газар нутгийн нэршил өөрчлөгдөж замхран, байгалийн болон түүхийн үнэт дурсгалууд устаж үгүй болж байна. Газар нутгийн нэр болон домог, байгалийн болон түүх соёлын дурсгалт зүйл нь тухайн нутаг оронд амьдарч ирсэн ард түмний ахуй амьдралын өвөрмөц онцлогуудтай нь нягт холбоотой учир түүх соёл, эдийн засаг, хэл, заншил, шүтлэг бишрэл, хүмүүсийн танин мэдэхүйн хэр хэмжээг тодорхойлоход чухал ач холбогдолтой мэдээллүүдийг өөртөө хадгалж байдаг онцлогтой.
- Байгалийн болон түүх соёлын дурсгалт зүйл, газар усны нэр мартагдах, түүнтэй уялдан цөөрөх, өөрчлөгдөх үйл явц хурдацтай явагдаж байгааг мэдэрч арга хэмжээ авах цаг болсон тул "Соёлын өвийг хамгаалах тухай хууль"-ийн заалтуудыг хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Орон нутгийн соёлын уламжлал, түүхийн мэдлэг түүнтэй холбоотойгоор мэдээллийн сан бүрдүүлэх, өв соёлоо хамгаалж үлдэх ажлын хүрээнд түүх соёлын өв болон газар нутгаа сайн мэддэг малчид, иргэдтэй хамтран ажиллаж түүх соёлын дурсгалт олдворт газруудын мэдээллийг сайжруулж олон нийтэд хүргэх, кадастрт оруулах, газар нутгийн нэрийн санг бүрдүүлнэ.





### **ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:**

- Сумын дурсгалт газруудын нэрийн санг бүрдүүлсэн газрын зураг хэвлүүлсэн.
- Түүх соёлын дурсгалт 8 газарт мэдээллийн самбарыг сэргээн засварлаж, мэдээллийг шинэчилсэн.
- Сумын нутаг дэвсгэрт буй 3000 орчим газрын албан ёсны нэрийн санг бүрдүүлж хадгалсан, газрын зурагт буулгаж хэвлүүлсэн.
- Дурсгалт газарт кадастрын хэмжилт хийж, зураг хийлгэсэн.

### **ТӨСЛИЙН ҮР ДҮН:**

- Сумын нутаг дэвсгэр дэх газар усны нэрийн санг бүрдүүлснээр нэр өөрчлөгдөх эрсдэлээс сэргийлсэн.
- Онцгой байдлын үед эрэл хайгуул хийхэд дөхөм болно.
- Аялал жуулчлалаар явж буй иргэдэд тухайн дурсгалт газрын мэдээллийг авах боломжтой болсон.



*Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## 8. “АХМАДЫН ӨРГӨӨНИЙ ГАДНА ТОХИЖИЛТ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

МАНЛАЙ СУМЫН ЗДТГ

МАНЛАЙ СУМЫН ИРГЭН Н.ПУНЦАГБОЛД

25,000,000 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Манлай сум нь нийт 308 ахмад настантай. 2019 онд шинэ ахмадын өргөөг барьж ашиглалтад оруулсан. Сумын ахмадын хороо нь өөрийн гэсэн санхүүжилт төсөв байхгүй зөвхөн ахмадуудын өгсөн хандиваар санхүүждэг. Одоогийн байдлаар шинэ барилга баригдсан боловч ахмадын өргөө нь гадна тохижилт хийгдээгүй, хуучин модон хашаатай байгаа. Дээрх нөхцөл байдлаас үндэслэн сумын ахмадын өргөөг бохирын шугам хоолойд холбох, гадна гэрэлтүүлэг тохижилт хийх, өргөөний гадна хашааг шинэчлэх зэргээр ахмадуудын чөлөөт цагаа өнгөрөөх таатай орчныг бүрдүүлэх хэрэгтэй байна.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Сумын нийт ахмадууд хүссэн үедээ өргөөндөө очиж санал бодлоо солилцох, тоглож наадах, ном сонин унших, эрүүл мэнд, бие бялдраа чийрэгжүүлэх зэрэг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх ахмадын өргөөг байнгын ажиллагаатай болгох зорилготой.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Манлай сумын ахмадын өргөөний гадна тохижилтын ажил гүйцэтгэж 150 метр төмөр хашаа, нэг ширхэг модон саравч байрлуулсан.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Сумын ахмад настууд болон иргэд чөлөөт цагаа өнгөрөөх аюулгүй орчинтой болсон.



## 2021 ОНД БАЯН-ОВОО СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ:

### 1. “ГОВИЙН ТӨГӨЛ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

БАЯН-ОВОО СУМЫН ЭДТГ

“ДАРХАН ТӨГӨЛДӨР ГОВЬ” ХХК

20,000,000 төгрөг



#### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Монгол орон төдийгүй дэлхийн хэмжээнд агаарын бохирдол, хүлэмжийн хийг багасгах, дулаарлыг бууруулах, байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах, ам амьтан, хөрс ургамал, хүн төрөлхтөнд эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахад чиглэсэн ажлыг ихээр хийж байна. Баян-Овоо сумын хэмжээнд ногоон байгууламж төдийлөн хангалттай байдаггүйгээс тоосжилт ихтэй, хуурайшил нэмэгдэж байна. Тиймээс сумын иргэдийн ажиллаж амьдрах таатай орчныг нэмэгдүүлэх, чөлөөт цагаа өнгөрөөх таатай орчныг бий болгох хэрэгцээ шаардлага үүсээд байна.

#### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Баян-Овоо сумын 1 га газарт ногоон байгууламж байгуулан 1500 ширхэг мод тарьж орчны агаарын бохирдлыг бууруулах, тоосжилтыг багасгах, элсний нүүдлийг тогтоох, цөлжилтийг эсэргүүцэх, чийгшүүлэлтийг нэмэгдүүлэх, дуу чимээг багасгах зэрэг байгаль экологийн тэнцвэртэй байдлыг хангахад хувь нэмэр оруулах, сумын төвийн иргэд болон хүүхдүүдийн амрах тав тухтай эрүүл, ногоон орчныг бүрдүүлэх.

#### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Баян-Овоо сумын төвийн заагдсан газарт улиас -500 ширхэг, хайлаас -500 ширхэг, агч модны 500 суулгацыг тариалан 2 нас хүрсэн модны тарьцыг хүлээлгэн өгнө.

#### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Иргэдийн амьдрах, чөлөөт цагаа өнгөрөөх таатай орчин нэмэгдэнэ.
- Тоосжилт, хуурайшилт багасна.





*Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## 2. “ЦЭВЭР СУМ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:  
ГҮЙЦЭТГЭГЧ:  
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

**БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ  
“ЭКО БАЯН-ОВОО ХОТ ТОХИЖИЛТ” ААТҮГ  
55,000,000 төгрөг**



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Баян-Овоо сумын төвлөрсөн хогийн цэг нь гадуураа хаалт хашаагүй тул малын бэлчээр, байгаль орчныг ихээр бохирдуулж, тэжээвэр мал амьтан хог хаягдлаар хооллон улмаар өвчилж хор уршиг үзүүлж байна. Одоогийн хогийн цэг нь айл өрхөөс гарч буй ахуйн хог хаягдлаас гадна малын сэг зэм болон барилгын хатуу хог хаягдал зэрэг хүн амьтан ургамлыг өвчлүүлж гэмтээх, тэдгээрийн үр удамд хор хөнөөл учруулах, байгаль орчны хэвийн төлөв байдалд сөрөг нөлөө үзүүлж байна.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Сум суурин газрын тохилог байдлыг хангах, хүрээлэн буй орчныг бохирдлоос хамгаалах.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Сумын төвлөрсөн хогийн цэгийн хашааг сайжруулан 500м урт, 20-60м өндөр суурьтай /өндөр газраа 20см, нам газраа 60см өндөртэй/, сууринаас дээш 1.1 метр өндөртэй төмөр хашааг суурилуулсан.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Хогны машин ороход хүндрэлгүй цэвэр үзэмжтэй хогийн цэгтэй болсон.
- Сумын хогийн цэгийн ойр орчмын малын бэлчээрийг хамгаалж байна.
- Мал амьтан хог хаягдлаар хооллох, хог хаягдал тараахаас сэргийлсэн.
- Хог хаягдлаас үүдэлтэй халдварт өвчнөөр өвдөх эрсдэлээс сэргийлж байна.



### 3. “ГОВИЙН ӨВ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:  
ГҮЙЦЭТГЭГЧ:  
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ  
“БАЯНТАНСАГ ЭРДЭНЭ” ХХК  
40,000,000 төгрөг



#### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Баян-Овоо суманд 2018 онд хэрэгжсэн “Цэвэр агаар” хөтөлбөрийн хүрээнд иргэдийн амрах, чөлөөт цагаа өнгөрөөх саравчуудыг сумын биеийн тамирын талбайд байрлуулсан. Гэвч цэцэрлэгт хүрээлэн хашаагүй болохоор мал, амьтан орох, хог хаягдлаар бохирдох зэргээр иргэдийн амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэхэд тав тухгүй байдлыг үүсгэж байна. Тиймээс цэцэрлэг, сургуулийн сурагчид болон залуучууд чөлөөт цагаа цэвэр агаарт зөв, боловсон өнгөрүүлэх, цэвэр аюулгүй тохилог орчныг бүрдүүлэхэд сумын биеийн тамирын талбайг хашаажуулах шаардлагатай байна.

#### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Сумын хүүхэд залуучуудыг эрүүл, тохилог орчинд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлснээр эрүүл, боловсон хүн болон төлөвших нөхцөл боломжоор хангах
- Сумын тохижилтод эерэг нөлөө үзүүлнэ.

#### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Баян-Овоо сумын биеийн тамирын талбайг тойруулан 350 метр урттай бетонон суурь бүхий төмөр хашааг суурилуулсан.

#### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Сумын иргэд чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрөөх орчин нөхцөл бүрдсэн.
- Цаашид сумын биеийн тамирын талбайд нэмэлтээр спортын талбай, тоглоомын талбай байгуулах боломжтой болсон



*Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## Сэтгэгдэл:

### Баян-Овоо сумын иргэн:

*Би дүү нараа агаарт гаргахад энэ тоглоомын талбай хашиатай болсноор илүү аюулгүй болсон санагддаг. Өмнө нь хашиаагүй учраас дүү маань гүйгээд шууд машины зам уруу гарчихдаг байсан. Хашиатай болсонд маш их баярлалаа ах эгч нартаа.*



### Сургуулийн сургалтын менежер Ч.Жавхланбаатар:

*Сургуулийн хуучин биеийн тамирын талбайг хашиалснаар сургуулийн насны хүүхдүүд чөлөөт цагаа өнгөрөөхөд боломжийн болсон байна. Одоо дараа дараагийн ажлаараа доторх талбайг илүү сайхан тохижуулах байх гэж бодож байна. Та бүхэнд ажлын ажилт хусье. Баярлалаа.*







## 4. “ЭМНЭЛГИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:  
ГҮЙЦЭТГЭГЧ:  
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

**БАЯН-ОВОО СУМЫН ЭДТГ  
“ШАНХ ЧАНДМАНЬ” ХХК  
20,000,000 төгрөг**



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Баян-Овоо сумын 2020-2024 оны Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд нийгмийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх тусламж үйлчилгээний чадавхыг нэмэгдүүлж, түргэн тусламжийн автомашины хүрэлцээг нэмэгдүүлэх талаар тусгагдсан. Энэ хүрээнд сумын иргэдэд эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг түргэн шуурхай чанартай хүргэхэд чиглэгдсэн ажлуудыг хийж байна. Ковид-19 цар тахлын нөхцөл байдал орон нутагт өдөр ирэх бүр хүндэрч, эмнэлгийн орчноос гадна гэрээр хэвтэн эмчлүүлэгчдийн тоо өсөх хандлагатай байна. Нөхцөл байдал хүндэрч түргэний тэрэг алсын дуудлага болон бусад үйлчилгээнд явсан үед гэрээр хэвтэн эмчлүүлэгчдэд цаг алдахгүй хүрч үйлчлэхэд унаа тэрэгний хүрэлцээ муугаас цаг алдах, шаардлагатай эмчилгээ үйлчилгээ хугацаандаа хүрч амжихгүй байх зэрэг эрсдэл үүсэж байна.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Эдгээр иргэд болон бусад эмнэлгийн тусламж үйлчилгээ шаардлагатай боловч гадуур эмчилгээтэй иргэдэд 24 цагийн аль ч үед түргэн шуурхай, цаг алдалгүй хүрч үйлчлэх

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Баян-Овоо сумын эрүүл мэндийн төвд иргэдэд үйлчлэхэд ашиглах бага оврын суудлын автомашиныг нийлүүлсэн.



*Итгэцлэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Гэрээр хэвтэн эмчлүүлэгч болон иргэдийн эмнэлгийн тусламж үйлчилгээг цаг хугацаандаа авах боломж бүрдсэн.
- Эмч, сувилагч нар ажлаа цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэхээс гадна тэдний ажиллах нөхцөл сайжирсан.
- Ковид цар тахлын нөхцөлд түргэний тэргээр халдвар авсан иргэд зөөвөрлөж буй тул бусад өвчтэй иргэд болон ажилчид эмнэлгийн орчинд халдвар авах эрсдэлээс сэргийлсэн.

## Сэтгэгдэл:

### Баян-Овоо сумын ЭМТ-ийн эмч Н.Өлзийсайхан



*Баян-Овоо сумын ЭМТ-д эмнэлгийн түргэн тусламжийн машин өгснөөр эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ болон бусад тусламж үйлчилгээнүүдийг цаг алдалгүй хүргэж үйлчилснээр үйлчлүүлэгч болон эмнэлгийн ажилтан бид нарын сэтгэл ханамж өндөр байна. Ковид-19 цар тахлын хүнд хэцүү үед түргэн тусламжийн машин нь гэрийн эмчилгээ үйлчилгээнд явж байхад ая тухтай, цаг алдалгүй үйлчилж байна. Та бүхний энэ сайхан үйлсэд тань ажлын өндөр амжилт, аз жаргалын дээдийг хүсэн ерөөе. Эрүүл мэндийн төлөө хамтдаа.*

### Баян-Овоо сумын иргэн Г.Долгормаа:

*Уг эмнэлэг нь ойрын дуудлагын машинтай болсноор өглөө эрт, орой түргэний дуудлага дуудахад хурдан түргэн ирж үйлчилдэг сайн талтай болжээ. Та бүхэндээ баярлаж байна.*





## 2021 ОНД ДАЛАНЗАДГАД СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ:

### 1. “ДОТУУР БАЙР-БИДНИЙ ГЭР” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЗАДГАД  
СУМЫН ЗДТГ**

ГҮЙЦЭТГЭГЧ:

**“ЗЭМҮҮ ГОВЬ” ХХК**

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

**14,500,000 ₮**



#### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Энэ оны байдлаар Өмнөговь аймгийн төв, Даланзадгад сумын ерөнхий боловсролын 1, 4, 7-р сургуулиудын дотуур байранд нийт 260 хүүхэд амьдарч байна. Гэрээсээ хол дотуур байранд байрлаж, сурч хүмүүжиж байгаа хүүхдүүдийг эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдруулах нь ихээхэн чухал байдаг. Дотуур байранд тогтмол сайжруулалт хийж спортоор хичээллэх боломж олгох, хувийн ариун цэврээ сахих өрөө гаргах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх анги танхим тохижуулах, хичээл, уулзалт хийх өрөөтэй болгох нь хүүхдүүдийн өсөлт хөгжилтөд эергээр нөлөөлдөг. Төхижилтын ажил хийх шаардлага жил бүр тулгардаг ч төсөвт тусгагдалгүй, дотуур байрны тохижилт, үйлчилгээний ажил хойш тавигдсаар байна.

#### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Даланзадгад сумын 1, 4, 7-р сургуулийн дотуур байранд шаардлагатай эд хогшил, тоног төхөөрөмж нийлүүлж хүүхдүүдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулах

#### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Халуун усны өрөөний ус халаагч, угаалгын машин, телевизор, уулзалтын өрөөний буйдан нийлүүлсэн





*Итгэцээг суурьд сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- 3 дотуур байрны 260 хүүхэд усанд орж хувийн ариун цэврээ сахих, хувцсаа угааж хэвших, олуулаа цуглаж уулзалтын өрөөнд тав тухтай амарч, хичээл хийх боломжтой болсон.

## Сэтгэгдэл

### 1-р сургуулийн дотуур байрны багш Ж.Нарантуяа



*Даланзадгад сумын Засаг даргын Тамгын газар, Говийн оюу хөгжлийг дэмжих сангаас манай сургуулийн дотуур байрны хүүхдийн сургалтын орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор угаалгын машин 2 ширхэг, ус халаагуур 2 ширхэг, сурагчдын өрөөнд буйдан өгч байрлуулан сурагчдын хэрэгцээнд бүрэн ашиглаж байна. Хөрөнгө оруулалт хийж хүүхдийн ая тухтай орчин нөхцөлийг бүрүүлсэн багш, сурагчид бид бүхэн баяртай байна.*

### Оюуны мэлмий 4-р бүрэн дунд сургуулийн 10-Б ангийн сурагч Б.Лхамсүрэн:



*Миний бие Өмнөговь аймгийн Оюуны мэлмий 4-р бүрэн дунд сургуульд суралцдаг. Та бүхэнд энэхүү сэтгэлийн үгээ илгээх сайхан мөчийн мэндийг дэвшүүлье.*

*Хүүхэд бид ирээдүйн гэрэл гэгээ, үүнийг минь дэмжиж бидний амьдрах орчныг сайжруулан, шаардлагатай техник хэрэгсэл, хэрэгцээт зүйлсээр хангасан эрхэм та бүхэндээ маш их талархсанаа илэрхийлье.*

*Бид бүхэн энэ сайхан орчиндоо ирээдүйд ихийг бүтээх хүмүүн болноо. Та бүхний ажил үйлс арвин ундарч байхыг хүсэн ерөөе.*



## 2. “СУРГАЛТЫН ТААТАЙ ОРЧИН” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН

ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

“СОФТ БЮЛДИНГ ЭФФЕКТ” ХХК

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

15,000,000 ₮



### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 24-р цэцэрлэг нь 1985 онд ашиглалтад орсноос хойш зөөлөн эдлэл, дэвсгэр бүрэн шинэчлэгдээгүй өдийг хүрсэн. Тус цэцэрлэгт Даланзадгад сумын 3, 7-р багийн нийт 250 хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байна. Цэцэрлэгийн орчин нөхцөл сургуулийн өмнөх боловсролын байгууллагын стандарт, эрүүл ахуйн шаардлагад нийцэхгүй, эцэг эхээс авсан сэтгэл ханамжийн судалгаагаар 80% нь багш нарын ур чадвар, хандлагад сэтгэл хангалуун байдаг ч сургалтын орчин нөхцөл шаардлага хангадаггүй гэсэн үнэлгээ өгсөн.
- Хивс дэвсгэр хөл доороосоо даарахгүй байх хамгаалалт болдог ч гэсэн 24-р цэцэрлэгийн хувьд олон жил ашиглагдсанаар хир тоос хуримтлагдан олон хүүхдийн хөдөлгөөний явцад агаарт тоосонцор үүсэж өвчлөл үүсгэх эх үүсвэр болж байна.



*Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

### **ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:**

- Даланзадгад сумын 24-р цэцэрлэгт эрүүл ахуйн шаардлага хангасан ноосон хивс, хивсэнцэр нийлүүлэн дэвсэж хүүхдүүдийг доороосоо жиндэж даарснаас үүдэлтэй аливаа өвчинд нэрвэгдэхээс хамгаална

### **ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:**

- Даланзадгад сумын 24-р цэцэрлэгийн анги танхим, дуу хөгжмийн заалны тайзны хэсэгт 180 метр Монгол хонины ноосон дэвсгэр, коридорт 19.2 метр хивс дэвсэж тохижуулсан

### **ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:**

- 24-р цэцэрлэгийн 28 багш, 250 хүүхдийн сурч ажиллах орчин нөхцөл сайжирсан
- 250 хүүхдийн 420 эцэг эх, асран хамгаалагчийн сэтгэл ханамж дээшилсэн
- Хивс, хивсэнцрийн тоосноос үүсэх амьсгалын замын өвчлөл багассан





### 3. “НОМАДИК ГОВЬ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН  
ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

“АФОР” ХХК

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

19,500,000 ₮



#### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Сүүлийн жилүүдэд дэлхий дахинд цахим худалдааны бизнес эрчимтэй хөгжиж хүмүүс хүссэн бараа бүтээгдэхүүнээ байгаа газраа хүргүүлж худалдан авалт хийх нь дэлгэрч байна. Манай улсын хувьд сүүлийн 2 жилд буюу Ковид-19 цар тахал гарснаас хойш цахимаар бараа бүтээгдэхүүнээ сурталчлан борлуулах үйл ажиллагаа идэвхжиж байгаа ч дотоодын үйлдвэрлэгчид бараа бүтээгдэхүүнээ борлуулах нэгдсэн суваг байхгүй, мөн цаг үеийн нөхцөл байдлаас үүдэлтэйгээр хөл хорио их болсонтой холбогдуулан борлуулалт багасаж байна. Тиймээс орон нутгийн үйлдвэрлэгчдийн бараа, үйлчилгээг сурталчлан орон нутгийн брэнд бүтээгдэхүүний худалдааг цахим хэлбэрт шилжүүлж бизнес эрхлэгчдэд нэн тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэж орлого нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага үүсэж байна.

#### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Орон нутгийн үйлдвэрлэгчдийн бараа үйлчилгээний тухай мэдээллийг төвлөрүүлсэн цахим хуудас үүсгэж орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг олон нийтэд таниулан иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ



*Итгэцлэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## **ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:**

- Орон нутгийн үйлдвэрлэгчдийн тухай мэдээлэл цуглуулж мэдээллийн бааз бүрдүүлж тэдгээрийн үйлдвэрлэж буй бараа бүтээгдэхүүний зургийг авч цахим хуудаст байршуулж [www.made-in-dalanzadgad.mn](http://www.made-in-dalanzadgad.mn) цахим хуудсыг хөтлөн ажиллах хүнийг ажиллуулна.

## **ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:**

- Даланзадгад суманд жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй 100 гаруй иргэд, аж ахуй нэгжийн 300 нэр төрлийн бүтээгдэхүүний үйлчилгээний талаар мэдээллийн бааз үүссэн байна
- Орон нутгийн брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд сурталчлах ажил хийж байна
- Бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах төвлөрсөн цахим хуудастай болсноор Даланзадгад сумын иргэд, аж ахуй нэгж, нөхөрлөл хоршооны гишүүд орлогоо нэмэгдүүлнэ

## **Сэтгэгдэл**



*Намайг Батын Отгон гэдэг. Даланзадгад сумын 6-р багийн иргэн. Би эсгийгээр чихмэл тэмээ, тэмээний дүрстэй төрөл бүрийн зээгт наамал, ширлэг ширж монгол өв соёл уламжлалыг өвлүүлэхийн зэрэгцээ өдөр тутмын хэрэгцээ болсон эсгий углааш хийж иргэдийн хэрэгцээнд нийлүүлдэг. Ингэхдээ Өмнөговьд үйлдвэрлэв дэлгүүрт бараагаа өгч заруулдаг. Дэлгүүр маань Made-in-Dalanzadgad гэсэн цахим хуудас хийж байгаад баяртай байна. Надтай адилхан гэрээр гар урлал хийдэг олон хүний барааг зарж өгөх боломж гарч байна.*





#### 4. “ЖИШИГ МАЛ ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН  
ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗДТГ  
“ДҮҮРЭН ШАРГАЛ ЭЛС” ХХК

ГҮЙЦЭТГЭГЧ:

14,500,000 ₮

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:



#### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Мал эмнэлгийн үйлчилгээ эрхлэх MNS 5368:2018 стандартад нэг малын эмчид 40,0 мянган толгой мал ноогдохоор заасан байдаг. Даланзадгад сумын хувьд 2021 оны байдлаар 627 өрхийн 136,380 толгой малтай.
- Мал эмнэлгийн ажил үйлчилгээг Мал эмнэлгийн газар үндсэн удирдлагаар ханган, хэрэгжилтийг хувийн хэвшлийн 35 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлэн ажиллаж байна. Өмнөговь аймгийн хэмжээнд 104 малын эмч мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид ажиллах стандарт байдаг ч одоогийн байдлаар 69 эмч дутагдалтай үйл ажиллагаа явуулж байна.
- Мөн Өмнөговь аймгийн хэмжээнд хүмүүс төрөл бүрийн үүлдрийн нохой, муур, загас зэрэг амьтан тэжээж, гэрийн тэжээвэр амьтад нэмэгдэж байна. Түүнчлэн эзэнгүй нохой, муур гэх мэт амьтад олон байгаа нь жижиг амьтны өвчнийг оношлох, эмчлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх мал эмнэлгийн үйлчилгээ, хоол тэжээлийн жор норм, арчилгааны болон эрүүл ахуй, ариун цэврийн дэглэм зэрэг мэргэжлийн заавар зөвлөгөө үзүүлэх үйлчилгээний хэрэгцээ нийгэмд тулгарч байна.

#### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Бүх төрлийн мал, амьтны халдварт болон халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлэх оношилгоо, эмчлэх халдварт өвчинтэй тэмцэх, мал амьтны гаралтай түүхий эдийн аюулгүй байдлыг хангах баталгаажуулах чиглэлээр стандартын шаардлага хангасан жишиг мал эмнэлгийн үйлчилгээний нэгж байгуулж тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах





Итгэцлэгд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

## ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Шаардлага хангасан жишиг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг тохижуулж шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж үйл ажиллагааг жигдрүүлэн ажиллаж байна

## ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Хөтөлбөрийн хүрээнд 3 ажлын байр бий болсон
- Малын эрүүл мэнд сайжирч малчдын амьдрал ахуй дээшилж орлого нэмэгдэнэ
- Иргэдэд эм, био бэлдмэлийн хадгалалт, хэрэглээ, мал амьтны эмийн зохистой хэрэглээг сурталчлах, нэвтрүүлэх ажил хийсэн
- Мал амьтны эрүүл мэндийг сайжруулж, эрүүлжүүлэх үйл ажиллагааг тогтмол хийнэ
- Нохой, муурын үржил хязгаарлах мэс ажилбарыг орон нутагтаа хийж гүйцэтгэн эзэнгүй нохойн муурын тоо толгойг бууруулж байна.

## Сэтгэгдэл


### Даланзадгад сумын иргэн А.Давааням

Даланзадгад суманд жижиг амьтны эмнэлэг байгуулагдаж байгаад үнэхээрийн баяртай байна. 2 нохойгоо хотоос авч ирэх гээд эрүүл мэндийн тал дээр учраа олохгүй байсан юмаа. Та нарын ажилд амжилт хүсье. Цаашидаа улам өргөжих болтугай.



### Даланзадгад сумын иргэн Энхбаатар

Нохойг минь эрүүл саруул болгож өгсөнд баяртай байна. Сайхан эмнэлэг байна. Цаашид эрүүл мэндийн үйлчилгээг танайхаар авч байх болно. Цаашидын ажилд нь амжилт хүсье.





## 5. “ДАЛАНЗАДГАДАД ҮЙЛДВЭРЛЭВ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН  
ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗДТГ  
СОНГОН ШАЛГАРУУЛЖ БАЙНА

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: 22,500,000 ₮



### ХӨТӨЛБЭРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Өмнөговь аймгийн 38 жижиг дунд бизнес эрхлэгч, Даланзадгад сумын 28 жижиг дунд бизнес эрхлэгчийг хамруулсан судалгаа хийсэн. Судалгаанаас харахад санхүү, маркетинг, үйлдвэрлэлийн менежмент, амжилттай жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд сургалтын хэрэгцээ шаардлага байгааг тодорхойлсон.
- Орон нутаг бүр өөрийн гэсэн онцлог бүтээгдэхүүнтэй байдаг. Даланзадгад сумын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг нэгтгэн кластер хэлбэрээр брэнд үүсгэн улсын хэмжээнд, цаашлаад экспортод гаргаж болохуйц бараа бүтээгдэхүүн боловсруулах боломж байгаа.

### ХӨТӨЛБЭРИЙН ЗОРИЛГО:

- Орон нутагт кластер брэнд үүсгэх, Өмнөговь аймгийн жижиг дунд бизнес эрхлэгчийг хөгжүүлж чадавхжуулах сургалт хийх, цахим орчинд борлуулалт хийх боломж бий болгох

### ХӨТӨЛБЭРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Өмнөговь аймгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүү, маркетинг, үйлдвэрлэлийн менежментийн сургалт зохион байгуулна
- Орон нутгийн онцлогийг агуулсан брэнд бүтээхэд шаардагдах ур чадварыг хөгжүүлж кластериар 3 брэнд бүтээгдэхүүн гаргана
- Цахим борлуулалтын хуудас үүсгэж хөгжүүлэх ажил хийнэ



*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

#### **ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:**

- Экспортод гаргах түвшний 3 брэнд бүтээгдэхүүнийг кластер хэлбэрээр тодорхойлон гаргаж, сав баглаа боодлоос эхлээд идэвхжүүлэлт, борлуулалт хийхэд дэмжиж ажиллаж үйл ажиллагааг тогтмолжуулна
- Кластериар үүсгэсэн брэндэд оролцогч Даланзадгад сумын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн борлуулалтыг 15%-аар өсгөнө
- Өмнөговь аймгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид Монгол орон даяар, цаашлаад экспортод бараа бүтээгдэхүүнээ гаргах боломж бүрдэнэ





## 6. “ДЭВШИЛТЭТ ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ: **ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗДТГ**  
ГҮЙЦЭТГЭГЧ: **СОНГОН ШАЛГАРУУЛЖ БАЙНА**  
ТӨСӨВ: **38,000,000 ₮**



### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- 2019 оноос эхлэн дэлхий дахинд гарсан цар тахал өвчин, мөн орчин үеийн дэвшилтэт технологи, цахимд суурилсан эринтэй хөл нийлүүлэх зорилгоор Монгол улсын засгийн газраас төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх бодлого баримтлан ажиллаж байна. Монгол улсын засгийн газраас хэрэгжүүлж байгаа бодлоготой нийцүүлэх, мөн Даланзадгад сумын иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг хөл хорионы үед ч хүртээмжтэй байлгах шаардлага багийн төвүүдэд ажиллаж байгаа албан хаагчдад өдөр тутам тулгарч байна. Одоогийн байдлаар Даланзадгад сумын 8 багийн төв дээр Засаг дарга, нийгмийн ажилтан, зохион байгуулагч, нийт 25 хүн ажиллаж Даланзадгад сумын 28361 хүнд төрийн үйлчилгээ үзүүлж байна. Гэвч техник технологи дутмагаас болж төрийн үйлчилгээ түргэн шуурхай үзүүлж чадахгүй, иргэдэд хүлээлт их үүсэж, цаашлаад халдвар хамгааллын дэглэм сахихад хүндрэл үүсэх нөхцөл бий болж байна. Тиймээс Даланзадгад сумын 8 багийн төв дээрх албан хаагчдын хэрэглэж буй тоног төхөөрөмжүүдийг шинэчлэх хэрэгцээ зайлшгүй тулгараад байна.

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Даланзадгад сумын 8 багийн төвийн үйл ажиллагааг жигд байлгаж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг түргэн шуурхай болгохын тулд шаардлагатай хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлнэ.

### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Даланзадгад сумын 8 багийн төвд 13 нэр төрлийн 36 ширхэг тоног төхөөрөмж, хэрэгслийг нийлүүлж суурилуулна.



*Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

#### **ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:**

- Даланзадгад сумын 8113 өрхийн 28361 иргэнд өгөх төрийн үйлчилгээг цахимаар орон зай үл харгалзан түргэн шуурхай хүргэдэг болно
- Албан бичиг боловсруулалт, хэвлэлт түргэн болж иргэдэд хүлээлт үүсгэхгүй хурдан шуурхай ажиллах боломжтой болно
- Багийн төвүүдэд ажиллаж буй 25 албан хаагчийн ажлын бүтээмж нэмэгдэж иргэдийн сэтгэл ханамж тэр хэмжээгээр нэмэгдэнэ.



## 7. “ХҮМҮҮНИЙ ХЭРЭГЦЭЭ ХҮЧИЛТӨРӨГЧ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:  
ГҮЙЦЭТГЭГЧ:  
ТӨСӨВ:

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗДТГ  
СОНГОН ШАЛГАРУУЛЖ БАЙНА**  
**15,900,000 ₮**



### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- “Ковид-19” цар тахал, халдварт өвчний эсрэг вакцинаар иргэдийг дархлаажуулах цэг 9 газар байгуулж 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрөөс эрүүл мэндийн салбарын ажиллагсад, хариу арга хэмжээ авах багт, 05 сарын 05-ны өдрөөс иргэдийг дархлаажуулах ажлыг зохион байгуулан ажиллаад байна. 2021 оны 07 дугаар сарны байдлаар өрхийн эрүүл мэндийн төвүүд 18-аас дээш насны иргэдийн 92.2% буюу 16167 иргэнийн 1 дүгээр тунд, 80.1% буюу 14041 иргэнийг 2 дугаар тунд, 12-17 насны 1518 хүүхдийг 1 дүгээр тунд, нийт 31726 хатгалт хийж ажилласан байна.
- Энэ хугацаанд 152 хүнд хүчил төрөгчийн хэрэгцээ гарч ам хамраар хүчилтөрөгч өгч яаралтай тусламж үзүүлсэн. Одоогийн байдлаар Даланзадгад сумын өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хүчилтөрөгчийн өтгөрүүлэгч байхгүй бөгөөд БОЭТөвийн сэхээний тасаг, хүүхдийн тасаг, “Амуу” эмнэлгээс хүчилтөрөгчийн өтгөрүүлэгч авч дархлаажуулалтад ашиглаад байна. Сүүлийн 3 жилд нийт 491 иргэнд маш яаралтай дуудлагаар хүчилтөрөгчийн дэмжлэг авах хэрэгцээ гарч байгаа бөгөөд энэ хэрэгцээ цар тахлын улмаас улам бүр нэмэгдсээр байна.

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Даланзадгад суманд хүчилтөрөгчийн өтгөрүүлэгч шаардлагатай болсон иргэдэд түргэн шуурхай хүрч ажиллахын тулд Өмнөговь аймгийн Бүсийн Оношилгоо, Эмчилгээний Төв, болон Даланзадгад сумын 3 өрхийн эмнэлэгт хүчилтөрөгчийн өтгөрүүлэгч дагалдах хэрэгсэл нийлүүлнэ.





*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

### **ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:**

- Өмнөговь аймгийн Бүсийн Оношилгоо, Эмчилгээний Төв, Шим билэг өрхийн эмнэлэг, Өнө-Орших өрхийн эмнэлэг, Энхийн хүслэн өрхийн эмнэлэгт хүчилтөрөгчийн өтгөрүүлэгч, гуурс болон бусад дагалдах хэрэгсэл нийлүүлнэ

### **ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:**

- Шим билэг өрхийн эрүүл мэндийн төвд бүртгэлтэй 10849 иргэн, Өнө-Орших өрхийн эрүүл мэндийн төвд бүртгэлтэй 8610 иргэн, Энхийн хүслэн өрхийн эрүүл мэндийн төвд бүртгэлтэй 9456 иргэн, нийт 28915 иргэнд анхан шатны тусламж үйлчилгээг түргэн шуурхай хүргэн боломж бүрдүүлнэ



## 2021 ОНД БАЯНДАЛАЙ СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ:

### 1. “ДАЛАЙ БУЛАГ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БАЯНДАЛАЙ  
СУМЫН ЗДТГ**

ГҮЙЦЭТГЭГЧ:

**ИРГЭН Б.БАЯРЖАРГАЛ**

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

**10,000,000 төгрөг**



#### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Баяндалай сум нь 1923 онд байгуулагдсан, 2100 хүн амтай. Сумын төв нь төвлөрсөн цэвэр усны шугам сүлжээнд холбогдсон хэдий ч усны нөөцийн савны багтаамж, тог цахилгааны доголдлоос шалтгаалан үе үе сумын төвөөрөө усан хангамжийн дутагдалд ордог. Энэ үед иргэд сумын төвийн урд талаар урсдаг “Далай” булгаас ундны усаа авдаг бөгөөд уг булаг нь сумын төвийн өмнө талд байдаг тул иргэд үе үе цэвэрлэгээ, арчилгаа хийдэг ч булгийг бохирдуулж булгийн эхийн ундарга дарагдаж хатаж ширгэх эрсдэл нэмэгдсээр байна. Иймд цаашид талхлагдаж бохирдсон “Далай” булгийн эхийг хашиж хамгаалах төслийг санаачилсан.

#### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Баяндалай сумын Далай булгийн эх ундаргыг сайжруулан төмөр торон хашаа барих бөгөөд энэ үйл ажиллагаа нь булаг шандын эхийг хамгаалах, сэргээх замаар байгаль орчноо хамгаалах

#### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Баяндалай сумын Далай булгийн эх ундаргыг сайжруулан хашаажуулна.



## ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Булаг шандын эхийг хамгаалах, сэргээх замаар байгаль орчноо хамгаална.
- Байгаль орчны унаган төрийг сэргээн экологийн тэнцвэрт байдалд эерэг нөлөө авчирна.


## Сэтгэгдэл:

### Баян багийн малчин Ч.Ууганбаяр:

Миний бие нь бага наснаасаа энэ голоос ус зөөж, тоглож өссөн. Одоо бидний хүүхэд байх үеэс их өөр болсон. Ус нь гүехэн нарийхан болоод, урсгал нь багасаад сэтгэл эмзэглэж явдаг байлаа. Голын усыг лайдаж цэвэрлэх төсөл хэрэгжүүлж байгааг сонсоод маш их баярлаж сэтгэлээрээ 3 хоног ажилд нь тусалж ажиллахдаа бид нар өөрсдөө л нутаг усаа хайрлаж тордохоор юм байна гэдгийг ойлгосон. Энэ маш хэрэгтэй ажлыг санаачилсан байна лээ. Нүдэн дээр л усны урсгал нь нэмэгдээд, сэтгэл санаа сайхан байсан. Хүмүүс бид жил бүр тордвол улам л сайхан болохоор юм байна. Бидний амьдралыг тэтгэх усны гол нөөц нь юм даа.



### Баяндалай сумын ЗДТГ-ын Нийгмийн ажилтан Б.Дүүрэнбаяр:



Баяндалай сум нь 1923 онд байгуулагдсан. Сумын урд талаар урсах гол буюу Далай булаг нь сумын иргэдийн ундны усны нөөц байсан. Гэвч жил ирэх тусам голын усны хэмжээ багасаж татраад байна. Усны хэмжээг хэрхэн нэмэгдүүлэх, ямар арга хэмжээ авах талаар сум орон нутаг, албан хаагчдын зүгээс гаргасан шийдвэр, зохион байгуулсан ажил тун тааруу. “Далай булаг” төслийг хэрэгжүүлэгч Б.Баяржаргал иргэний санаачилсан энэхүү төсөл нь сумын иргэдийн санаа бодолд нийцсэн, үр өгөөжтэй ажил байгаа юм. Голын урсгалаа чулуугаар хашиж өгсөн нь усны урсгал шаварт дарахаас сэргийлж өгч байна. Мөн голд тунарсан элс, шаварт дарагдсан хог, элдэв төрлийн уут хаягдлуудыг цэвэрлэж байгаа нь усны урсгалыг сайжруулж, саадгүй урсах боломжоор хангаж өгч байгаа юм. Энэхүү төсөл нь нүдэнд харагдаж, олныг хамарч байгаагаараа их давуу талтай. Байгаль орчин, экологийн тэнцвэрт байдлыг хадгалахад үр нөлөө өгнө. Нөгөө талаар хүн малын ундны усны нөөц сайжирна.





## 2. “ЖУРМЫН ХАШАА” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БАЯНДАЛАЙ  
СУМЫН ЗДТГ**

ГҮЙЦЭТГЭГЧ:

**ИРГЭН Б.ГАНБОЛД**

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

**10,000,000 төгрөг**



### ХӨТӨЛБЭРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Баяндалай сумын цагдаагийн хэсгийн барилга 2012 онд баригдаж ашиглалтад орсон бөгөөд анх ашиглалтад орох үеэсээ журамлагдсан машины болон үйлчлүүлэгчдийн авто машины зогсоолгүй, гадна хашаа, ногоон байгууламж хангалтгүй байсаар байна. Сумын цагдаагийн хэсгийн үйл ажиллагаа нь ард иргэдэд хоногийн 24 цагийн турш төрийн үйлчилгээг үзүүлдэг онцлогтой байгууллага төдийгүй ард иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд сөргөөр нөлөөлөх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчлийн гаралтын тоог бууруулахаар зорин ажилладаг чухал байгууллага юм. Цаашид тус байгууллагын үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад дэмжлэг болох зорилгоор төслийг санаачилсан.

### ХӨТӨЛБЭРИЙН ЗОРИЛГО:

- Баяндалай сумын Цагдаагийн хэсэг журмын хашаатай болж иргэдэд үйлчлэх төрийн үйлчилгээг сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн амь нас, эд хөрөнгийг хамгаалах.



## **ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:**

- Баяндалай сумын Цагдаагийн хэсгийн гадуур 81,4 м хашаа барих, 19,5м<sup>2</sup> бетон талбай хийж гадна вандан сандал-2ш, хогийн сав-1ш, мэдээллийн самбар-10ш, бичгийн шкаф-1ш алдартнуудын хүндэтгэлийн булан-1ш байрлуулах ажил хийгдсэн.

## **ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:**

- Сумын өнгө үзэмжид эерэг нөлөө гарсан.
- Журамлагдсан авто машиныг найдвартай аюулгүй, хамгаалалттай орчинд хадгалах боломж бүрдсэн.
- Иргэдэд үйлчлэх төрийн үйлчилгээг сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн амь нас, эд хөрөнгийг хамгаалахад дэмжлэг болсон.
- Цагдаагийн ажилтнуудын ажиллах орчин сайжруулсан.

## **СЭТГЭГДЭЛ** Баяндалай сумын өндөр настан Ц.Галсандорж:

2021 онд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр хэрэгжсэн “Журмын хашаа” төслийн хүрээнд сумын Цагдаагийн хэсэгт журамлагдсан тээврийн хэрэгсэл байрлуулах хашаа барьж, сумын төвийн төв замын уулзваруудад “Жолооч ах, эгч нараа Бидэнд зам тавьж өгөөч” гэсэн тэмдэглэгээнүүд байрлуулсан нь нутгийн иргэд бидэнд эрүүл аюулгүй орчинд амьдрах, эд хөрөнгийг маань хамгаалахад чухал дэмжлэг боллоо гэж харж баяртай байна. Мөн эх орон эгэл түмнийхээ төлөө өргөсөн тангарагтаа чин үнэнчээр цаг наргүй ажилладаг Баяндалай сум дахь Цагдаагийн хэсгийн хамт олондоо баярлалаа.







### 3. “ХОТ АЙЛ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:


**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БАЯНДАЛАЙ  
СУМЫН ЗДТГ**

ГҮЙЦЭТГЭГЧ:

**ИРГЭН Д.ОЮУНБИЛЭГ**

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

**15,000,000 төгрөг**



#### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Сүүлийн жилүүдийн цаг уурын эрс тэрс тогтворгүй байдлаас бэлчээрийн доройтол нэмэгдэх, худаг усны ундарга муудах зэргээр малчид, малд сөргөөр нөлөөлөх хүндрэл бэрхшээлүүд тулгарсаар байна. Баяндалай сумын Төхөм багийн Гашуун гэдэг газарт гүн нь 8м буюу 8 кольцотой богино янданд эргүүлэгтэй худагтай байсан бөгөөд эвдэрсэн учир гар худгаар ашиглагддаг болсон. Тус худгаас ойр орчмын малчин өрхүүд малаа усалдаг бөгөөд худгийн ундарга удаан учир амархан шавхагдаж зарим айлууд өнжиж малаа усалдаг. Дээрх өрхийн малчид өөрсдийн боломж нөөцөө ашиглан худаг усаа сэргээх, малын тэжээлийн ургамал тариалахаар зорин төслийг санаачилсан.

#### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Эвдэрч дарагдсан усны эх үүсвэрийг сэргээх, хамгаалах, мод, малын тэжээлийн ургамал тарих зэргээр байгаль орчны экологийн тэнцвэрийг хадгалах, нутгийн малчид өвс тэжээлийн нөөцөө бэлтгэхэд дэмжлэг болох.





## **ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:**

- Баяндалай сумын Төхөм багийн нутаг дахь Гашуун гэдэг газарт эвдэрч дарагдсан гар худгийг засварлан гадуур нь худгийн байр барих, мод услах усалгааны хоолой, мото помп, чиргүүлтэй усны сав худалдан авах, 60 ш /Чацаргана, улиас, сухай/ тарих, 60м\*70 м талбайд овьёос тариалах, тариалангийн талбайг хашаажуулах зэрэг ажлууд хийгдэнэ.


## **ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:**

- Хүн, малын усны гачигдлыг буруулж малчдын хөдөлмөр эрхлэлт, эдийн засагт эерэг дэмжлэг болсон.
- Малчид өөрсдөө орон нутагтаа малын тэжээлийн ургамал тариалах боломжтой болсон
- Цөлжилтийг бууруулах үйл ажиллагаанд дэмжлэг болсон.

## **СЭТГЭГДЭЛ** Төхөм багийн малчин Ж.Уртбаяр:

*Хот айл төсөл нь худаг гаргах, мод тарих, малын тэжээлийн ургамал тариалах тухай төсөл байсан бөгөөд төслийн үр дүнтэй танилцсан малчин хүнийхээ хувьд дараах дүгнэлтийг хийж байна. Хот айл төсөл хэрэгжсэнээр бидэнд дараах давуу талууд бий болж байна.*

- *Гашуун, Шавга толгой хавийн малчин өрхүүдийн 2000 гаруй мал усандаа ханадаг болсон.*
- *Малын тэжээлийн ургамлыг уг худагт түшиглэн тариалж эхний жилийн суулгацаа суулгаж, тариалж үзсэн нь дараа дараагийн жил илүү өсөн нэмэгдүүлж тарих боломжтой байгаа*
- *Газар хашиж мод тарьснаар цөлжилтөөс бага ч болтугай сэргийлж байгаа*
- *Хүнсний ногоо тариалснаар өөрсдийн хэрэгцээний төмс, сонгиныг үнээр авахгүй болсон*
- *Энэ төсөл хэрэгжсэн нь малчид бидэнд ашиг тустай тариа ногоо тэжээлийн ургамал тарих бүрэн боломж бүрдсэн малчид бидэнд үр өгөөжөө өгсөн төсөл болсонд баяртай байна.*





#### 4. “ЯВУУЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БАЯНДАЛАЙ  
СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

ИРГЭН Ж.МӨНХ-ЭРДЭНЭ

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

16,000,000 төгрөг



#### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- 2020 оны жилийн эцсийн байдлаар Баяндалай сум нь албан ёсны бүртгэлтэй 2100 хүн амтай, засаг захиргааны анхан шатны нэгж болсон 3 багтай сум юм. Мөн тус сум нь аймгийн төв Даланзадгадаас Ноён, Сэврэй, Гурвантэс сум чиглэлийн төв засмал замын дагуу байршилтайгаас шалтгаалан орон нутгийн иргэд, уул уурхайн ажилчид, гадаад дотоодын аялагч гэх мэт дайран өнгөрөх зорчигч харьцангуй олонтой байдаг нь COVID-19 цар тахалтай өнөөгийн нөхцөлд тэднийг сумын төв рүү оруулалгүй түр пост ажиллуулан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, хяналт тавих, иргэдээс шинжилгээ авах зэргээр халдвар хамгааллыг баримтлах зайлшгүй шаардлага тулгардаг. Мөн хүн, малын халдварт өвчлөлийн дэгдэлттэй нөхцөлд малчдад төрийн үйлчилгээг хүртээмжтэй, цаг алдалгүй хүргэхэд хүндрэлтэй байдаг.





*Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

### **ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:**

- Баяндалай сумын ЗДТГ газар нь төрийн үйлчилгээ болон цар тахлын нөхцөл байдлын үеийн тусламжийг иргэд, малчдад түргэн шуурхай хүргэж тэдэнд төрийн үйлчилгээг чанартай хүргэх, эрүүл мэндийг нь хамгаалахад дэмжлэг болох

### **ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:**

- Баяндалай сумын ЗДТГ-т нэг ширхэг чирдэг чингэлэг нийлүүлсэн.

### **ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:**

- Баяндалай сумын ЗДТГ явуулын үйлчилгээ явуулахад зориулан тохижуулсан чингэлэгтэй болсон.
- Төрийн албан хаагчдын явуулын үйлчилгээ явуулах орчин нөхцөл сайжирсан.
- Иргэд, малчдад хүргэх төрийн үйлчилгээний хүртээмж дээшлэхэд дэмжлэг болсон.

## **Сэтгэгдэл** **Баяндалай сумын ЗДТГ-ын дарга Д.Энхтөр:**

*“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр хэрэгжсэн “Явуулын үйлчилгээ” төслөөр нийлүүлэгдсэн явуулын чингэлгийг ашиглан эрүүл мэндийн төвтэй хамтран малчдадаа эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ явуулж байгаагаас гадна Ковид-19 цар тахлын хөл хорионы үед эргүүл постын байр болгон ашиглаж байгаа. Энэ нь төрийн албан хаагчдад ая тухтай ажиллах нөхцөл бүрдүүлж байгаагаас гадна болон сумын ард иргэд, малчдад төрийн үйлчилгээг хүргэхэд маш их ач холбогдол өгч байна.*







## 2021 ОНД МАНДАЛ-ОВОО СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨТӨЛБӨР:

### 1. “ЭМНЭЛГИЙН ЭРСДЭЛГҮЙ ОРЧИН” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МАНДАЛ-ОВОО  
СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

“АЛТАН МУФТЬ” ХХК

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

19,900,000 төгрөг



#### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- 2019 онд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр Мандал-Овоо сумын 10 ортой эрүүл мэндийн төвийн барилга баригдан ашиглалтад орсон бөгөөд тухайн үед суманд төвлөрсөн цэвэр, бохир усны шугам сүлжээ тавигдаагүй байсан тул уг барилгын бохир ус зайлуулах асуудлыг цооног ухан шийдвэрлэсэн юм. Гэтэл энэ цооног нь сар хүрэхгүй хугацаанд дүүрч, бохир усыг соруулж зайлуулах асуудал байнга тулгарч, эмнэлгийн үйл ажиллагааны хэвийн байдал алдагдахад хүрч хүндрэл үүсгэж байна. Мөн 2020 онд тус сум бохир усны төвлөрсөн шугам сүлжээтэй болсон тул эрүүл мэндийн төвийн барилгыг сумын бохир усны төвлөрсөн шугам сүлжээнд холбох бүрэн боломжтой болсон.



### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Эрүүл мэндийн төвийн барилгыг сумын бохир усны төвлөрсөн шугам сүлжээнд холбож эрүүл мэндийн ажил, үйлчилгээний тав тухтай орчин бүрдүүлэн эмнэлгийн халдвар хамгааллын дэглэм сайжруулах, эрсдэл бууруулах, эмнэлгээр үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх.

### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Мандал-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн барилгын бохир ус зайлуулах шугамыг /120м, 4 худагтай/ сумын төвлөрсөн ариутгах татуургын сүлжээнд холбосон.

### ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Сумын эрүүл мэндийн үйлчилгээний чанар дээшлэхэд дэмжлэг болсон.
- Эрүүл мэндийн төвийн халдвар хамгааллын дэглэм сайжирч эрсдэл буурна.
- Эмнэлгийн ажилчдын ажиллах таатай орчин бүрдсэн.
- Эмнэлгийн ашиглалтын зардал буурахад дэмжлэг болсон.

## СЭТГЭГДЭЛ **Мандал-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч Д.Адьяасүрэн:**



Манай эрүүл мэндийн төв нь 2019 оны 9 сард шинэ эмнэлэгтэй болсон боловч цэвэр бохирын төв шугамд холбогдоогүй байсан. Энэ нь үйлчлүүлэгчдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэхэд хүндрэлтэй байсан. Мөн манай эмнэлгийн барилга 2 давхар учир ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, жирэмсэн эмэгтэйчүүд гарч бие засахаас эхлээд хэцүү байсан, цар тахалтай энэ үед стандартын шаардлага хангаагүй гэдэг утгаараа эмнэлгийн тусламж үйлчилгээ хангалтгүй байсан. Одоо бүх шүршүүр болон ариун цэврийн өрөөний хэрэгслүүд хэвийн ажиллаж байгаа тул эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх ая тухтай орчин нөхцөл бүрдсэнд баяртай байна.



## 2. “ИРГЭДИЙН ОРОЛЦОО-НУТГИЙН ХӨГЖИЛ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МАНДАЛ-ОВОО  
СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

“ЭНГҮҮН ОЧИР КОНСТРАКШН” ХХК

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

48,790,000 төгрөг



### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь сум орон нутгийн хөгжлийн бодлого чиглэлийг тодорхойлж, түүний хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг иргэний төлөөллийн байгууллага тул үйл ажиллагаандаа иргэдийн оролцоог хангаж тэдний санал хүсэлтийг шийдвэр гаргах, хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа тусгах, уулзалт ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулах, иргэдийн хууль эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, сургалт мэдээлэл зохион байгуулах хэрэгцээ шаардлага өндөр байдаг.

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Иргэний танхимыг тохижуулж, тоног төхөөрөмжөөр хангаж, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах, мэдээ мэдээллээр хангах, цахим болон танхимаар сургалт хэлэлцүүлэг зохион байгуулах орчин үеийн нөхцөл боломж бүрдүүлэх

### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Мандал-Овоо сумын ЗДТГ-т 102 ширхэг тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл нийлүүлж иргэний танхимын ханыг дуу намсгагч эсгий хавтангаар доторлосон.





*Итгэцлэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

### **ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:**

- Мандал-Овоо сумын ЗДТГ-ын иргэний танхим цахим болон танхимын сургалт, хэлэлцүүлэг явуулах тоног төхөөрөмжөөр хангагдсан.
- Иргэдийг алдаршуулах, алдартнуудын гавьяа, түүхийг сурталчлах, тэднээс суралцах боломж бүрдсэн.
- Иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ дээшилнэ.
- Иргэд тав тухтай орчин нөхцөлд санал бодлоо илэрхийлэх, уулзалт ярилцлага хийх боломж бүрдсэн.
- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.

### **Сэтгэгдэл** Мандал-Овоо сумын ИТХ-ын дарга Ц.Санжаа:



*“Товийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн квотын санхүүжилтээр Иргэний танхимыг тохижуулах «Иргэний оролцоо-Нутгийн хөгжил» төслийг хэрэгжүүлснээр цахим хурал, сургалт арга хэмжээг зохион байгуулах боломж нөхцөл бүрэн бүрдлээ. Энэ нь одоогийн цар тахлын нөхцөл байдалд орон зай харгалзахгүйгээр мэдээ мэдээлэл солилцох, мэдээлэл түгээх, иргэдийн санал бодлыг сонсож үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх өргөн ач холбогдолтой байна. Сум орон нутаг, иргэдийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулдаг Оюу толгой компани, “Товийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн хамт олондоо баярлалаа. Та бүхний үйлс өөдрөг байх болтугай.*



### 3. “СТАНДАРТАД НИЙЦСЭН СОЁЛТОЙ ҮЙЛЧИЛГЭЭ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МАНДАЛ-ОВОО  
СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

“МОНГОЛЫН МЕНЕЖМЕНТИЙН  
ЗӨВЛӨХҮҮДИЙН ХОЛБОО” ТББ

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

5,000,000 төгрөг



#### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Ард иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй, чанартай хүргэх, төрийн үйлчилгээнд чанарын менежментийн тогтолцооны олон улсын стандартыг хэрэгжүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх зорилго зорилтыг улс, аймгийн хэмжээнд дэвшүүлж байгаа өнөөгийн нөхцөлд сумын ЗДТГ нь төрийн үйлчилгээндээ энэхүү стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх нь чухал юм. Иймд сумын ЗДТГ-т олон улсын стандартыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн байгууллагаас зөвлөх үйлчилгээ авах, мэргэжлийн байгууллагаар баталгаажуулалт хийлгэх шаардлагатай байсан.



*Итгэлийг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Мандал-Овоо сумын ЗДТГ нь төрийн үйлчилгээндээ олон улсын стандартыг нэвтрүүлж орон нутгийн ард иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх, мэдээлэх, үйлчилгээний тав тухтай орчин нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зорилготой.

### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Мандал-Овоо сумын ЗДТГ-т ISO9001:2015 олон улсын стандартыг нэвтрүүлж гэрчилгээжүүлсэн.

### ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Хэрэглэгчийн сэтгэл ханамж тасралтгүй өсөн нэмэгдэнэ.
- Мэдээллийн ил тод байдал хангагдана.
- Төрийн албан хаагчдын харилцаа хандлага, ажлын уялдаа холбоо сайжирна..
- Иргэд төрийн үйлчилгээг тав тухтай орчин нөхцөлөөс авах боломж бүрдэнэ.
- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.

## СЭТГЭГДЭЛ **Мандал-Овоо сумын ЗДТГ-ын дарга Д.Адилбиш:**

*Чанарын менежментийн тогтолцооны ISO9001:2015 стандартыг “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн дэмжлэгтэйгээр сумынхаа ЗДТГ-т хэрэгжүүллээ. Энэхүү стандартыг хэрэгжүүлснээр төрийн үйлчилгээний чанар хүртээмж, төрийн албан хаагчдын харилцаа хандлагыг сайжруулж, үүний үр дүнд иргэдийн сэтгэл ханамж нэмэгдэх боломж нөхцөл бүрдэнэ. Олон нийт үр шимийг нь хүртэх бидний үйл ажиллагааг үргэлж дэмжиж байдаг “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн хамт олондоо баярлалаа. Ажлын улам их амжилт хүсье.*







## 2021 ОНД СЭВРЭЙ СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨТӨЛБӨР:

### 1. “ТҮРГЭН ТУСЛАМЖ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СЭВРЭЙ СУМЫН ЗДТГ

“САНГИЙН ДАЛАЙ ЭНЕРЖИ” ХХК

63,000,000 төгрөг



#### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Сэврэй сум нь хойд талаараа Их бага Богдын уулс, дунд хэсэг нь Гурван сайхан уулс, Өмнөд хэсэг нь Алтайн өвөр говийн тойрогт хамаардаг бөгөөд сумын нутаг дэвсгэр нь өндөр уулс, гүвээ толгод, тэгш тал, элсэн манхан, хотгор хоолой хосолсон шинжтэй боловч ихэнх хэсгийг нь уулс эзэлдэг онцлогтой. Дээрх нутаг дэвсгэрийн онцлогоос хамааран сумын ихэнх газар нутгаар элс, ус шавар, уул хад зэрэг бартаат зам ихтэй, сумын төвөөсөө алслагдсан айл өрх олонтой буюу сумын хамгийн захын айлд 180км явж хүрдэг. Сумын эрүүл мэндийн төв нь хөдөөгийн дуудлагадаа үйлчилдэг нэг фургон машинтай боловч уг машины эдэлгээний хугацаа дуусаж эвдэрсэн. Иймд хөдөөгийн дуудлагаар үйлчлэхэд шаардлага хангасан найдвартай, туулах чадвар сайтай автомашин худалдан авах шаардлагатай байсан.



*Итгэцээг суурин сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

### **ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:**

- Сумын төвөөс алслагдсан иргэд, малчдад эмнэлгийн тусламж, үйлчилгээг цаг алдалгүй, түргэн шуурхай хүргэх

### **ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:**

- Сэврэй сумын Эрүүл мэндийн төвд Land cruiser 105 авто машин нийлүүлсэн.

### **ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:**

- Сумын төвөөс алслагдсан иргэд, малчид эмнэлгийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй авдаг болоход дэмжлэг болсон.
- Анхан шатны тусламж үйлчилгээг цаг алдалгүй хүргэж чадвал ард иргэдэд учрах эрсдэл тэр хэмжээгээр буурах боломжтой.
- Туулах чадвар сайтай түргэн тусламжийн автомашинтай болсноор байгалийн хүчин зүйлээс шалтгаалсан замын саатал багасна.

## **СЭТГЭГДЭЛ | Сэврэй сумын Бүйлсэн багийн малчин Ё.Бүд:**

*Манай сум нь газар нутгийн хувьд элс, бартаа ихтэй уулархаг нутагтай. Хөдөөгийн малчид бид эмнэлгийн яаралтай тусламж авахад хугацаа алдах эрсдэл өндөр байдаг. Энэ жил “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-аас санхүүжүүлэн хэрэгжүүлсэн төслийн хүрээнд сумын эрүүл мэндийн төв туулах чадвар сайтай түргэний машинтай болсонд үйлчлүүлэгч бидний зүгээс баяртай байна. Эрүүл мэндийн төв маань эмнэлгийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж дархлаажуулалт, дуудлага, гэрийн эргэлтийг улирал бүр хийж малчид бидэнд зөвлөгөө үйлчилгээг тасралтгүй үзүүлж байна. “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн хамт олон болон сумын эмнэлгийн хамт олонд ажлын өндөр амжилт хүсье.*







## 2. “ЭМИЙН САН” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:  
ГҮЙЦЭТГЭГЧ:  
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СЭВРЭЙ СУМЫН ЗДТГ  
“НӨРӨӨТГОВЬ” ОНӨААТҮГ  
15,600,000 төгрөг**



### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Сэврэй сум нь 600 гаруй өрхтэй бөгөөд үүний 70 орчим хувийг малчин өрх эзэлдэг. COVID-19 цар тахлын жилүүдэд сумын төв рүү орж, гарах иргэдийн хөдөлгөөнийг тодорхой хугацаагаар үе үе хязгаарладаг мөн сүүлийн жилд сумын ихэнх нутгаар хур бороо муу орж малчид өөр сумдын нутгаар отор нүүдэл хийн сумын төвөөс алслагдмал байгаа нь иргэд, малчид яаралтай үед хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийн хүрэлцээ дутмаг, тусламж авахад цаг хугацаа алдах эрсдэл өндөр байсан.

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Сумын өрх бүрийг эмийн санжуулж COVID-19 цар тахлаас шалтгаалсан хөл хорионд орсон иргэд болон отор нүүдэл хийж сумын төвөөс алслагдсан малчдад эрүүл мэндийн, эмийн анхан шатны тусламж үйлчилгээг цаг алдалгүй түргэн шуурхай хүргэхэд дэмжлэг болох

### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Сэврэй сумын 624 өрхийг 19 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл бүхий өрхийн эмийн сангаар хангасан.

### ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Сумын төвөөс алслагдсан иргэд, малчид эмнэлгийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй авдаг болоход дэмжлэг болсон.
- Анхан шатны тусламж үйлчилгээг цаг алдалгүй хүргэж чадвал ард иргэдэд учрах эрсдэл тэр хэмжээгээр буурах боломжтой.





*Итгэцээг суурьлсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## **СЭТГЭГДЭЛ** Сэврэй сумын Сайншанд багийн иргэн Л.Тогоо:



*“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн хөрөнгө оруулалтаар “Эмийн сан” төсөл хэрэгжсэн нь сүүлийн жилүүдэд КОВИД-19 цар тахлын хорио цээр ихтэй, хур бороо ховор байснаас отор нүүдэл хийж сумын төвөөсөө алслагдмал байгаа бидэнд эмийн болон эмнэлгийн анхан шатны тусламжийг цаг алдалгүй гэртээ авч болох баялаг эмийн сантай болгосонд сэтгэл хангалуун байна.*



### 3. “АХМАДЫН СУРГААЛ АЛТ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СЭВРЭЙ СУМЫН ЗДТГ

“СЭВРЭЙН ХӨГЖИЛ” ТББ

7,490,000 төгрөг



#### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Сэврэй сумын ахмадын хороо 1992 онд байгуулагдаж эдүгээг хүртэл тасралтгүй үйл ажиллагаа явуулан ахмадуудынхаа эрүүл мэнд, эрх ашиг, нийгмийн баталгааг хангахад тодорхой хувь нэмрээ оруулан ажиллаж байна. Одоогоор тус ахмадын хороонд 60-аас дээш насны 112 ахмад бүртгэлтэй байдаг бөгөөд цаашид сумынхаа ахмад настнуудын ажил хөдөлмөрийн амжилт, түүхэн гавьяа, залууст үлгэр дуурайлал болох үйлсийг нь баримтжуулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах үйл ажиллагаа зохион байгуулахаар төслийг санаачилсан.

#### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Ахмад настнуудын ажил хөдөлмөрийн амжилт, түүхэн гавьяаг ирээдүй хойч үед үлгэр дуурайлал болгохоор дүрсжүүлэн хадгалах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах

#### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Сэврэй сумын ахмадын хороонд нэг ширхэг суурин компьютер, хоёр ширхэг зөөврийн компьютер нийлүүлсэн.

#### ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Ахмадууд өөрсдийн ажил хөдөлмөрийн амжилт, түүхэн гавьяагаа ирээдүй хойч үедээ үлгэр дуурайлал болгох зорилгоор сайн сайхан түүхийг дүрсжүүлэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах нөхцөл боломжоор хангагдана.
- Ахмад настайчуудад нийгмийн идэвхтэй эрүүл, сэтгэл хангалуун өөдрөг амьдрах ээлтэй орчин бүрдэнэ.





*Итгэцлэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*



## 2021 ОНД БУЛГАН СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ:

### 1. “УС ТҮГЭЭХ БАЙРНЫ ЦАХИМ ТӨХӨӨРӨМЖ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН ЗДТГ

“КОКС ЗАГ” ОНӨААТҮГ

18,285,000 ₮



#### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Булган суманд 2092 хүн оршин суудаг бөгөөд иргэд сумын төвийн хоёр худгаас ажлын цагуудад ундны усаа авч хэрэглэдэг. Уг худгууд дээр ус түгээгч долоо хоногийн таван өдөр ажлын 8 цагаар ажилладаг. Ус түгээх ажлын цагт багтаж ундны усаа авах шаардлагатай хэрэглэгчдийн бөөгнөрөл, хүлээлт, очер дараалал худаг дээр үүсэх, ажлын цагт багтан ундны усаа авч амжихгүй байх зэрэг хүндрэлүүд бий болж байна.
- Мөн одоо ашиглагдаж байгаа хоёр худгийн гадна тохижилт муу, хамгаалалтын хашаагүй, иргэд ус авахдаа худгийн ойр орчимд ус асгах тохиолдолд дулаан үед шалбааг үүсэж, хүйтэн сэрүүн үед халтиргаа үүсэж унаж бэртэх, ус зөөвөрлөхөд хүндрэл учрах гэх мэт асуудлууд их үүсдэг тул худгийг гадна тохижилтыг сайжруулах шаардлага мөн гарч байна.





### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Булган сумын төвд оршин суудаг 726 өрхийн 2092 иргэний ундны усаа авч үйлчлүүлдэг ус түгээх газрын орчин нөхцөлийг сайжруулна

### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Худгийн гадна 6.2х6.5 метр квадрат талбайг хашаажуулж барилгын гадна талбайг цементлэн цахим картаар үйлчлүүлэх зориулалттай болгон тохижуулж тоног төхөөрөмж суурилуулсан. Мөн гадна гэрэлтүүлэг, хяналтын камер, ус түгээлтийг хянах систем суурилуулснаар иргэдийн эрүүл аюулгүй байдлыг хангаад зогсохгүй сумын удирдах байгууллагад цахим мэдээ, тайлан очих боломжтой болсон.

### ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Иргэд хүссэн үедээ карт ашиглан ундны ус авдаг болсон
- Сумын 726 өрхийн 2092 хүн төслийн үр шимийг хүртэж байна.
- Стандартад нийцсэн ус түгээх газраар үйлчлүүлж сэтгэл ханамж өндөр болсон
- Иргэд цахим худгийн ашиглалтын талаарх сургалтад сууж мэдлэг, мэдээлэлтэй болж соёлтой зөв боловсон үйлчлүүлэх боломж бүрдсэн

## СЭТГЭГДЭЛ **Булган сумын 2-р багийн иргэн П.Нямсүрэн**



*Ухаалаг худаг ашиглалтад орсноор цаг хугацаа хэмнэж, хүссэн үедээ ус авах боломж бүрдсэн нь таатай байна. Мөн ус ил задгай асгарах, ундны усны үргүй зарцуулалт үүсэхээс урьдчилан сэргийлэх, багасах нөхцөл үүссэн. Энэхүү ажлыг хийж гүйцэтгэхэд хөрөнгө санхүүгээр тусалж дэмжсэн “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн хамт олондоо талархаж цаашдын ажилд нь амжилт хүсье.*



*Итгэлийг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## 2. “БУЛГАН МУЗЕЙ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН ЗДТГ

Б.МӨНХ-УНДРАМ

19,571,500 ₮



### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Булган сумын соёлын төвийн дэргэдэх музей 1975 онд сумын клубийн өрөөнд байгуулагдаж үйл ажиллагаа явуулж байсан боловч 1987 онд клуб шатаж музейн үзмэрүүд устаж үгүй болсон. 1991 онд шинэ соёлын төв баригдаж, 2010 онд их засварт орох үед орон нутаг судлах музейд зориулан 2 танхим тохижуулан үзмэр цуглуулж түүхэн олдворын 1 танхим, палеонтологийн олдворын 1 танхимыг дэглэснээр түүх соёлоо хадгалан үлдээх, сурталчлах ажлын хийж гадаад дотоодын жуулчид, сумын иргэдэд үйлчилж байна.
- Музейн 2 танхимд өнөөгийн стандарт шаардлагад нийцсэн үзмэрийн хорго байхгүй, танхимын дотоод засал, тохижилт дутмаг байгаа тул музейн үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэх, сайжруулж өргөжүүлэх хэрэгцээ шаардлага тулгарч байна.

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Булган сумын музейг стандартын дагуу тохижуулан сумын иргэд, гадаад дотоодын жуулчдад сумын түүх соёлтой танилцах боломжийг бүрэн бүрдүүлж, музейн үйл ажиллагааг өргөжүүлэх ажил хийнэ





### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Байгалийн үзэсгэлэнт газар нутгаар явж судалгаа хийн зураг авалтын ажил хийсэн. Самбар, хорго урлаж үзмэрийн самбар хийж байрлуулан ханын зураг зурж музейн үзмэр хийж дэглэсэн. Хөдөлмөрийн баатар Аюурзанын булан, Хөөрхөн дэвсэхийн хийдийн загвар, Гандан хийдэд шавь болж сууж байсан ах дүү гурван ламын булан, лам, ихэс дээдсийн үр удам болон ургийн хөтөлгөө хийх талаар булан байгуулсан. Булган сумын онцлогийг агуулсан булангуудыг байгуулж самбар, хаяг, тавиуруудыг урлан гэрээнд заагаагүй, гэвч сумын музейд шаардлагатай байсан загвар, чихмэл амьтан урлах, чулуун дээрх хадны сүг зурах, гэрэлт самбар байрлуулах гэх мэт ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

### ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Булган сумын соёлын өвийн хадгалалт хамгаалалт сайжирсан
- Орон нутгийн онцлог, баялаг олдворуудыг хамгаалан үр хойчдоо үлдээх боломжтой болсон
- Гадаад дотоодын жуулчид, орон нутгийн 2092 хүн үр шимийг нь хүртэнэ

### Сэтгэгдэл **Булган сумын 4-р багийн иргэн С.Мөнхсайхан**



Булган сум нь Өмнөговь аймагтаа газар тариалан, аялал жуулчлалын 1 дүгээр бүс нутаг боловч Булган сумаар дайран өнгөрөх дотоод, гадаадын аялагч жуулчдад үзүүлэхэд орон нутгийн судлах музей нь хангалтгүй байсан билээ. “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн орон нутгийг судлах музей нь Булган сумын түүх соёл, мал аж ахуй, газар тариалан, байгаль орчин аялал жуулчлал, Булган сумын 9 гайхамигийг бодит болгож хийсэн нь сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид мөн нийт ард иргэд, гадаад дотоодын аялагчдад үзэхэд үзүүштэй сайхан болсон байна.





*Итгэлийг суурьлсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

### 3. “ХҮРТЭЭМЖТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ТОХИЖИЛТ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН ЗДТГ**

**ШАЛГАРУУЛЖ БАЙНА**

**35,000,000 ₮**



#### **ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:**

- Булган сумын нутгийн удирдлагын ордны иргэн угтаж авах, мэдээлэл авах хэсэг, дотоод тохижилт төрийн үйлчилгээ үзүүлэхэд тохиромж муутай, олон өнгө хэлбэр хэмжээ бүхий оновчтой бус зохион байгуулалттай, иргэд хүссэн мэдээллээ авахад ойлгомжгүй, учир дутагдалтай байгаагаас гадна төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцөл өнөөгийн шаардлагад нийцэхгүй, төрийн үйлчилгээг чанар хүртээмжтэй хүргэхэд хүндрэл учруулж байна. Тиймээс зарим нэг өрөө танхимын тохижилтыг өөрчилж, мэдээлэл авах хэсэг, хурал цуглаан зохион байгуулан өрөө танхимыг шинэчлэн сайжруулах шаардлагатай байна.

#### **ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:**

- Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж иргэдийн уулзалт, цуглаан зохион байгуулах өрөө танхимыг тохижуулж төрийн алба хаагчдын ажиллах тав тухтай орчныг бүрдүүлэн сумын иргэд, цаашлаад гадаад дотоодын зочдод мэдээллээ түгээх булан байгуулах



#### **ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:**

- Булган сумын нутгийн удирдлагын ордны угтах үйлчилгээний заал, зарим өрөө, танхимыг тохижуулж, гэрэлтүүлэг, мэдээллийн самбар байршуулж, самбаруудын өнгө, хэлбэр хэмжээг жигд болгох, төрийн үйлчилгээг иргэдэд ойрхон болгохуйц тохижилтын ажил хийнэ.

#### **ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:**

- Сумын иргэд төрийн үйлчилгээг тав тухтай орчноос шуурхай авдаг болно
- Төрийн алба хаагчдын ажиллах орчин нөхцөл сайжирч, иргэд шаардлагатай мэдээллийг мэдээллийн самбаруудаас цаг алдалгүй хүлээн авдаг болно.



*Итгэцээг сууринсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*



## 2021 ОНД ЦОГТ-ОВОО СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ:

### 1. “БИД ӨНӨӨДРИЙН УНШИГЧ-МАРГААШИЙН МАНЛАЙЛАГЧИД” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН  
ЦОГТ-ОВОО СУМЫН ЗДТГ**

ГҮЙЦЭТГЭГЧ:

**“БӨХ ДҮҮРЭН” ХХК**

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

**9,864,000 ₮**



#### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Цогт-Овоо сумын ерөнхий боловсролын сургууль 2020-2021 оны хичээлийн жилд 272 сурагч, 33 багш ажилчинтай үйл ажиллагаа явуулж байна. 2005 онд БСШУЯ-аас бага ангийн сурагчдад зориулсан READ төсөл хэрэгжиж, нийлүүлэгдсэн номууд хуучирч урагдаж, сургуулийн номын сан ширээ сандлын хүрэлцээ муутайгаас шалтгаалан сурагчид хүссэн үедээ номын санд суух боломж дутмаг байна.
- Цогт-Овоо суманд 320 хүүхдийн суудалтай шинэ сургууль ашиглалтад орох ба уншлагын танхим 24 хүүхдийн суудалтай байх юм. Бид шинэ сургуульдаа номын фондтой байх бөгөөд уг номын санг тохижуулахдаа цахим номын сан болгон тохижуулах хүсэлтэй байгаа юм.





### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Цогт-Овоо сумын сургуулийн сурагчдыг номтой нөхөрлүүлэх, ном унших орчин нөхцөлийг бүрдүүлж, мөн 5-6 насны хүүхдүүдэд зориулсан “Бяцхан номын сан” байгуулна.

### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Номын санг цахим бүртгэлтэй болгож, номын тавиур, уншлагын ширээ сандал, хөлтэй самбар, бичиг хэргийн шүүгээтэй болгож сурагчдыг номын санд ном уншингаа чөлөөт цагаа өнгөрөөх боломжийг бүрдүүлнэ. Цаашлаад олуулаа цуглаж ном унших, ном уншлагын клубын үйл ажиллагааг өргөжүүлж, ном унших өдөр бий болгож хүүхдүүдийг идэвхжүүлж байна.

### ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Цогт-Овоо сумын сургуулийн 327 сурагч, тэдгээрийн эцэг эх үр шимийг хүртэж байна
- Номын амт клубын үйл ажиллагаа өргөжнө

## Сэтгэгдэл:

#### Цогт-Овоо сумын ЕБС-ийн бага ангийн багш А.Оюунтөгс:



“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр манай сургуулийн номын санд төсөл хөтөлбөр хэрэгжин орчин нөхцөл нь сайжирч байгаад маш их баяртай байна. Хүүхдүүд маань чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлж, ном унших, хичээл давтлага хийх, ном уншигчийн клубын үйл ажиллагаагаа явуулах зэрэг олон талт ажлуудыг зохион байгуулах таатай нөхцөл бүрдэж байгаа нь говь нутгийн ирээдүй болсон хүүхэд багачуудын минь хөгжлийн үндэс суурь болох юм. Тус төслийг санхүүжүүлсэн ГОХДС-ийн хамт олон, төслийг дэмжин ажилласан Цогт-Овоо сумын Засаг дарга Н.Наранзаяа, болон ЗДТГ-ын хамт олонд баярласнаа илэрхийлье.

#### Цогт-Овоо сумын ЕБС-ийн 76 ангийн сурагч О.Энхжаргал:



Бидний орох дуртай Номын сангийн уншлагын танхимыг гоё тохижуулж өгсөн ах, эгч нартаа баярлалаа. Хүүхдүүд бид ном уншиж, найз нартаа уншсан номоо ярьж өгдөг, бас хичээлээ давтдаг. Жил бүр болдог Номын баяраа сэтгэл догдлон хүлээж оролцдог. Бид улам их хичээж, Монголоо төдийгүй дэлхийд нэрээ гаргасан алдартай хүн болноо.



Итгэцлэгд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

## 2. “ЗӨӨВРИЙН ХЯНАЛТЫН СУУЦ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН  
ЦОГТ-ОВОО СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

Ю.БОЛДБААТАР

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

19,500,000 ₮



### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Цогт-Овоо сум нь 1986 хүн амтай, нийт 580 өрх байгаагаас 380 нь малчин өрх байдаг бөгөөд 137 мянган толгой малтай сум юм. Тиймээс ч хөдөө аж ахуйдаа түшиглэн сумын иргэдийн амьдрал ахуй мал, амьтантай салшгүй холбоотой байдаг. Малын гоц халдварт өвчин гарах, ариутгал халдваргүйжүүлэлт хийх, хорио цээр, онцгой байдал, байгаль цаг уурын хүнд хэцүү үе гэх мэт нөхцөл байдал гарахад зөөврийн ариутгал халдваргүйжүүлэлтийн сууц зайлшгүй шаардлагатай байдаг.

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, онц ноцтой болон гамшгийн үед иргэдэд шаардлагатай үйлчилгээг үзүүлэх, өвчний үед иргэдэд, мөн малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ариутгал, халдваргүйжүүлэлт хийх зөөврийн сууц нийлүүлэх

### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- 6 метрийн урт, зөөвөрлөх боломжтой, бүрэн тоноглогдсон зөөврийн сууц нийлүүлсэн.



### ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Постоңд гарах албан хаагчдын ажиллах орчин нөхцөл сайжирсан
- Сумын 1923 иргэн, 380 малчин өрхийн 657 иргэн ашиг ашиг шимийг хүртэж байна
- Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, явуулын үйлчилгээ шаардлагатай болсон малчид үр шимийг хүртэж байна

### Сэтгэгдэл Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч Т.Энхтуяа



“Зөөврийн сууц”-ны төсөл хэрэгжсэнээр бусад аймаг, сумдад тархаад байгаа малын гоц болон халдварт өвчнийг сумын нутаг дэвсгэрт нэвтрүүлэхгүй суурин болон хөдөлгөөнт эргүүл, хяналт шалгалтын постыг гаргаж хүн, мал амьтан, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ариутгал халдваргүйжүүлэлт хийж ажиллахад зөөврийн сууцаар хангагдсанаар тухайн нөхцөлд ажиллах албан хаагчдын ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлж өгсөн “Говийн оюу хөгжлийг дэмжих сан-ийн хамт олонд талархаж байна.





*Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

### 3. “ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ЗӨӨЛӨН ЭДЛЭЛ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН  
ЦОГТ-ОВОО СУМЫН ЗДТГ**

ГҮЙЦЭТГЭГЧ:

**“БУРЯТ-ОМБОЛ” ХХК**

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

**6,849,400 ₮**



#### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Цогт-Овоо сумын эрүүл мэндийн төв 2009 онд ашиглалтад орсон бөгөөд одоогоор 88.9%-ийн хүний нөөц, 65.8%-ийн багаж тоног төхөөрөмжийн хангалттай үйл ажиллагаа явуулж байна. “Ковид-19” цар тахал гарсантай холбогдуулан хоёр гуравдугаар шатлалын эмнэлгүүдэд ирэх ачаалал ихсэж өрхийн эмнэлгүүд халдвар авсан хүмүүсийг эмчилж эхэлсэн.
- Цогт-Овоо сумын улаан бүсийн эмнэлгийг сургуулийн дотуур байранд байршуулан ажилласан. Түүнтэй холбоотой эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх, эмийн нөөц бүрдүүлэх хэрэгтэй байгаа тул шаардлагатай эдлэл хэрэгсэл, эм бэлдмэлийг нийлүүлэх шаардлага гарсан.



### **ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:**

- Цогт-Овоо сумын эрүүл мэндийн төв, өрхийн эмнэлгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, шаардлагатай эдлэл хэрэгсэл, эм бэлдмэлийн хангамжийг нэмэгдүүлэх

### **ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:**

- Цогт-Овоо сумын эрүүл мэндийн төвд шаардлагатай 12 төрлийн 140 ширхэг эдлэл хэрэгсэл, эм бэлдмэл, бараа материал нийлүүлсэн.

### **ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:**

- Цогт-Овоо сумын 1896 суурин хүн ам болон суманд зорчиж ирсэн 2800 гаруй хүмүүс үр шимийг хүртэж эрүүл саруул байна.
- Эрүүл мэндийн төвийн 20 эмч, сувилагч, ажилчдын ажлыг хөнгөвчлөхөд тус нэмэр болсон.

## **СЭТГЭГДЭЛ** Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Х.Гүнжлхам

*“Цогт-Овоо сумын ЭМТ-д “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр зөөлөн эдлэл, тоног төхөөрөмж нийлүүлсэн нь дэлхий нийтийг цочроосон Ковид-19 цар тахлын үед улаан бүсийн эмнэлэгт нэн шаардлагатай дэмжлэг болсон бөгөөд иргэд цэвэр орчинд эмчлүүлэх боломж бүрдсэн. Нутаг орныхоо иргэдийн эрүүл мэндийн төлөө үргэлж сайн үйлс бүтээж, дэмжиж байдаг “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн хамт олонд чин сэтгэлээсээ баярлалаа. Цаашидын ажилд нь өндөр амжилт хүсье.*



*Итгэцээд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

#### 4. “ЭРҮҮЛ МАЛ-ЭРҮҮЛ ХҮНС” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН  
ЦОГТ-ОВОО СУМЫН ЗДТГ**

ГҮЙЦЭТГЭГЧ:

**“ЦОГТ-ОВОО НУТАГ” ХХК**

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

**44,500,000 ₮**



#### **ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:**

- Цогт-Овоо сум нь 1986 хүн амтай, 137 мянган толгой малтай сум юм. Малын гоц халдварт өвчин гарах, хүн малын дунд халдварт өвчин дэгдэх тохиолдолд халдваргүйжүүлэлт хийх зориулалтын тоног төхөөрөмж, машин техник зайлшгүй шаардлагатай байдаг.

#### **ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:**

- Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, онц ноцтой болон гамшгийн үед иргэдэд шаардлагатай үйлчилгээг үзүүлэх, өвчний үед иргэдэд, мөн малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ариутгал хийх зориулалтын шүршигчтэй автомашин нийлүүлэх

#### **ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:**

- Ариутгал хийх зориулалтын тоноглол бүхий автомашин нийлүүлсэн





### ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Постоңд гарах албан хаагчдын ажиллах орчин нөхцөл сайжирсан
- Сумын 1923 иргэн, 380 малчин өрхийн 657 иргэн ашиг шимийг хүртэнэ
- Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, явуулын үйлчилгээ шаардлагатай болсон малчид үр шимийг хүртэнэ

### Сэтгэгдэл

“Говийн эрдэнэ”-мал эмнэлэг үйлчилгээний нэгжийн захирал малын их эмч Р.Байгалмаа



Халдварт, паразиттай өвчин гарах, тархах шалтгаан нөхцөлийг хязгаарлан, эрүүлжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж, халдварт, паразит өвчингүй тайван, угаалга, ариутгал, халдваргүйтгэлийн арга хэмжээг цогцоор авч хэрэгжүүлснээр халдварын голомтыг таслан зогсооно. Мал сүрэг эрүүлжсэнээр малын тарга хүч сайжирч, гарах ашиг ишм нэмэгдэж хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангах, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай “Мал угаалгын дүк” автомашины санхүүжилтийг шийдвэрлэсэнд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн хамт олонд талархаж байна



*Итгэцлэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*



## 2021 ОНД НОМГОН СУМАНД КВОТЫН САНХҮҮЖИЛТЭЭР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТЭСЭЛ:

### 1. “БАЯНБУЛАГ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ” ТЭСЭЛ

ЗАХИАЛАГЧ:


ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТЭСӨВ:

**НОМГОН СУМЫН ЗДТГ**

**НОМГОН СУМЫН ИРГЭН Н.ТУНГАЛАГ**

**15,000,000 төгрөг**



ГОВИЙН ОЮУ  
ХӨГЖЛИЙГ  
ДЭМЖИХ САН

### ТЭСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Өмнөговь аймгийн Номгон сум нь мал сүргийн тоогоороо аймагтаа тэргүүлдэг. 2020-2021 оны өвөл, хаврыг даван туулахад 15,652 боодол буюу 313 тонн өвс, 115 тонн хорголжин болон хивгэн тэжээлийг татан авч мал сүргээ хамгаалах, малчдаа дэмжих өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг ханган ажилласан.
- Номгон сумын Баянбулагийн 25 га ногооны талбайд тариалан эрхэлдэг ба тус сумын ногоочин иргэд 10 га талбайд хүнсний ногоо тариалдаг. Сумын тамгын газрын эзэмшилд байдаг үлдсэн 15 га талбайд малын тэжээлийн ургамал тариалж улмаар өвөлжилт, хаваржилтад ашиглах малын тэжээл, өвс бэлтгэдэг байсан бөгөөд одоогоор тариалалт хийхгүй уринш хийж байна. 2021 оноос эхлэн уг талбайд малын тэжээлийн ургамал тариалахаар болсон ч шаардлагатай техник хэрэгслийн дутагдлаас шалтгаалан тариалангийн ажил хойшлоод байсан. Тиймээс уг талбайд тариалалт хийхэд шаардлагатай техник хэрэгслийг нийлүүлэх хэрэгцээ шаардлага үүсээд байна.

### ТЭСЛИЙН ЗОРИЛГО:

- Ган зудыг хохирол багатай даван туулах, малчид олон нийтийн эрх ашгийг дэмжих зорилгоор Баянбулагийн тариалангийн 15 га талбайд малын тэжээлийн ургамал тариалалтын ажлыг хийхэд шаардагдах тоног төхөөрөмжийг худалдан авна.



### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Төслийн хүрээнд 90 морины хүчтэй бага оврын трактор, анжис, үр тариа үрлэгч, хадуур зэрэг төхөөрөмжүүдийг нийлүүлнэ.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Номгон сумын газар тариалангийн бүрэн техник хэрэгсэлтэй болсноор сум, орон нутаг өөрийн өвс тэжээлийн нөөцийг бүрдүүлэх, тэжээлийн ургамлаа тариалан, цаашид малчид ган зудыг хохирол багатай даван туулна.


### СЭТГЭГДЭЛ **Номгон сумын хөдөө аж ахуйн мэргэжилтэн Ч.Номин-Эрдэнэ:**

Өмнөговь аймгийн Номгон суманд малын тэжээлийн ургамал тариалахад зориулагдсан тоног төхөөрөмжтэй болсноор хөдөлмөр хөнгөвчлөгдөж урьд онуудад 4га-гаас хэтрэхгүй тариалалт хийгдэж 40-50 тн ургац авдаг байсан. Сумын нөөцийн өвсийг Дорнод аймгаас 8-р сард гэрээ хийж 1 боодол өвсийг 5000 төгрөгөөр авдаг ч замын зардал ороод Номгон суманд ирэхэд 13.0-15.0 мянган төгрөгийн өвсийг авч нөөц бүрдүүлдэг байсан. Энэхүү тоног төхөөрөмжтэй болсноор газар тариалан эрхлэгчдийн гар аргаар үрсэлгээгээ хийж гар хадуураар хадлангаа хадаж цаг хугацаа алдаж хадлангаа бүрэн авч чаддаггүй гэх мэтийн олон ажлыг хөнгөвчилж энэ оноос 15 га-д тариалалт хийгдэж ургацын хэмжээ нэмэгдэж 704 малчин өрхийн зохих хувийг өвс хадлангаар ханган сумын нөөцийн өвс хадлангийн зохих хувийг замын зардалгүйгээр хямд өртөг багатай нөөц бүрдүүлж байна.



ҮР ШИМ ХҮРТЭГЧИД ЯРЬЖ БАЙНА

# “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙН ДЭМЖИХ САНДАА БАЯРЛАЛАА, ТАЛАРХЛАА



ДУЛААНД ХОЛБОГДОЖ СУМАНДАА САЙХАН АМЬДАРЧ БАЙНА

Мавлай сумын Далай багийн иргэн Д.СУМЬЯА

ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САНДАА БАЯРЛАЛАА



Даланаадгал сумын 4 дүгээр багийн иргэн М.МӨНХЗАЯА

ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САНДАА БАЯРЛАЛАА



Мавлай сумын ЕБС-ийн 5Б ангийн сурагч Х.МӨНХЗҮЛ

ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САНДАА БАЯРЛАЛАА




Би шинэ сургуульд сурч эхэлсэн



Сангийн цахим хуудсанд тогтмол  
мэдээлэл байршуулж байна

[www.goviinoyu.mn](http://www.goviinoyu.mn)



Жил бүрийн үйл  
ажиллагааны тайлан,  
бусад танилцуулгыг  
товхимол байдлаар  
6000 хувь хэвлүүлэн  
олон нийтэд  
тайлагнаж байна



“Говийн Оюу хөгжлийг  
дэмжих сан”-ийн Фэйсбүүк  
пэйжээр 126 удаагийн  
постоор давхардсан  
тоогоор 186,540 хүнд  
мэдээлэл хүргэж  
ажилласан

# САНГИЙН ИЛ ТОД БАЙДАЛ



Орон нутгийн  
болон үндэсний  
сонинд Сангийн  
санхүүжилтээр  
хэрэгжиж байгаа  
төсөл хөтөлбөрийн  
талаар мэдээлэл  
нийтэлж байна



Жил бүр хөндлөнгийн  
аудитын үйлчилгээ  
авч байна. 2021 онд  
Грант Торнтон аудитын  
компанитай хамтран  
ажилласан

Хөрөнгө оруулагч  
Оюу толгой компани, Хамтын  
ажиллагааны гэрээний  
талууд болох Өмнөговь  
аймгийн ЗДТГ, Ханбогд  
сумын ЗДТГ-тай албан бичиг,  
имэйл, уулзалт зохион  
байгуулах замаар мэдээлэл  
солилцож байна



Даланзадгад сумын  
төвийн зарын  
самбарууд дээр  
Сангийн тухай мэдээлэл  
байршуулж байна



*Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## САНГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

### ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- Сангийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний журмыг 2018 оны 03 сарын 15-ны өдөр Удирдах зөвлөлөөс баталсан бөгөөд Сан нь уг журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байна.
- Хяналт-шинжилгээ, үнэлгээний журмын зорилго нь Говийн оюу хөгжлийн дэмжих сангийн Санхүүжилтийн удирдамж, Сангийн дүрэм болон Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд ХДС-аас санхүүжилтийн дэмжлэг олгохоор батлагдсан төсөл хөтөлбөрүүдийн хөрөнгө оруулагч, санхүүжүүлэгч, санаачлан удирдагч, хэрэгжүүлэгч, холбогдох орон нутгийн төр захиргааны байгууллагууд болон төслийн үр шим хүртэгчдийн зүгээс төсөл хөтөлбөрүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хэрэгжиж дууссан төсөл хөтөлбөрийн хаалт, төсөл хөтөлбөрт эрсдэлийн үнэлгээ хийх үйл ажиллагааг зохицуулахад оршиж байна.
- Сангийн хяналт-шинжилгээ үнэлгээний ажилд дараах оролцогч талууд оролцоно.
  - Хөрөнгө оруулагч-Оюу толгой ХХК
  - Санхүүжүүлэгч байгууллага- Говийн оюу хөгжлийг дэмжих сан
  - Захиалагч- Хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангаж хэрэгжиж дууссанаас хойш үйл ажиллагааг авч явах/хариуцах иргэн/байгууллага
  - Гүйцэтгэгч/Хэрэгжүүлэгч- Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж байгаа иргэн/байгууллага
  - Шууд болон шууд бус үр шим хүртэгч- Өмнөговь аймгийн иргэд/байгууллага
  - Үнэлгээний байгууллага/хувь хүн- Бие даасан үнэлгээ, судалгааны байгууллага/хувь хүн

### ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

БҮРЭН ХЭРЭГГИЖ АРХИВТ БҮРТГЭСЭН 181 ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

ХЭРЭГГИЖ БАЙГАА 115 ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ШАТАНД БАЙГАА 8 ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

### ХЭРЭГГИЖ БАЙГАА ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

Сангийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийг хүлээн авахаас эхлэн хаах хүртэлх бүх үе шатанд хяналт тавьж захиалагч, ашиглагч, гүйцэтгэгч болон үр шим хүртэгчтэй харилцаа холбоотой хамтран ажиллаж байна.





## ҮЕ ШАТНЫ ХЯНАЛТ



### НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

#### Ашиглалттай холбоотой мэдээлэл

- 2015-2021 оны хооронд 52 тэрбум төгрөгийн төсөв бүхий 53 нийгмийн дэд бүтцийн шинж чанартай төсөл хэрэгжүүлж байна.
- 8 төсөл хэрэгжилтийн шатанд байна. Тендерийн шатнаас эхлээд 60 хүртэлх хувийн гүйцэтгэлтэй байна.
  - Даланзадгад сумын 1200 хүүхдийн сургуулийн барилга
  - Даланзадгад сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга
  - Гашуун сухайт боомтын хяналтын камераар тоноглогдсон цамхагт харуулын байрны барилга
  - Цогт-Овоо сумын эрүүл мэндийн төвийн барилга



- Даланзадгад сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил
- Дата төв байгуулах техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, зах зээлийн судалгааны ажил
- Эко жорлон
- Нутгийн үйлдвэрлэгч

### **Иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангах тухайд**

- **Урьд нь байсан нөөц бололцоо, нөхцөл байдал сайжруулж, багтаамжийг нэмэгдүүлсэн-21 төсөл**
  - 2015 онд Даланзадгад сумын 25, 26-р цэцэрлэгийн барилга барьж 400 хүүхэд цэцэрлэгт шинээр хамрагдаж боломжтой болсон
  - 2016 онд Баян-Овоо сумын 10 ортой эмнэлгийн барилга барьж хүчин чадал нэмэгдүүлсэн
  - 2016 онд Ханбогд сумын сургууль цэцэрлэгийн цогцолборын барилга барьж 840 хүүхэд сургууль цэцэрлэгт хамрагдсан
  - 2016 онд Даланзадгад сумын 2-р сургуулийн спорт заалны барилга барьж 764 хүүхэд спортоор хүссэн цагтаа хичээллэх болсон
  - 2017 онд Ханбогд болон Манлай сумдын уурын зуухны хүчин чадлыг ихэсгэн халаалтыг 140%-аар нэмэгдүүлсэн
  - 2017 онд Даланзадгад сумын 11-р цэцэрлэгийг өргөтгөж нэмэлтээр 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга барьсан
  - 2018 онд Мандал-Овоо сумын эрүүл мэндийн төвийн барилга баригдаж хүртээмж нэмэгдсэн
  - Ханбогд сумын цэцэрлэгт анги танхим тохижуулж 2 ангид шинээр хүүхэд элсүүлэн хамруулсан
  - Баяндалай сумын усан халаагуурын тогоо, тоног төхөөрөмжийг шинэчилсэн
  - 2019 онд Баян-Овоо суманд уурын зуухыг шинээр барьж ашиглалтад оруулснаар хүчин чадал 3 дахин өсөж, одоогийн байдлаар хэрэглэгчдийн тоо 24% аар өссөн
  - 2019 онд Манлай сумын цэцэрлэгийн барилга барьж 100 хүүхэд шинээр цэцэрлэгт хамрагдсан
  - 2019 онд Ханбогд суманд цахилгаан шугамын өргөтгөл хийсэн
  - 2020 онд Даланзадгад сумын төвөөс зайтай гэр хороололд 1200 хүүхдийн сургуулийн барилга барьж байна
  - 2020 онд Даланзадгад сумын төвөөс зайтай гэр хороололд 200 хүүхдийн цэцэрлэг барьж байна
  - 2021 онд Мандал-Овоо сумын эрүүл мэндийн төвийн бохир ус зайлуулах шугамыг төвлөрсөн сүлжээнд холбож эрүүл мэндийн төвийн ашиглалтын нөхцөлийг сайжруулсан
  - 2021 онд Өмнөговь аймгийн музейн барилга ашиглалтад орж музейн олдворын хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдал сайжирсан
  - 2021 онд Цогт-Овоо суманд 15 ортой эрүүл мэндийн төвийн барилга барьж байна



- **Иргэдэд үзүүлэх шинэ, сайжруулсан үйлчилгээг нэвтрүүлсэн -32 төсөл**
  - 2017 онд Баян-Овоо сургуулийн дотуур байрны зураг төсөл, 2018 онд Манлай сумын эрүүл мэндийн төвийн барилгын зураг төсөл
  - 2017 онд Даланзадгад сумын төвийг ус зайлуулах шугамтай болгосон
  - 2017 онд Гашуун сухайт боомтын ус цэвэршүүлэх байгууламж, Нийтийн тээврийн үйлчилгээ, Ханбогд сумын сургуулийн нийтийн ариун цэврийн барилгыг барьж ашиглалтад оруулж, Гашуун сухайт боомт орчмын хүмүүсийг шүүж цэвэршүүлсэн усны нөөцтэй болгож, Ханбогд, Манлай сумдыг хоногийн 24 цаг дулаан байж болохуйц халаалттай болгон, Даланзадгад сумын иргэдийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ сайжирсан.
  - 2018 онд Ханбогд суманд Сум дундын малын эрүүл мэндийн төвийг барьж ашиглалтад оруулж, малын эмч нарыг бэлтгэж байгаа бөгөөд Даланзадгад сумын төвийн хэсэгт ус зайлуулах шугам тавьсан.
  - 2019 онд Ханбогд суманд үерийн далан, сувгийн ажил, Ханбогд суманд өвс тэжээлийн агуулах барьсан, Ханбогд суманд цахилгаан шугамын өргөтгөл хийж тариаланчид цахилгааны эх үүсвэрт холбогдсон
  - 2019 онд Өмнөговь аймагт махны үйлдвэрийн барилга барьж, чанартай мах, махан бүтээгдэхүүнээр Өмнөговь аймгийн иргэдийн хүнсний хангамж чанар сайжирсан
  - 2019 онд Баяндалай, Номгон сум, 2020 онд Булган суманд нэгдсэн гудамжны гэрэлтүүлгийн ажил хийсэн
  - 2021 онд Гашуун сухайт боомтын камераар тоноглогдсон цамхагт харуулын байр барьж эхэлсэн
  - 2021 онд Даланзадгад сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Дата төвийн зураг төслийн ажил хийсэн
  - 2021 онд Даланзадгад сумын үйлдвэрлэлийн бүсэд цахилгаан шугам тавих ажил хийж эхэлсэн

### **Асуудал/Зөвлөмж**

- Барилгын ажил гүйцэтгэх хугацааг тооцож, тендерийг төлөвлөж шуурхай зарлан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж шийдвэрлэж байх.
- Зураг төслийн гүйцэтгэлийн чанарт анхаарах, холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллах



# Ашиглалтад орсон нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийн ашиглалт

№	Төслийн нэр	Ерөнхий мэдээлэл				ОГ-и хөрөнгө оруулалт				Ашиглалтын үзүүлэлт				Биеэлтийг хэмжих үзүүлэлт			
		Ашиглалтад орсон огноо	Ашиглагч	Захиалагч	Байгууллагын төрөл	Төсөв	Эх үүсвэр	Санхүүжилт ( )	Даац багтаамж	2019 оны байдлаарх ашиглалт	Хувь	Асуудал	Үзүүлэлт	Төлсөөс өмнөх үзүүлэлт	2019 оны үзүүлэлт	Өөрчлөлт	Бий болсон/болж ажлын байр
1	ДЭ 25-р цэцэрлэг	2016	ДЭ 25-р цэцэрлэг	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	1,8 тэрбум	200	327	100%	байхгүй	Хамрагдсан хүүхдийн тоо	0	327	+9%	31
2	ДЭ 26-р цэцэрлэг	2016	ДЭ 26-р цэцэрлэг	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	2,2 тэрбум	200	288	100%	байхгүй	Хамрагдсан хүүхдийн тоо	0	288	+35%	34
3	БО ЭМТ	2017	БО эрүүл мэндийн төв	Орон нутаг	Ашгийн	Орлогоор санхүүждэг	ХДС	1,1 тэрбум	10 ортой	15 ортой	100%	байхгүй	Эмчлүүлж буй өвчний тоо	10	15	+50%	
4	ДЭ 2-р сургуулийн заал	2017	ДЭ 2-р сургууль	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	796,9 сая	768	830	100%	байхгүй	Байгууламжийг ашиглаж байгаа хүүхдийн тоо	0	830	+8%	-
5	Манлай сумын уурын зуух (3.2 МВт)	2017	Манлай сумын уурын зуух	Орон нутаг	Ашгийн	Орлогоор санхүүждэг	ХДС	929,1 сая	3.2МВ (2 зуух тус бүр 1.6МВ)	3.2МВ (2 зуух)	100%	байхгүй	Халаалтанд холбогдсон байгууламжийн тоо	5 барилга	29628М2 5 барилга, 67 өрх	+100%	8
6	Ханбогд сумын уурын зуух (1.8 МВт)	2017	Хандиель ХХК	Орон нутаг	Ашгийн	Орлогоор санхүүждэг	ХДС, Сумын ЗДТТ	365,7 сая	5МВ (3 зуух тус бүр 1.8МВ)	1.8МВ (1 зуух)	100%	байхгүй	Халаалтанд холбогдсон байгууламжийн тоо	6 барилга (38000М3)	10 барилга	+40%	6
7	ХБ сумын сургуулийн бие засах газар	2017	ХБ сумын сургууль	Орон нутаг	Ашгийн бус	Орон нутгийн төсөвт	ХДС	391,6 сая	9	9	100%	байхгүй	Бие засах газар ашиглаж буй сургагчийн тоо	0	9	+7%	-

8	Ханбогд сумын сургууль цэцэрлэгийн цогцлолбор	2018	Ханбогд сумын сургууль, цэцэрлэг	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	7.2 тэрбум	360 сурагч 300 хүүхэд	1070 сурагч	100%	байхгүй	Хамрагдсан хүүхдийн тоо	660	1070	+127%	92
9	Сум дундын малын эрүүл мэндийн төв	2018	Мал аж ахуй харуусан нэгж	Улсын	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	1.4 тэрбум	4 тасгай, бүрэн тоноглогдсон малын ЭМТ	100%	байхгүй	Үйлчилгээ үзүүлж буй тасгийн тоо	0	4	+100%	5	
10	ДЗ сумын төвийн ус зайлуулах шугам	2018	ӨМ ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	Орон нутгийн төсөвт	ХДС, ӨМ ЗДТГ	2.7 тэрбум	Даланзадгад сумын төвд 6.5 км ус зайлуулах шугам татсан	100%	байхгүй	Ус зайлуулах шугамын урт	0	6.5 км	+100%	-	
11	ДЗ 1-р цэцэрлэгийн өргөтгөл	2018	ДЗ сумын 11-р цэцэрлэг	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	1.4 тэрбум	100 хүүхэд	273	байхгүй	Хамрагдсан хүүхдийн тоо	0	273	273	7	
12	Мах жижиглэн ангилах, жямны үйлдвэр	2019	Гүйд Рүүт Итер Трейдинг	Орон нутаг	Ашгийн	Орлогоорсан хүүхэнэ	ХДС, Гүйд Рүүт Итер Трейдинг	48 тэрбум	3000м <sup>2</sup> 2 давхар үйлдвэрийн барилга, 400 тонн мах хадгалах агуулах	100%	байхгүй	Мах боловсруулах, хадгалах хэмжээ	0	400тн	400тн	25	
13	Жаргалтай хүүхдүүд	2018	Ханбогд сумын цэцэрлэг	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	14.5 сая	24 хүүхдийн 2 анги	100%	байхгүй	Хамрагдсан хүүхдийн тоо	0	24	20%	5	
14	Усан халаагуурын тогоо, тоног төхөөрөмж	2018	Баяндай сумын уурын зуух	Орон нутаг	Ашгийн	Орлогоор санхүүждэг	ХДС, Орон нутаг	ХДС 69.4 сая	1400 кв хүчин чадалтай 1 зуух	100%	байхгүй	Халаалтанд холбогдсон байгууламжийн тоо	5	байгуула-га, 23 айл өрх	+100%		
15	Соёл спортын хөгжил	2018	Манлай ЗДТГ	Орон нутаг	Ашгийн	Орлогоор санхүүждэг	ХДС	58.6 сая	Орчин нөхцөл сайжруулсан	100%	байхгүй	Ашиглалт сайжирсан			+100%		
16	Булган 5 цэцэрлэгийн гадна тохижилт	2018	Булган цэцэрлэг	Орон нутаг	Ашгийн бус	орон нутгийн төсөвт	ХДС	37.9 сая	Орчин нөхцөл сайжруулсан	100%	байхгүй	Ашиглалт сайжирсан			+100%		
17	Сэврай зүүн байрны спорт талбай	2018	Сэврай ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	орон нутгийн төсөвт	ХДС		Орчин нөхцөл сайжруулсан	100%	байхгүй	Ашиглалт сайжирсан			+100%		

# Ашиглалтад орсон нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийн ашиглалт

18	Цэцэрлэгт хүрээлэн байгуулах	2018	Номгон ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	56 сая	Олон нийтийн амралт, зугаалтын газар	100%	байхгүй	Амьдрах орчин нөхцөл сайжирсан	+100%	
19	Баяндалай хүүхдийн тоглоомын талбайн тохижилт	2019	Баяндалай ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	орон нутгийн төсөвт	ХДС	23.4 сая	Орчин нөхцөл сайжруулсан	100%	байхгүй	Ашиглалт сайжирсан	+100%	
20	Баян-Овоо сумын уурын зуух (2 МВт)	2019	7 шар цаг ОНӨТҮГ	Орон нутаг	Ашгийн	Орлогоор санхүүждэг	ХДС	901.8 сая	4МВ (2 зуух тус бүр 2МВ)	100%	байхгүй	Халаалтанд холбогдсон байгууламжийн тоо	36 айл өрх, 12 байгууллага	+17%
21	Манлай сумын цэцэрлэг, тоног төхөөрөмж	2019	Манлай сумын цэцэрлэг	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	1,7 тэрбум	100 хүүхдийн цэцэрлэг	100%	байхгүй	Хамрагдсан хүүхдийн тоо	100	+100%
22	Баяндалай гэрэлтүүлгийн ажил	2019	Баяндалай ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	52.9 сая	60 ш гудамжны гэрэлтүүлэг, 5 ш цамхагт гэрэлтүүлэг	100%	байхгүй	Суурилуулсан гэрлийн тоо	0	+100%
23	Гэрлэн дохио	2019	Даланзадгад ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	70 сая	Уулзварын 4 ш гэрлэн дохио	100%	байхгүй	Суурилуулсан гэрлэн дохионы тоо	0	+100%
24	Цогт-Овоо замын тэмдэг	2019	Цогт-Овоо ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	орон нутгийн төсөвт	ХДС	9.6 сая	Орчин нөхцөл сайжруулсан	100%	байхгүй	Орчин нөхцөл сайжруулсан	+100%	
25	Булган тохилог орчин	2019	Булган ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	орон нутгийн төсөвт	ХДС	33.9 сая	Орчин нөхцөл сайжруулсан	100%	байхгүй	Орчин нөхцөл сайжруулсан	+100%	
26	Булган жишиг гудамж	2019	Булган ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	орон нутгийн төсөвт	ХДС	27.5 сая	Орчин нөхцөл сайжруулсан	100%	байхгүй	Орчин нөхцөл сайжруулсан	+100%	
27	Мандал-Овоо сумын эрүүл мэндийн төв	2019	Мандал-Овоо эмнэлэг	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	1.2 тэрбум	10 ортой эрүүл мэндийн төвийн барилга	100%	байхгүй	ЭМТ-ийн орны тоо	0	100%



28	Ханбогд сумын өвс тэжээлийн агуулах	2020	Ханбогд сумын ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	370.1 сая	Өвс тэжээл агуулах байр	100%	байхгүй	Өвс тэжээл хадгалах хэмжээ	0	7500м3	100%
29	Ханбогд сумын цахилгаан шугамын өргөтгөл	2020	Ханбогд сумын ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	50 сая	Цахилгааны шугам татсан	100%	байхгүй	Дулаанд холбогдсон айлын тоо	0	278 иргэн	100%
30	Ханбогд сумын хог хаягдлын менежмент	2020	Ханбогд сумын ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	591.4 сая	Хог хаягдал булшлах байгууламж	100%	байхгүй	Хог булшлах хүчин чадал	0	21,120м3	100%
31	Ханбогд сумын үерийн далан, суваг	2020	Ханбогд сумын ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	1.3 тэрбум	Үерийн далан, сувгийн ажил	100%	байхгүй	Үерийн далангийн урт	0	1.5 км	100%
32	Хөрс эрдэнэ	2018	Баян-Овоо сумын ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	104.5 сая	Цахилгааны шугам татсан	100%	байхгүй	Хог булшлах хүчин чадал	0	3.2 км	100%
33	Номгон гэрэлтүүлэг	2019	Номгон сумын ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	орон нутгийн төсөвт	ХДС	30 сая	6 ш цамхагт гэрэлтүүлэг	100%	байхгүй	Суурилуулсан гэрлийн тоо	0	6	100%
34	Манлай биеийн тамирын талбайн томжилт	2020	Манлай ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	орон нутгийн төсөвт	ХДС	56.7 сая	Орчин нөхцөл сайжруулсан	100%	байхгүй	Орчин нөхцөл сайжруулсан	100%		
35	Даланзадгад Аюулгүй орчин-амьдралын баталгаа	2020	Даланзадгад ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	орон нутгийн төсөвт	ХДС	36 сая	Орчин нөхцөл сайжруулсан	100%	байхгүй	Орчин нөхцөл сайжруулсан	100%		
36	Нэгдсэн гудамжны гэрэлтүүлэг	2020	Булган сумын ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	орон нутгийн төсөвт	ХДС	39.5 сая	Гудамжны гэрэлтүүлэг	100%	байхгүй	Суурилуулсан гэрлийн тоо	0	13	100%
37	Амгалан орчин	2020	Баяндай сумын ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	орон нутгийн төсөвт	ХДС	38.2 сая	Цахилгааны шугам татсан	100%	байхгүй	10кв цахилгаан шугам	0	620 м	100%
38	Эмнэлгийн эрсдэлгүй орчин	2021	Мандаг-Овоо ЭМТ	Орон нутаг	Ашгийн бус	Орон нутгийн төсөвт	ХДС	19.9 сая	Орчин нөхцөл сайжруулсан	100%	байхгүй	Орчин нөхцөл сайжруулсан	100%		



## ХАРИЛЦАГЧ БАЙГУУЛЛАГУУД-2021

№	ХАРИЛЦАГЧ БАЙГУУЛЛАГЫН НЭР	ХОЛБОО ХАМААРАЛ
1	Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газар	Хамтын ажиллагааны гэрээний нэг тал
2	Ханбогд сумын Засаг даргын тамгын газар	Хамтын ажиллагааны гэрээний нэг тал, түншлэгч сум
3	Оюу толгой ХХК	Хамтын ажиллагааны гэрээний нэг тал, хөрөнгө оруулагч байгууллага
4	Даланзадгад сумын Засаг даргын тамгын газар	Даланзадгад суманд хэрэгжиж байгаа төслүүдийн захиалагч, түншлэгч сум, квотын санхүүжилт хүлээн авсан сум
5	Манлай сумын Засаг даргын тамгын газар	Манлай суманд хэрэгжиж байгаа төслүүдийн захиалагч, түншлэгч сум, квотын санхүүжилт хүлээн авсан сум
6	Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газар	Баян-Овоо суманд хэрэгжиж байгаа төслүүдийн захиалагч, түншлэгч сум, квотын санхүүжилт хүлээн авсан сум
7	Баяндалай сумын Засаг даргын тамгын газар	Баяндалай суманд хэрэгжиж байгаа төслүүдийн захиалагч, уул уурхайгүй сум, квотын санхүүжилт хүлээн авсан сум
8	Сэврэй сумын Засаг даргын тамгын газар	Сэврэй суманд хэрэгжиж байгаа төслүүдийн захиалагч, уул уурхайгүй сум, квотын санхүүжилт хүлээн авсан сум
9	Номгон сумын Засаг даргын тамгын газар	Номгон суманд хэрэгжиж байгаа төслүүдийн захиалагч, уул уурхайгүй сум, квотын санхүүжилт хүлээн авсан сум
10	Булган сумын Засаг даргын тамгын газар	Булган суманд хэрэгжиж байгаа төслүүдийн захиалагч, уул уурхайгүй сум, квотын санхүүжилт хүлээн авсан сум
11	Цогт-Овоо сумын Засаг даргын тамгын газар	Цогт-Овоо суманд хэрэгжиж байгаа төслүүдийн захиалагч, уул уурхайгүй сум, квотын санхүүжилт хүлээн авсан сум



12	Мандал-Овоо сумын Засаг даргын тамгын газар	Мандал-Овоо суманд хэрэгжиж байгаа төслүүдийн захиалагч, уул уурхайгүй сум, квотын санхүүжилт хүлээн авсан сум
13	Хүрмэн сумын Засаг даргын тамгын газар	Хүрмэн суманд хэрэгжиж байгаа төслүүдийн захиалагч, уул уурхайгүй сум, квотын санхүүжилт хүлээн авсан сум
14	"Сэврэйн хөгжил" ТББ	"Ахмадын сургаал алт" хөтөлбөрийн гүйцэтгэгч
15	"Нөрөөт говь" ОНӨААТҮГ	"Эмийн сан" хөтөлбөрийн гүйцэтгэгч
16	"Сангийн далай энерги" ХХК	"Түргэн тусламж-2" хөтөлбөрийн гүйцэтгэгч
17	"Алтан муфть" ХХК	"Эмнэлгийн эрсдэлгүй орчин" хөтөлбөрийн гүйцэтгэгч
18	"Монголын менежментийн зөвлөхүүдийн холбоо" ТББ	"Стандартад нийцсэн соёлтой үйлчилгээ" хөтөлбөрийн гүйцэтгэгч
19	А.Гантөмөр	"Цэвэр Манлай" хөтөлбөрийн гүйцэтгэгч
20	Д.Уламбаяр	"Эмнэлгийн хаягдлын менежмент" хөтөлбөрийн гүйцэтгэгч
21	Б.Лхамсүрэн	"Үдийн цайны гал тогооны тоног төхөөрөмж" хөтөлбөрийн гүйцэтгэгч
22	Б.Пэрэнлэймаа	"Малын им, тамга" хөтөлбөрийн гүйцэтгэгч
23	Д.Бүрэнжаргал	"Хөгжмийн боловсрол хүүхдийн ирээдүй" хөтөлбөрийн гүйцэтгэгч
24	Э.Балжирмаа	"Эрүүл эх хүүхэд-Эрүүл Манлай" хөтөлбөрийн гүйцэтгэгч
25	Д.Отгонбат	"Түүх, өв соёл" хөтөлбөрийн гүйцэтгэгч
26	Н.Пунцагболд	"Ахмадын өргөөний гадна тохижилт" хөтөлбөрийн гүйцэтгэгч
27	"Энгүүн очир констракшн" ХХК	"Иргэдийн оролцоо нутгийн хөгжил" хөтөлбөрийн гүйцэтгэгч
28	Кокс заг ОНӨААТҮГ	"Ус түгээх байранд цахим төхөөрөмж суурилуулах" хөтөлбөрийн гүйцэтгэгч
29	"Бөх дүүрэн" ХХК	"Бид өнөөдрийн уншигч-Маргаашийн манлайлагчид" хөтөлбөрийн гүйцэтгэгч
30	Ю.Болдбаатар	"Зөөврийн хяналтын сууц" хөтөлбөрийн гүйцэтгэгч





*Итгэцлэг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

31	“Бурят омбол” ХХК	“Эмнэлгийн тоног төхөөрөмж, зөөлөн эдлэл” хөтөлбөрийн гүйцэтгэгч
32	Б.Мөнх-Ундрэм	“Музейн тохижилт” хөтөлбөрийн гүйцэтгэгч
33	“Цогт-Овоо нутаг” ХХК	“Мал угаалгын автомашин” хөтөлбөрийн гүйцэтгэгч
34	Н.Тунгалаг	“Баянбулаг тоног төхөөрөмж” хөтөлбөрийн гүйцэтгэгч
35	“Дархан төгөлдөр говь” ХХК	“Баян-Овоо говийн төгөл” хөтөлбөрийн гүйцэтгэгч
36	“Эко Баян-Овоо хот тохижилт” ААТҮГ	“Баян-Овоо цэвэр сум” хөтөлбөрийн гүйцэтгэгч
37	“Баянтансаг эрдэнэ” ХХК	“Цэвэр агаар-эрүүл мэнд” хөтөлбөрийн гүйцэтгэгч
38	“Шанх эрдэнэ” ХХК	“Эмнэлгийн түргэн тусламж” хөтөлбөрийн гүйцэтгэгч
39	Б.Баяржаргал	“Далай булаг” хөтөлбөрийн гүйцэтгэгч
40	Б.Ганболд	“Журмын хашаа” хөтөлбөрийн гүйцэтгэгч
41	Д.Оюунбилэг	“Хот айл” хөтөлбөрийн гүйцэтгэгч
42	Ж.Мөнх-Эрдэнэ	“Явуулын үйлчилгээ” хөтөлбөрийн гүйцэтгэгч
43	“Зэмүү говь” ХХК	“Дотуур байр бидний гэр” хөтөлбөрийн гүйцэтгэгч
44	“Софт бюлдинг эффект” ХХК	“Сургалтын таатай орчин” хөтөлбөрийн гүйцэтгэгч
45	“Дүүрэн шаргал элс” ХХК	“Жишиг мал эмнэлгийн үйлчилгээ” хөтөлбөрийн гүйцэтгэгч
46	“Ханбогд хот тохижилт” ОНӨААТҮГ	“Цэмцгэр Ханбогд”, “Сагсан бөмбөг” хөтөлбөрийн гүйцэтгэгч
47	Н.Өлзийбаяр	“Гадна тохижилт” хөтөлбөрийн гүйцэтгэгч
48	М.Мажигсүрэн	“Эрдмийн оргил” хөтөлбөрийн гүйцэтгэгч
49	М.Норовсүрэн	“Ханбогд брэнд багц” хөтөлбөрийн гүйцэтгэгч
50	Д.Нарансүрэн	“Нэг цэг” хөтөлбөрийн гүйцэтгэгч
51	М.Сүглэгмаа	“Малын им тамга” хөтөлбөрийн гүйцэтгэгч
52	Т.Базарсад	“Гар аргаар худаг гаргах” хөтөлбөрийн гүйцэтгэгч
53	Б.Шинэбаяр	“Багт мод тарих” хөтөлбөрийн гүйцэтгэгч
54	Д.Хишигбат	“Баян дэлгэрэх” хөтөлбөрийн гүйцэтгэгч
55	“Эвт цахирал” ХХК	“Цогт-Овоо сумын 15 ортой эрүүл мэндийн төвийн барилга” төслийн гүйцэтгэгч
56	“ММ Архитектур” ХХК	“Даланзадгад сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” төслийн гүйцэтгэгч



57	“Хязгааргүй шулуун” ХХК	“Дата төв байгуулах техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, зах зээлийн судалгаа” төслийн гүйцэтгэгч
58	“Ихэр сайхан уул” ХХК	“Хүүхдийн зуслангийн зоогийн газрын тоног төхөөрөмж” хөтөлбөрийн гүйцэтгэгч
59	“Гранд холдинг” ХХК	“Бэлчээр усжуулалтын 2-р аян” төслийн гүйцэтгэгч
60	“Гранд лайм прожект” ХХК	“Нутгийн үйлдвэрлэгч” хөтөлбөрийн гүйцэтгэгч
61	Хилийн 0131-р цэргийн анги	“Гашуунсухайт боомтын хяналтын камераар тоноглогдсон цамхагт харуулын байр” төслийн гүйцэтгэгч
62	“Ханбогд арвижих” ХХК	“Даланзадгад сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга” төслийн гүйцэтгэгч
63	“Хүннүгийн говь” ХХК	“Даланзадгад сумын 1200 хүүхдийн сургуулийн барилга” төслийн гүйцэтгэгч
64	Нэгдсэн үндэстний байгууллагын Хүн амын сан	“Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих хамтарсан хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэгч байгууллага
65	Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сан	“Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих хамтарсан хөтөлбөр”-ийг хамтран санхүүжүүлэгч байгууллага
66	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага	“Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих хамтарсан хөтөлбөр”-ийг хамтран санхүүжүүлэгч байгууллага
67	Австралийн засгийн газар	“Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих хамтарсан хөтөлбөр”-ийг хамтран санхүүжүүлэгч
68	Монгол улсын засгийн газар	“Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих хамтарсан хөтөлбөр”-ийг хамтран санхүүжүүлэгч
69	Грант Торнтон ХХК	Аудитын үйлчилгээ
70	Интерпрэсс ХХК	Хэвлэлийн үйлчилгээ
71	Сэтгэшгүй хойч ХХК	Хэвлэлийн үйлчилгээ
72	Өнөөдөр сонин	Зар мэдээ нийтлэлийн үйлчилгээ
73	Өдрийн сонин	Хэвлэлийн үйлчилгээ



Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

## САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### БАЛАНС

2021 оны 12-р сарын 31

Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>Хөрөнгө</b>		
<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	7,004,135,735.51	14,142,611,815.71
Богино хугацаат хөрөнгө оруулалт	1,559,255,962.40	2,034,107,443.23
Авлага	1,658.02	0.00
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>8,563,393,355.93</b>	<b>16,176,719,258.94</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
Үндсэн хөрөнгө	75,296,268.00	64,932,568.00
Үндсэн хөрөнгө хуримтлагдсан элэгдэл	22,504,270.61	29,503,028.21
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>52,791,997.39</b>	<b>35,429,539.79</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>8,616,185,353.32</b>	<b>16,212,148,798.73</b>
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө</b>		
Дансны өглөг	2,599,953,769.06	9,968,967,807.06
Цалингийн өглөг	0.72	0.00
<b>Богино хугацаат өглөгийн дүн</b>	<b>2,599,953,769.78</b>	<b>9,968,967,807.06</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>2,599,953,769.78</b>	<b>9,968,967,807.06</b>
<b>Цэвэр хөрөнгө</b>		
Хуримтлагдсан үр дүн	6,016,231,583.54	6,243,180,991.67
<b>Цэвэр хөрөнгийн дүн</b>	<b>6,016,231,583.54</b>	<b>6,243,180,991.67</b>
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгийн дүн</b>	<b>8,616,185,353.32</b>	<b>16,212,148,798.73</b>





## ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31

Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>Үндсэн үйл ажиллагааны орлого</b>		
Бэлэг, хандив, тусламжийн орлого	14,629,916,035.55	16,255,279,171.59
Бусад орлого	503,711,351.45	206,555,041.57
<b>Үйл ажиллагааны орлогын нийт дүн</b>	<b>15,133,627,387.00</b>	<b>16,461,834,213.16</b>
<b>Үндсэн үйл ажиллагааны зардал</b>		
<b>Бэлэг, хандив ба тусламж</b>	<b>322,595,920.00</b>	<b>866,500,000.00</b>
Байгууллагад өгсөн хандив, тусламж	322,595,920.00	866,500,000.00
Хөтөлбөр хэрэгжүүлсний зардал	138,650,022.00	197,437,145.00
Төсөл хэрэгжүүлсний зардал	11,639,467,330.00	14,721,673,235.00
Ерөнхий удирдлагын зардал	599,315,650.29	449,274,425.03
Цалин хөлс, шагнал	202,520,297.92	203,345,610.80
Нийгмийн даатгалын шимтгэл	25,406,237.24	26,336,684.87
Засвар үйлчилгээний зардал	439,500.00	306,498.00
Ашиглалтын зардал	24,973,043.00	15,569,739.00
Түрээсийн зардал	16,988,400.00	16,988,400.00
Албан томилолтын зардал	1,414,258.00	0.00
Элэгдлийн зардал	14,213,073.13	17,765,457.60
Зар сурталчилгааны зардал	218,813,756.25	92,095,137.75
Шуудан, холбооны зардал	5,357,934.60	8,211,911.00
Шатахууны зардал	6,023,546.00	5,272,012.00
Бусад зардал	83,165,604.15	63,382,974.01
<b>Үндсэн үйл ажиллагааны зардлын нийт дүн</b>	<b>12,700,028,922.29</b>	<b>16,234,884,805.03</b>
<b>Үндсэн ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>2,433,598,464.71</b>	<b>226,949,408.13</b>
<b>Үндсэн бус үйл ажиллагааны ашиг, алдагдал</b>	<b>166,503.94</b>	<b>0.00</b>
Бусад	166,503.94	0.00
<b>Тайлант үеийн цэвэр үр дүн</b>	<b>2,433,764,968.65</b>	<b>226,949,408.13</b>



*Итгэцлэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31

№	Үзүүлэлт	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
1	<b>2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>3,582,799,622.77</b>	<b>3,582,799,622.77</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.	0.
3	Залруулсан үлдэгдэл	3,582,799,622.77	3,582,799,622.77
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт/бууралт	0.	0.
5	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт/бууралт	0.	0.
6	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.	0.
7	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.	0.
8	Тайлант үеийн цэвэр үр дүн	2,433,431,960.77	2,433,431,960.77
9	<b>2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>6,016,231,583.54</b>	<b>6,016,231,583.54</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.	0.
11	Залруулсан үлдэгдэл	6,016,231,583.54	6,016,231,583.54
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт/бууралт	0.	0.
13	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт/бууралт	0.	0.
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.	0.
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.	0.
16	Тайлант үеийн цэвэр үр дүн	226,949,408.13	226,949,408.13
17	<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>6,243,180,991.67</b>	<b>6,243,180,991.67</b>



## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31

Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Үйл ажиллагааны мөнгөн орлого</b>	<b>14,761,955,703.06</b>	<b>16,279,996,082.62</b>
Бэлэг, хандив, тусламж	14,616,773,750.00	16,251,900,621.00
Бусад	145,181,953.06	28,095,461.62
<b>Үйл ажиллагааны мөнгөн зарлага (-)</b>	<b>13,193,741,032.92</b>	<b>8,831,582,835.10</b>
Ажиллагчдад олгосон мөнгө	183,750,233.91	166,970,027.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	21,649,672.78	41,601,084.75
Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	0.00	5,933,800.00
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	11,030,889.00	8,277,297.00
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө	12,934,933,675.85	8,589,246,683.75
Төлсөн татвар	42,280,036.38	19,424,242.60
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	96,525.00	129,700.00
<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>1,568,214,670.14</b>	<b>7,448,413,247.52</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Худалдаж авсан урт хугацаат хөрөнгө	0.00	403,000.00
Худалдаж авсан хөрөнгө оруулалт	270,299,000.00	325,071,082.91
<b>Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-270,299,000.00</b>	<b>-325,474,082.91</b>
<b>Санхүү үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Хүү ба урамшууллын орлого	327,432,361.52	15,536,915.59
<b>Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>327,432,361.52</b>	<b>15,536,915.59</b>
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>1,625,348,031.66</b>	<b>7,138,476,080.20</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>5,378,787,703.85</b>	<b>7,004,135,735.51</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>7,004,135,735.51</b>	<b>14,142,611,815.71</b>






ГОВИЙН ОЮУ  
ХӨГЖЛИЙГ  
ДЭМЖИХ САН

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ.*

 Монгол улс, Өмнөговь аймаг,  
Даланзадгад сум, 3-р баг,  
Голомт бизнес төвийн  
4 давхар, 404 тоот

 7053-3576, 7053-3578

 [www.goviinoyu.mn](http://www.goviinoyu.mn)

 [www.facebook.com/GobiOyuDSF](https://www.facebook.com/GobiOyuDSF)